ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

# ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАР

# 2016

Улаанбаатар хот

2017 он

**Танилцуулгыг хянан, тохиосон:**
ҮСХ-ны дарга А.Ариунзаяа
ҮСХ-ны дэд дарга Ч.Баянчимэг
Эдийн засгийн статистикийн газрын дарга Э.Эрдэнэсан

**Танилцуулгыг нэгтгэн боловсруулсан:**
Эдийн засгийн статистикийн газрын ахлах шинжээч Ч.Мөнхтуул,
шинжээч Г.Цэвэлмаа

Хаяг: Засгийн газрын III байр, Бага тойруу-44, Улаанбаатар-11, Монгол Улс
Утас: 326414, 1800-1212
Имэйл: information@nso.mn, Веб хаяг: http://nso.mn, www.1212.mn.

АГУУЛГА

Оршил 11

I. Эдийн засагт хөдөө аж ахуйн салбарын эзлэх байр суурь 12
II. Мал аж ахуй 12
II.1. Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл 12
Мал аж ахуйн бүтээгдэхүүний экспорт 14
Мал аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалт 15
II.2. 2016 оны жилийн эцсийн мал тооллогын дүн 16
II.2.1. Малтай болон малчин өрх, малчид, тэдгээрийн соёл ахуйн үзүүлэлтүүд 16
II.2.2. Мал, тэжээвэр амьтдын тоо, сүргийн бүтэц 18
Малын тоо 18
Малтай өрхийн бүлэглэлт 25
Малчин өрхийн бүлэглэлт 27
Хээлтэгч малын тоо 28
Төл бойжилт 30
Том малын зүй бус хорогдол 33
Хээл хаялт, сувайралт 35
Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо 36
Малын хэрэглээний зарлага 37
Сүргийн бүтэц 38
II.2.3. Эрчимжсэн мал аж ахуй, үүлдрийн болон шилдэг омгийн мал 40
II.2.4. Малын бэлчээр, тэжээлийн хүрэлцээ, хангамж 41
II.2.5. Тэжээвэр амьтад 43
II.2.6. Хашаа, худгийн тооллого 44
II.3. Мал эмнэлгийн үйлчилгээ 45
II.4 Малын индексжүүлсэн даатгал 45

**III. Газар тариалан** 46
III.1. Тариалсан талбай 46
III.2. Газар тариалангийн үйлдвэрлэл, хураасан ургац 49
III.3. Га-гийн ургац 53
III.4. Хөдөө аж ахуйн эдэлбэр газар 54
**Дүгнэлт** 55
**Хавсралтууд**

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл
Хүснэгт 2. Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, биет хэмжээгээр
Хүснэгт 3. Нэг хүнд ногдох мал аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүн
Хүснэгт 4. ХАА-н гаралтай бүтээгдэхүүний экспорт
Хүснэгт 5. Мал аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүний экспорт
Хүснэгт 6. Малын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэл
Хүснэгт 7. Дотоодын үйлдвэрт боловсруулсан малын гаралтай бүтээгдэхүүн
Хүснэгт 8. Өрх малчдын тоо, насны бүтэц
Хүснэгт 9. Малчин өрхийн нийгэм ахуйн зарим үзүүлэлтүүд
Хүснэгт 10. Цахилгаан үүсгүүртэй өрхийн тоо
Хүснэгт 11. Малын тоо, төрлөөр
Хүснэгт 12. Малын тоо, бүсээр
Хүснэгт 13. Малын тоо, бүсээр, төрлөөр
Хүснэгт 14. Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь
Хүснэгт 15. Малын жилийн дундаж тоо толгой
Хүснэгт 16. Өрхийн аж ахуйн малын тоо
Хүснэгт 17. Малтай өрхийн малын бүлэглэлт
Хүснэгт 18. Малтай өрхийн малын бүлэглэлт, бүсээр
Хүснэгт 19. Малтай нэг өрхөд ногдох малын тоо
Хүснэгт 20. Малчин өрхийн малын бүлэглэлт
Хүснэгт 21. Малчин нэг өрхөд ногдох малын тоо
Хүснэгт 22. Хээлтэгч малын тоо
Хүснэгт 23. Сүрэгт хээлтэгч малын эзлэх хувь
Хүснэгт 24. Хээлтэгч малын тоо, бүсээр
Хүснэгт 25. Төллөсөн хээлтэгч малын тоо, бүсээр
Хүснэгт 26. Төл бойжилт
Хүснэгт 27. Бойжуулсан төл, төрлөөр
Хүснэгт 28. Бойжуулсан төл, бүсээр
Хүснэгт 29. 100 эхээс бойжуулсан төл, төрлөөр
Хүснэгт 30. 100 эхээс бойжуулсан төл, бүсээр
Хүснэгт 31. Том малын зүй бус хорогдол
Хүснэгт 32. Том малын зүй бус хорогдол, бүсээр
Хүснэгт 33. Оны эхний малд зүй бус хорогдлын эзлэх хувь
Хүснэгт 34. Оны эхний малд зүй бус хорогдол, бүсээр, төрлөөр
Хүснэгт 35. Өвчнөөр хорогдсон малын тоо, бүсээр
Хүснэгт 36. Гэнэтийн аюулаар хорогдсон малын тоо, төрлөөр
Хүснэгт 36. Гэнэтийн аюулаар хорогдсон малын тоо, бүсээр
Хүснэгт 38. Хээл хаяж, сувайрсан эх малын тоо
Хүснэгт 39. Оны эхэнд байсан хээлтэгч малын тоонд хээл хаясан, сувайрсан малын эзлэх хувь
Хүснэгт 40. Хээл хаяж, сувайрсан эх мал, бүсээр
Хүснэгт 41. Хээлтүүлэгч малын тоо, малын төрлөөр
Хүснэгт 42. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо
Хүснэгт 43. Малын хэрэглээний зарлага, төрлөөр

Хүснэгт 44. Малын хэрэглээний зарлага, бүсээр
Хүснэгт 45. Зах зээлд худалдан борлуулсан болон аж ахуйн дотоодод хэрэглэсэн малын тоо
Хүснэгт 46. Сүргийн бүтэц, 2016 он
Хүснэгт 47. Сүргийн бүтэц, хувиар, малын төрлөөр
Хүснэгт 48. Хээлтүүлэгчээс бусад нас гүйцсэн эр малын өсөлт
Хүснэгт 49. Цэвэр үүлдрийн болон эрлийз нутгийн шилдэг омгийн малын тоо
Хүснэгт 50. Бэлчээрийн хүрэлцээ хангамж
Хүснэгт 51. Бэлтгэсэн тэжээл, нэр төрлөөр
Хүснэгт 52. Бэлтгэсэн тэжээл, бүсээр
Хүснэгт 53. Үйлдвэрлэсэн тэжээлийн хангамж
Хүснэгт 54. Тэжээвэр амьтад, тэдгээрийг өсгөн үржүүлдэг өрхийн тоо
Хүснэгт 55. Тэжээвэр амьтад, бүсээр
Хүснэгт 56. Худаг, усан сангийн тоо
Хүснэгт 57. Малын хашааны тоо, хангамж, тооллого явагдсан оноор
Хүснэгт 58. Мал эмнэлгийн арга хэмжээний мэдээ
Хүснэгт 59. Даатгалд хамрагдсан өрх, малын тоо
Хүснэгт 60. Тариалсан талбай
Хүснэгт 61. Нийт тариалсан талбай бүс, аймаг, нийслэлээр
Хүснэгт 62. Тариалсан талбай, аж ахуйн төрлөөр
Хүснэгт 63. Тариалан эрхэлдэг өрх, аж ахуйн нэгж байгууллагын тоо
Хүснэгт 64. Газар тариалангийн салбарын үйлдвэрлэл
Хүснэгт 65. Хураасан ургац
Хүснэгт 66. Ургац хураалт, зарим онуудаар
Хүснэгт 67. Хураасан ургац, аж ахуйн төрлөөр
Хүснэгт 68. 2016 оны ургац хураалтыг 2015 оныхтой харьцуулсан байдал
Хүснэгт 69. Өрхийн хураасан ургац
Хүснэгт 70. Газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлт
Хүснэгт 71. Дотоодын үйлдвэрлэлийг нийт нийлүүлэлтэд, импортыг дотоодын үйлдвэрлэлд харьцуулсан харьцаа
Хүснэгт 72. Га-гийн ургац
Хүснэгт 73. Хураасан ургац, тариалсан талбай, га-гийн ургацын дээд хэмжээ
Хүснэгт 74. Га-гаас хураасан төмс, хүнсний ногооны ургац, аж ахуйн төрлөөр
Хүснэгт 75. ХАА-н эдэлбэр газар

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. ДНБ-д ХАА-н салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь
Зураг 2. Малчдын тоо, насны бүлгээр
Зураг 3. Нийгэм ахуйн зарим үзүүлэлт, малчин өрхийн тоонд эзлэх хувь
Зураг 4. Нийт малын тоо
Зураг 5. 2016 оны эцэст тоологдсон нийт малын тоо, аймаг, сум
Зураг 6. Нийт сарлагийн тоо
Зураг 7. 2016 оны эцэст тоологдсон нийт хонины малын тоо, аймаг, сум
Зураг 8. 2016 оны эцэст тоологдсон нийт адууны тоо, аймаг, сум
Зураг 9. 2016 оны эцэст тоологдсон нийт үхрийн тоо, аймаг, сум
Зураг 10. 2016 оны эцэст тоологдсон нийт тэмээний тоо, аймаг, сум
Зураг 11. 2016 оны эцэст тоологдсон нийт ямааны тоо, аймаг, сум
Зураг 12. Малтай өрхийн тоо, малын тооны бүлэглэлтээр
Зураг 13. Малчин өрхийн тоо, малын тооны бүлэглэлтээр
Зураг 14. Хээлтэгч малын тоо
Зураг 15. Бойжуулсан төлийн тоо
Зураг 16. 100 эхээс бойжуулсан төл, улсын дундаж
Зураг 17. 100 эхээс бойжуулсан төл, аймгаар
Зураг 18. Том малын зүй бус хорогдол
Зураг 19.100 га бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо
Зураг 20. Бэлтгэсэн хадлан
Зураг 21. Үр тариа, төмс, хүнсний ногооны тариалсан талбай
Зураг 22. Тариалалт, уринш хийсэн талбай
Зураг 23. Хураасан ургац, ургамлын төрлөөр
Зураг 24. Өрхийн хураасан ургац, ургамлын төрлөөр

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| **ААНБ** | Аж ахуйн нэгж, байгууллага |
| **ГЕГ** | Гаалийн Ерөнхий Газар |
| **ДНБ** | Дотоодын нийт бүтээгдэхүүн |
| **МАА** | Мал аж ахуй |
| **МИД** | Малын Индексжүүлсэн Даатгал |
| **ТЕГ** | Татварын Ерөнхий Газар |
| **УЦУОСМХ** | Ус Цаг Уур, Орчны Судалгаа, Мэдээллийн Хүрээлэн |
| **ҮСХ** | Үндэсний Статистикийн хороо |
| **ХАА** | Хөдөө аж ахуй |

## ТЭМДЭГЛЭГЭЭ

* урьдчилсан гүйцэтгэл

## НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

Мал бүхий өрх гэж малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрхийг ойлгоно.

Малчин өрхөд жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа өрхийг хамруулна.

Малтай өрх гэж мал бүхий өрх болон малчин өрхийг хэлнэ.

Малчид гэж жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны мал аж ахуй эрхлэгчдийг ойлгоно.

Бодод шилжүүлэх коэффициент:

1 адуу, үхэр - 1 бод
1 тэмээ - 1.5 бод
6 хонь - 1 бод
8 ямаа - 1 бод

Бодод шилжүүлэх коэффициентийг таван төрлийн малыг нэг төрлийн малд шилжүүлэн малын өсөлт, бууралтыг гаргах, үр ашгийг тооцоход ашиглана.

Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ - 5 хонь
1 адуу - 7 хонь
1 үхэр - 6 хонь
1 хонь - 1 хонь
1 ямаа - 0.9 хонь

Хонин толгойд шилжүүлэх коэффициентийг малын тэжээлийн хүрэлцээ, хангамж, бэлчээрийн даацыг тодорхойлон гаргахад ашиглана.

Нас гүйцсэн малд малын төрөл бүрээр дараах насны малыг хамруулна.

Тэмээ - 4 ба түүнээс дээш настай
Адуу - 3 ба түүнээс дээш настай
Үхэр - 2 ба түүнээс дээш настай
Хонь - Тухайн жилийн төл малаас бусад насны хонь
Ямаа - Тухайн жилийн төл малаас бусад насны ямаа

Өсвөр насны мал

Тэмээ - Өмнөх оны төл, 2, 3 настай
Адуу - Өмнөх оны төл, 2 настай
Үхэр - Өмнөх оны төл
Бог мал - Тухайн жилийн төл малаас бусад насны мал

Төл малд малын төрөл бүрээрх тухайн жилийн төлийг хамруулна.

Бэлэн хээлтэгчид малын төрөл бүрээрх нас гүйцсэн эм малыг хамруулна.

Малын тоо толгойн өсөлт оны эцсийн малаас оны эхний малыг хасаж, малын тооны өөрчлөлтийг тоогоор илэрхийлнэ. Оны эцсийн малын тоог оны эхний малын тоонд харьцуулж өсөлт, бууралтыг хувиар илэрхийлнэ.

Малын өсөлтийн **<u>орлого тал</u>** нь төл бойжилт, **<u>зарлага тал нь</u>** хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол байна.

<u>Төллөлтийн хувь</u> төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулж тооцно.

<u>Төл бойжилтын хувь</u> бойжуулсан төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулж тооцно.

<u>100 эхээс бойжуулсан төл</u> бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулж тооцно.

<u>Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо</u> хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулж тооцно.

1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур - 20-25
Азарга - 12-15
Бух - 35-45
Хуц, ухна - 25-30

<u>Том малын зүй бус хорогдолд</u> өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг хамруулна.

<u>Оны эхний малд том малын зүй бус хорогдлын эзлэх хувь</u> зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулж тооцно.

<u>Малын хэрэглээний зарлага</u> оны эхний мал, бойжуулсан төлийн нийлбэрээс том малын зүй бус хорогдол болон оны эцсийн малын тоог хасаж нийт малын хэрэглээний зарлагыг тооцно.

<u>Малын хашааны хангамж</u> хашааны багтаамжийг малын тоонд харьцуулна. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулж тооцно.

<u>Тэжээл хангамж</u> тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулж тооцно.

<u>Бэлчээрийн даац</u> хонин толгойд шилжүүлсэн малын тоог хадлан, бэлчээрийн талбайн хэмжээнд харьцуулж тооцно.

<u>Тэжээлийн нэгжид шилжүүлэх итгэлцүүр</u> бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Дараах итгэлцүүрийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ:

| Бэлтгэсэн тэжээл | Итгэлцүүр |
|---|---|
| Гар тэжээл, хужир шүү | 1.00 |
| Үр тарианы хаягдал | 0.90 |
| Хадлан өвс | 0.45 |
| Лай | 0.40 |
| Таримал тэжээл | 0.35 |
| Даршны ургамал | 0.25 |
| Сүрэл | 0.25 |
| Төмс ногооны хаягдал | 0.22 |

<u>Малын тэжээлийн ангилал</u> малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

- Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал багтах бөгөөд бүдүүн, хүчит, шүүст гэж ангилна.

    1. Бүдүүн тэжээл - өвс, сүрэл, нэг наст ба олон наст ургамал
    2. Хүчит тэжээл - үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг
    3. Шүүст тэжээл - Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал тус тус орно.

- Амьтны гаралтай тэжээлд яс, цусны гурил зэрэг багтана.
- Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

Тариалангийн талбай хөдөө аж ахуйн таримал ургамлыг тариалсан талбайг хэлнэ. Тариалангийн талбайг тариалсан талбай, хураасан талбай, өнжсөн талбай, уринш боловсруулсан талбай гэж ангилна.

Тариалсан талбай тухайн жилд үр суулгасан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

Хураасан талбай тухайн жилд ургац хурааж авсан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

Га-гийн ургац талбайн нэг нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ бөгөөд га-гийн ургацыг тодорхойлохдоо тухайн төрлийн ургамлын хурааж авсан бүх ургацыг тариалсан талбайн хэмжээнд харьцуулж тооцно.

Нийт ургац тухайн жилд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний хэмжээ, өөрөөр хэлбэл, нийт тариалсан талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техникийн ургамал зэрэг ургамал тус бүрийн төрлөөрх ургацын хэмжээг хэлнэ.

ХАА-н эдийн засгийн бүс 5 бүсэд хувааж, бүс тус бүрд дараах аймаг, нийслэл хамрагдана.

| Бүс | Аймаг/Нийслэл |
|---|---|
| Баруун бүс | Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд, Увс, Завхан аймаг |
| Хангайн бүс | Баянхонгор, Булган, Архангай, Өвөрхангай, Орхон, Хөвсгөл аймаг |
| Төвийн бүс | Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул аймаг |
| Зүүн бүс | Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймаг |
| Улаанбаатар | Улаанбаатар хот |

# ОРШИЛ

Дэлхийн олон улс орнуудын нэгэн адил манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр суурь эзэлдэг салбарын нэг юм.

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад зориулагддаг.

“Монгол Улсын Үндсэн хууль”-нд “Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна” гэж хуульчлан зааж өгсөн байдаг бөгөөд мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

Монгол Улсын ‘’Статистикийн тухай“ хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу Үндэсний Статистикийн хороо мал, тэжээвэр амьтдын тооллогыг 2016 оны 12 дугаар сарын 7-ноос 17-ны өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулж явуулав.

Энэ удаагийн танилцуулгад мал аж ахуй, газар тариалангийн салбарын 2016 оны төлөв байдлыг нэгтгэн, мал тооллогын 2016 оны дүнг нэгтгэн дүгнэснээс гадна мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, голлох нэр төрлийн түүхий эд үйлдвэрлэлийн хэмжээ, тэдгээрийн экспорт, импорт болон мал эмнэлгийн арга хэмжээ, малын хашаа, худаг, уст цэгийн талаарх мэдээллийг тусган оруулав.

Түүнчлэн газар тариалангийн салбарын үндсэн үзүүлэлтүүд болох тариалсан талбай, хураасан ургац, га-гийн ургацын талаарх мэдээллийг 2016 оны жилийн дүнгээр нэгтгэн тусгасан болно.

Танилцуулгад улсын дүн мөн Баруун, Хангай, Төв, Зүүн бүс болон Улаанбаатар гэсэн бүсүүдээр тодорхойлж зэрэгцүүлэлт хийж харуулав.

Манай улсын хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга, судалгааны материал нь суурь мэдээлэл болно гэдэгт итгэж байна.

# I. ЭДИЙН ЗАСАГТ ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

Монгол Улсын Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д 2016 оны байдлаар 12.2 хувь, экспортын орлогын 8.7 хувийг хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспорт бүрдүүлж, нийт ажиллах хүчний 30.4 хувь нь энэ салбарт ажиллаж байна.

ЗУРАГ 1. ДНБ-Д ХАА-Н САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТГИЙН ЭЗЛЭХ ХУВЬ




Салбарын бүтцээр анхдагч салбар буюу хөдөө аж ахуйн салбар, үүний дотор мал аж ахуйн салбар 1999 он хүртэл ДНБ-ий 30-40 орчим хувийг үйлдвэрлэж байсан бол 2000 оноос хойш хөдөө аж ахуйн салбарт учирсан байгалийн гамшиг, үйлчилгээний салбарын өсөлтөөс үүдэн хөдөө аж ахуйн салбарын ДНБ-д эзлэх хувийн жин буурч, улмаар үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын эзлэх хувийн жин өссөөр байна.

Хөдөө аж ахуйн салбар, үүний дотор мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл нь боловсруулах аж үйлдвэрийн салбарын хүнсний бүтээгдэхүүн, нэхмэл эдлэл болон арьс, ширэн эдлэл зэрэг үйлдвэрлэлийн салбарын түүхий эдийг нийлүүлж, боловсруулах салбар болон үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, газар тариалангийн салбар нь хүн амыг аюулгүй, баталгаат хүнсээр хангах үндсэн нөхцөл нь болж байна.

ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа нийт 3539 ААНБ байгаа нь нийт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-д 4.9 хувийг эзэлж байна.

# II. МАЛ АЖ АХУЙ

## II.1 Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл

Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр, оны үнээр 3496.1 тэрбум төгрөг, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2618.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхтой харьцуулахад оны үнээр 6.2 хувь, зэрэгцүүлэх үнээр 1.5 хувиар буурлаа (Хүснэгт 1).

ХҮСНЭГТ 1. МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016* | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тэрбум төг | | | | | хувь | зөрүү |
| Тайлант оны үнээр | 2 114.8 | 2 937.6 | 3 468.4 | 3 728.8 | 3 496.1 | 92.7 | -275.4 |
| 2010 оны зэрэгцүүлэх үнээр | 1 621.0 | 2 018.8 | 2 310.8 | 2 657.5 | 2 618.7 | 98.5 | -38.8 |

Мал аж ахуйн салбарт 2016 онд нядалгааны жингээр 400.0 мянган тонн мах, 891.5 сая литр сүү, 27.4 мянган тонн хонины ноос, 9.4 мянган тонн ноолуур, 1.7 мянган тонн тэмээний ноос, 14.0 сая ширхэг арьс, шир үйлдвэрлэв.

Өмнөх оныхтой харьцуулахад махны үйлдвэрлэл, нядалгааны жингээр 48.3 мянган тонн, арьс, шир 1.2 сая ширхгээр буурч, сүүний үйлдвэрлэл 17.1 сая литр, ноолуур 0.6 мянган тонн, хонины ноос 1.6 мянган тонн, тэмээний ноос 91.1 тонноор нэмэгдсэн байна (Хүснэгт 2).

ХҮСНЭГТ 2. МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, БИЕТ ХЭМЖЭЭГЭЭР

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016* | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хувь | зөрүү |
| **Мах, нядалгааны жингээр, мянган тонн** | **263.4** | **299.3** | **291.7** | **448.3** | **400.0** | **89.2** | **-48.3** |
| Адууны | 31.1 | 29.8 | 29.5 | 50.8 | 41.7 | 82.1 | -9.1 |
| Үхрийн | 59.7 | 57.7 | 54.9 | 93.2 | 92.4 | 99.1 | -0.8 |
| Тэмээний | 5.3 | 6.7 | 6.4 | 8.2 | 6.5 | 79.3 | -1.7 |
| Хонины | 67.2 | 91 | 91.3 | 134.6 | 116.2 | 86.3 | -18.4 |
| Ямааны | 56.3 | 64 | 60.5 | 86.3 | 86.9 | 100.7 | 0.6 |
| **Сүү, сая литр** | **588.0** | **667.0** | **765.4** | **874.4** | **891.5** | **102.0** | **17.1** |
| Гүүний | 55.8 | 65.1 | 75 | 85.1 | 86.2 | 101.3 | 1.1 |
| Үнээний | 337 | 380.6 | 440.4 | 512.4 | 522.4 | 102.0 | 10.0 |
| Ингэний | 8.3 | 7.5 | 9.3 | 9 | 10.2 | 113.3 | 1.2 |
| Хонины | 64.5 | 74.2 | 84.7 | 95.2 | 99.1 | 104.1 | 3.9 |
| Ямааны | 122.4 | 139.5 | 156 | 172.6 | 173.6 | 100.6 | 1.0 |
| **Ноос, ноолуур, тонн** | | | | | | | |
| Тэмээний ноос | 1 079.3 | 1 437.5 | 1 510.5 | 1 643.6 | 1 734.7 | 105.5 | 91.1 |
| Хонины ноос | 17 484.9 | 20 229.2 | 22 318.7 | 25 820.8 | 27 399.8 | 106.1 | 1579 |
| Ямааны ноолуур | 6 325.8 | 7 009.9 | 7 726.9 | 8 857.5 | 9 449.6 | 106.7 | 592.1 |
| **Арьс, шир, мянган ширхэг**** | **8 617.9** | **11 037.9** | **10 217.9** | **15 192.9** | **14 001.2** | **92.2** | **-1 191.7** |
| Тэмээний | 25.7 | 32.7 | 30.5 | 40 | 30.9 | 77.3 | -9.1 |
| Адууны | 238.4 | 247.1 | 235.4 | 397 | 352.7 | 88.8 | -44.3 |
| Үхрийн | 458.6 | 493.2 | 438.8 | 733.1 | 791 | 107.9 | 57.9 |
| Хонины | 3 659.4 | 5 239.4 | 4 979.0 | 7 363.5 | 6 566.6 | 89.2 | -796.9 |
| Ямааны | 3 957.0 | 4 687.2 | 4 323.5 | 6 170.3 | 5 763.8 | 93.4 | -406.5 |

**хурга, ишигний арьс ороод

***<u>Нэг хүнд ногдох мал аж ахуйн бүтээгдэхүүн.</u>*** Нэг хүнд 2016 онд дунджаар 132.1 кг мах, 294.5 л сүү ногдож, өмнөх оныхтой харьцуулахад мах 19.0 кг, сүү 0.5 кг-аар буурсан байна (Хүснэгт 3).

ХҮСНЭГТ 3. НЭГ ХҮНД НОГДОХ МАЛ АЖ АХУЙН ГОЛ НЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016** |
|---|---|---|---|---|---|
| Мах, нядалгааны жингээр, кг | 96.7 | 105.4 | 100.4 | 151.1 | 132.1 |
| Сүү, л | 215.9 | 234.8 | 263.5 | 295 | 294.5 |
| Өндөг, ширхэг | 21 | 22 | 25 | 34 | 39 |

**жилийн дундаж хүнд ногдуулж тооцсоноор

***Мал аж ахуйн бүтээгдэхүүний экспорт.*** Хөдөө аж ахуйн гаралтай гол нэрийн бүтээгдэхүүн, түүхий эдийн экспортоос 2016 онд 428.5 сая ам.доллар буюу нийт экспортын орлогын 8.7 орчим хувийг олсон байна. ХАА-н гаралтай бүтээгдэхүүний нийт экспорт нь өмнөх оноос 12.1 сая ам.доллар буюу 2.9 хувиар өссөн байна.

Мал аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүнээс олсон экспортын орлого 323.1 сая ам.доллар буюу нийт экспортын орлогын 6.6 орчим хувийг эзэлж байна.(Хүснэгт 4).

ХҮСНЭГТ 4. ХАА-Н ГАРАЛТАЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ

| | 2015 | 2016 | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|
| | мянган ам.доллар | | Хувь | Зөрүү |
| **Нийт экспорт - Бүгд** | **4 669 280.5** | **4 917 331.0** | **105.3** | **248 050.5** |
| **ХАА-н гаралтай бүтээгдэхүүн** | **416 427.1** | **428 523.5** | **102.9** | **12 096.4** |
| Мал, амьтад тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн | 26 382.0 | 29 594.7 | 112.2 | 3 212.7 |
| Ургамлын гаралтай бүтээгдэхүүн | 37 844.0 | 55 143.3 | 145.7 | 17 299.3 |
| Мал, амьтан болон ургамлын гаралтай өөх, тос | 71.7 | 700.5 | 976.9 | 628.8 |
| Хүнсний бүтээгдэхүүн | 15 669.3 | 11 945.4 | 76.2 | - 3 723.9 |
| Түүхийн болон боловсруулсан арьс шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл | 33 805.6 | 30 210.4 | 89.4 | - 3 595.2 |
| Нэхмэл, нэхмэлийн бүтээгдэхүүн | 302 654.5 | 300 929.1 | 99.4 | - 1 725.4 |

Эх үүсвэр: Гаалийн Ерөнхий Газар

2016 онд бэлтгэсэн хонины ноосны 51.4 хувь буюу 14.1 мянган тонн, бэлтгэсэн ямааны ноолуурын 57.3 хувь буюу 5.4 мянган тонн бохир ноолуур, адууны ширний 31.4 хувь буюу 0.1 мянган ширхгийг боловсруулалтгүйгээр экспортод гаргасан байна (Хүснэгт 5).

ХҮСНЭГТ 5. МАЛ АЖ АХУЙН ГОЛ НЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ

| | 2012 | | Нэгжийн дундаж үнэ, ам $ | 2013 | | Нэгжийн дундаж үнэ, ам $ | 2014 | | Нэгжийн дундаж үнэ, ам $ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тоо хэмжээ | үнийн дүн, мян.ам $ | | тоо хэмжээ | үнийн дүн, мян.ам $ | | тоо хэмжээ | үнийн дүн, мян.ам $ | |
| **Мах, тонн** | | | | | | | | | |
| Үхрийн хөлдүү | 965.1 | 3 301.3 | 3.4 | - | - | - | 480.0 | 1 590.6 | 3.3 |
| Хонь, ямааны | 675.1 | 1 775.3 | 2.6 | 403.4 | 2 209.3 | 5.6 | - | - | - |
| Адууны | 1 462.1 | 4 765.3 | 3.3 | 2 597.8 | 7 573.0 | 2.9 | 1 822.2 | 4 971.5 | 2.7 |
| Дайвар бүтээгдэхүүн | 821.2 | 511.9 | 0.6 | 790.4 | 1 320.9 | 1.7 | 202.8 | 238.9 | 1.2 |
| **Ноос, ноолуур, тонн** | | | | | | | | | |
| Хонины ноос | 4 494.3 | 5 415.6 | 1.2 | 2 370.4 | 3 006.1 | 1.2 | 7 351.3 | 9 577.8 | 1.3 |
| Бохир ноолуур | 3 597.8 | 145 379.5 | 40.4 | 4 070.3 | 188 819.2 | 46.4 | 4 035.4 | 223 815.4 | 55.5 |
| Самнасан ноолуур | 532.9 | 47 829.9 | 89.8 | 564.5 | 56 081.2 | 99.4 | 636.6 | 61 931.8 | 97.3 |
| Тэмээний ноос | 1 032.3 | 2 609.8 | 2.5 | 991.0 | 2 145.7 | 2.2 | 1 090.1 | 3 560.5 | 3.3 |
| **Шир, мянган ширхэг** | | | | | | | | | |
| Адууны | 196.7 | 2 162.1 | 10.8 | 209.7 | 2 136.2 | 11.7 | 65.4 | 654.0 | 10.0 |
| Үхрийн | 4.0 | 40.0 | 10.0 | 140.5 | 1 969.7 | 14.0 | 174.6 | 2 216.8 | 12.7 |

Хүснэгт 5-ын үргэлжлэл

| | 2015 | | Нэгжийн дундаж үнэ, ам $ | 2016* | | Нэгжийн дундаж үнэ, ам $ |
|---|---|---|---|---|---|---|
| | тоо хэмжээ | үнийн дүн, мян.ам $ | | тоо хэмжээ | үнийн дүн, мян.ам $ | |
| **Мах, тонн** | | | | | | |
| Үхрийн хөлдүү мах | 847.7 | 2 621.9 | 3.1 | 695.1 | 1 592.3 | 2.3 |
| Хонь, ямааны мах | 39.0 | 117.0 | 3.0 | 238.0 | 361.5 | 1.5 |
| Адууны мах | 3 856.9 | 7 318.5 | 1.9 | 7 983.6 | 14 392.6 | 1.8 |
| Дайвар бүтээгдэхүүн | 42.7 | 88.3 | 2.1 | 8.4 | 59.4 | 7.1 |
| **Ноос, ноолуур, тонн** | | | | | | |
| Хонины ноос | 11 450.3 | 13 945.5 | 1.2 | 14 090.6 | 16 356.6 | 1.2 |
| Бохир ноолуур | 4 988.2 | 197 181.0 | 39.5 | 5 413.5 | 192 534.6 | 35.6 |
| Самнасан ноолуур | 558.9 | 40 711.2 | 72.8 | 509.0 | 33 189.1 | 65.2 |
| Тэмээний ноос | 484.9 | 1 599.8 | 3.3 | 818.9 | 2 623.8 | 3.2 |
| **Шир, мянган ширхэг** | | | | | | |
| Адууны шир | 6.2 | 74.4 | 12.0 | 110.9 | 2 447.6 | 22.1 |
| Үхрийн шир | 111.7 | 1 725.0 | 15.5 | 0.0 | 0.0 | 0.0 |

Эх үүсвэр: Гаалийн Ерөнхий Газар

***__Мал аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалт__***. Нийт 2016 онд үйлдвэрлэсэн сүүний 8.0 хувьтай тэнцэх 71.8 сая литр сүүг үйлдвэрийн аргаар боловсруулан шингэн сүү, тараг, бяслаг, аарц, цөцгий зэрэг сүү, сүүн бүтээгдэхүүн дотооддоо үйлдвэрлэсэн байна. Мөн нийт бэлтгэсэн махны 2.3 хувьтай тэнцэх 9.0 мянган тонн махыг дотоодын үйлдвэрүүдэд үйлдвэрийн аргаар боловсруулалт хийж мах, хиам, нөөш зэрэг мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэжээ. Түүнчлэн нийт үйлдвэрлэсэн хонины ноосны 25.5 хувьтай тэнцэх 7.0 мянган тонн угаасан ноос, ноолуурын 8.3 хувьтай тэнцэх 782.1 мянган тонн самнасан ноолуур үйлдвэрийн аргаар бэлтгэсэн байна (Хүснэгт 7).

Улсын хэмжээнд бэлтгэсэн үхрийн ширний 35.3 хувьтай тэнцэх 279.2 мянган ширхэг, хонины арьсны 7.4 хувьтай тэнцэх 489.0 мянган ширхэг, ямааны арьсны 10.4 хувьтай тэнцэх 0.6 сая ширхэг арьс, ширийг тус тус дотоодын үйлдвэрт боловсруулсан байна.

## ХҮСНЭГТ 6. МАЛЫН ГАРАЛТАЙ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ

| | хэмжих нэгж | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016* |
|---|---|---|---|---|---|---|
| Мах | мян.т | 263.4 | 299.3 | 291.7 | 448.3 | 400 |
| Сүү* | мян.л | 588 | 667 | 765.4 | 874.4 | 891.5 |
| Тэмээний ноос | т | 1 079.3 | 1 437.5 | 1 510.5 | 1 643.6 | 1 734.7 |
| Хонины ноос | т | 17 484.9 | 20 229.2 | 22 318.7 | 25 820.8 | 27 399.8 |
| Ямааны ноолуур | | 6 325.8 | 7 009.9 | 7 726.9 | 8 857.5 | 9 449.6 |
| Үхрийн шир | мян.ш | 458.6 | 493.2 | 438.8 | 733.1 | 791.0 |
| Хонины арьс | мян.ш | 3 659.4 | 5 239.4 | 4 979.0 | 7 363.5 | 6 566.6 |
| Ямааны арьс | мян.ш | 3 957.0 | 4 687.2 | 4 323.5 | 6 170.3 | 5 763.8 |

## ХҮСНЭГТ 7. ДОТООДЫН ҮЙЛДВЭРТ БОЛОВСРУУЛСАН МАЛЫН ГАРАЛТАЙ БҮТЭЭГДЭХҮҮН

| | Хэмжих нэгж | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016* |
|---|---|---|---|---|---|---|
| Боловсруулсан мах | мян.т | 13.2 | 19.8 | 16.8 | 12.6 | 9.0 |
| Боловсруулсан сүү** | мян.л | 72 820.2 | 63 942.9 | 71 148.3 | 70 349.6 | 71 763.0 |
| Боловсруулсан шингэн сүү | мян.л | 24 847.3 | 26 330.3 | 28 003.3 | 26 947.7 | 29 512.9 |
| Цөцгий | т | 26.52 | 118.56 | 32.76 | 29.64 | 24.2 |
| Хуурай сүү | Т | - | - | - | - | 11 505.1 |
| Тараг | мян.л | 7 706.8 | 8 645.9 | 6 960.9 | 7 015.3 | 7 863.5 |
| Хоормог | мян.л | 8.1 | 3.2 | 4.2 | 8.8 | 9 |
| Ааруул | т | 191 | 1 152.0 | 1 449.0 | 1 698.0 | 1 529.0 |
| Цөцгийн тос | т | 800.28 | 1 154.4 | 1 018.7 | 988.3 | 1 227.7 |
| Өрөм, зөөхий | т | 14.04 | 19.5 | 27.3 | 28.86 | 1 700.4 |
| Шар тос | т | 70 | 52.5 | 0 | 0 | 72.5 |
| Масло | т | 0 | 2.3 | 0 | 0 | 0 |
| Өтгөн цөцгий | т | 33 295.5 | 23 031.0 | 29 511.0 | 29 472.8 | 5 863.5 |
| Бяслаг | т | 97.7 | 116.2 | 16.7 | 24.6 | 0 |
| Ааруц | т | 2 135.9 | 827.4 | 703.5 | 958.1 | 716.2 |
| Зайрмаг | т | 3 206.6 | 1 863.4 | 2 725.5 | 2 462.8 | 3 261.2 |
| Угаасан ноос | т | 1 075.2 | 893.7 | 1 386.7 | 1 777.8 | 6 990.9 |
| Самнасан ноолуур | т | 417 | 521.8 | 633.2 | 754.5 | 782.1 |
| Үхрийн шир | мян.ш | 63.3 | 54.4 | 92.1 | 284.2 | 279.2 |
| Хонины арьс | мян.ш | 690.7 | 264.4 | 625.4 | 136.6 | 489.0 |
| Ямааны арьс | мян.ш | 1 184.3 | 894.9 | 1 313.8 | 1 769.4 | 596.7 |

| | Боловсруулалтын хувь | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
| Боловсруулсан мах | 5 | 6.6 | 5.8 | 2.8 | 2.3 |
| Боловсруулсан сүү** | 12.4 | 9.6 | 9.3 | 8.0 | 8.0 |
| Угаасан ноос | 6.1 | 4.4 | 6.2 | 6.9 | 25.5 |
| Самнасан ноолуур | 6.6 | 7.4 | 8.2 | 8.5 | 8.3 |
| Үхрийн шир | 13.8 | 11 | 21 | 38.8 | 35.3 |
| Хонины арьс | 18.9 | 5 | 12.6 | 1.9 | 7.4 |
| Ямааны арьс | 29.9 | 19.1 | 30.4 | 28.7 | 10.4 |

** Боловсруулсан сүүнд шингэн сүү, зайрмаг, тараг, бяслаг, ааруц зэргийг оруулан тооцсон

## II.2 2016 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

### II.2.1 Малтай болон малчин өрх, малчид, тэдгээрийн ахуйн соёлын үзүүлэлтүүд

***Малтай өрх, малчид.*** Мал тооллогын 2016 оны дүнгээр улсын хэмжээнд 223.8 мянган малтай өрх тоологдсон байна. Үүний 71.8 хувь буюу 160.7 мянган өрх нь жилийн дөрвөн улирлын туршид малаа малладаг, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа малчин өрх, 28.2 хувь буюу 63.2 мянган өрх нь малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөн үржүүлж буй мал бүхий өрх байна (Хүснэгт 8).

Мал тооллогын 2016 оны дүнгээр 311.4 мянган малчид мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллаж байгаа бөгөөд малчдыг насны бүлгээр авч үзвэл 34.8 хувь нь 15-34 насны, 55.3 хувь нь 35 наснаас тэтгэвэрт гарах хүртэлх насныхан, 9.9 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна. Сүүлийн жилүүдэд малчдын дотор 15-34 насны залуу малчдын эзлэх хувийн жин буурч, харин 35 наснаас тэтгэвэрт гарах хүртэлх насныхны эзлэх хувийн жин өссөн хэвээр байна.

ХҮСНЭГТ 8. ӨРХ, МАЛЧДЫН ТОО, НАСНЫ БҮТЭЦ

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
|---|---|---|---|---|---|
| **Малтай өрх,** *мянган өрх* | **207.8** | **209.9** | **213.4** | **216.7** | **223.8** |
| **Малчин өрх,** *мянган өрх* | **146.1** | **145.3** | **149.7** | **153.1** | **160.7** |
| **Малчдын тоо,** *мянган хүн* | **289.7** | **285.7** | **293.6** | **297.8** | **311.4** |
| 15-34 насны | 117.8 | 110.1 | 108.6 | 107.3 | 108.3 |
| 35-59 насны эмэгтэй, 35-60 насны эрэгтэй | 144 | 147.9 | 156.4 | 161.9 | 172.3 |
| тэтгэврийн насны | 27.9 | 27.7 | 28.6 | 28.6 | 30.9 |
| **Нийт малчдаас эмэгтэй** | **136.1** | **134.7** | **137.4** | **137.9** | **143.7** |
| **Насны бүтэц, хувиар** | **100** | **100** | **100** | **100** | **100** |
| 15-34 насны | 40.7 | 38.5 | 36.9 | 36 | 34.8 |
| 35-59 насны эмэгтэй, 35-60 насны эрэгтэй | 49.7 | 51.8 | 53.3 | 54.4 | 55.3 |
| тэтгэврийн насны | 9.6 | 9.7 | 9.8 | 9.6 | 9.9 |

Улсын дүнгээр 2016 онд малтай өрхийн тоо өмнөх оныхтой харьцуулахад 3.2 хувь буюу 7.0 мянган өрхөөр, малчин өрхийн тоо 4.9 хувь буюу 7.6 мянган өрхөөр өсжээ. Малтай өрхийн тоо хамгийн их буюу Завхан аймагт 755, Өвөрхангай аймагт 561, Баянхонгор аймагт 518, Хэнтий аймагт 477, Архангай аймагт 435 өрхөөр өссөн бол бусад аймаг болон Улаанбаатар хотод 49-431 өрхөөр өссөн байна.

Малчин өрхийн тоо өмнөх онтой харьцуулахад Төв аймагт 776, Өвөрхангай аймагт 749, Увс аймагт 597, Баянхонгор аймагт 564, Завхан аймагт 549 өрхөөр өссөн байна. Бусад аймаг болон Улаанбаатар хотод 16-476 өрхөөр өсжээ (Хавсралт хүснэгт 1).

Нийт малтай өрхийн 36.5 хувь нь Хангайн, 27.7 хувь нь Баруун, 21.6 хувь нь Төвийн, 11.8 хувь нь Зүүн бүсэд, 2.4 хувь нь Улаанбаатар хотод байна. Харин малчин өрхийн 40.7 хувь нь Хангайн, 25.3 хувь нь Баруун, 21.2 хувь нь Төвийн, 11.8 хувь нь Зүүн бүсэд, 1.1 хувь нь Улаанбаатарт байна (Хавсралт хүснэгт 1).

Мал аж ахуйн үйлдвэрлэлд 2016 онд ажиллаж буй малчдын тоо өмнөх оныхоос 4.5 хувь буюу 13.5 мянгаар өссөн байна.

Аймгаар авч үзвэл, малчдын тоо Өвөрхангай аймагт 1547, Увс аймагт 1283, Төв аймагт 1198, Хөвсгөл аймагт 1086, бусад аймаг болон Улаанбаатар хотод 13-928-аар өссөн байна (Хавсралт хүснэгт 2).

ЗУРАГ 2. МАЛЧДЫН ТОО, НАСНЫ БҮЛГЭЭР, МЯНГАН ХҮН



***<u>Малчдын нийгэм ахуйн зарим үзүүлэлт.</u>*** 2016 оны мал тооллогоор нийт малчин өрхийн 86.1 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 73.9 хувь нь телевизортой, 39.9 хувь нь автомашинтай, 44.9 хувь нь мотоциклтой, 3.5 хувь нь трактортой гэсэн дүн гарсан (Хүснэгт 9).

Цахилгааны эх үүсгүүртэй өрхийн тоо 2016 онд 138.3 мянга болж, өмнөх оныхоос 3.2 мянгаар буюу 2.4 хувь, телевизортой өрхийн тоо 0.4 мянга буюу 0.3 хувь, автомашинтай өрхийн тоо 0.9 мянга буюу 1.4 хувиар өсөж, мотоциклтой өрхийн тоо 3.6 мянга буюу 4.8 хувиар буурчээ.

Нийт малчин өрхөд мотоциклтой өрхийн эзлэх хувь өмнөх оноос 4.5 пункт, телевизортой өрхийн эзлэх хувь 3.4 пункт, цахилгаан үүсгүүртэй өрхийн эзлэх хувь 2.2 пункт, автомашинтай өрхийн эзлэх хувь 1.4 пунктээр буурсан байна. (Дэлгэрэнгүйг хавсралт хүснэгт 3-аас харна уу.)

ХҮСНЭГТ 9. МАЛЧИН ӨРХИЙН НИЙГЭМ АХУЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| | Өрхийн тоо, мянгаар | | | | | Малчин өрхийн тоонд эзлэх хувь | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
| Цахилгаан үүсгүүртэй | 119.8 | 122.3 | 132.8 | 135.1 | 138.3 | 82 | 84.1 | 88.7 | 88.3 | 86.1 |
| Телевизортой | 108.7 | 107.6 | 114.9 | 118.3 | 118.7 | 74.7 | 74.1 | 76.7 | 77.3 | 73.9 |
| Автомашинтай | 41.2 | 55.8 | 60.2 | 63.2 | 64.1 | 28.2 | 38.4 | 40.2 | 41.3 | 39.9 |
| Мотоциклтой | 63.0 | 68.6 | 76.2 | 75.7 | 72.1 | 43.2 | 47.2 | 50.9 | 49.4 | 44.9 |

Зураг 3. **НИЙГЭМ АХУЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, МАЛЧИН ӨРХИЙН ТООНД ЭЗЛЭХ ХУВЬ**




Нийт цахилгаан үүсгүүртэй өрхийн 94.3 хувь нь нарны, 0.6 хувь нь салхины, 6.4 хувь нь бусад (бага оврын мотор, аккумлятор гэх мэт) төрлийн цахилгаан эх үүсгүүртэй байна (Хүснэгт 10).

ХҮСНЭГТ 10. ЦАХИЛГААН ҮҮСГҮҮРТЭЙ ӨРХИЙН ТОО

| | Бүгд | Нарны | Салхины | Бусад | Нарны | Салхины | Бусад |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мянган өрх | | | | дүнд эзлэх хувь | | |
| 2012 | 119.8 | 112.8 | 2.0 | 5.0 | 94.1 | 1.7 | 4.2 |
| 2013 | 122.3 | 117.3 | 1.4 | 3.6 | 95.9 | 1.2 | 2.9 |
| 2014 | 132.8 | 125 | 1 | 8.9 | 94.1 | 0.8 | 6.7 |
| 2015 | 135.1 | 127.4 | 1.3 | 8.4 | 94.3 | 1.0 | 6.2 |
| 2016 | 138.3 | 130.4 | 0.8 | 8.8 | 94.3 | 0.6 | 6.4 |

## II.2.2 Мал, тэжээвэр амьтдын тоо, сүргийн бүтэц

***Малын тоо.*** Жилийн эцсийн мал тооллогын 2016 оны дүнгээр малын тоо 61.5 сая толгой болж, өмнөх оныхоос 9.9 хувь буюу 5.6 сая толгойгоор өсөв.

ЗУРАГ 4. НИЙТ МАЛЫН ТОО, сая толгойгоор




Төрлөөр нь авч үзвэл, адуу 3635.5 мянга, үхэр 4080.9 мянга, тэмээ 401.3 мянга, хонь 27856.6 мянга, ямаа 25574.9 мянган толгой тоологдсон нь өмнөх оныхоос адуу 340.2 мянга, үхэр 300.5 мянга, тэмээ 33.3 мянга, хонь 2913.5 мянга, ямаа 1982.0 мянган толгойгоор тус тус өссөн байна (Хүснэгт 11).

ХҮСНЭГТ 11. МАЛЫН ТОО, төрлөөр

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мянган толгой | | | | | хувь | зөрүү |
| **Бүгд** | **40 920.9** | **45 144.3** | **51 982.6** | **55 979.8** | **61 549.2** | **109.9** | **5 569.4** |
| Адуу | 2 330.4 | 2 619.4 | 2 995.8 | 3 295.3 | 3 635.5 | 110.3 | 340.2 |
| Үхэр | 2 584.6 | 2 909.5 | 3 413.9 | 3 780.4 | 4 080.9 | 107.9 | 300.5 |
| Тэмээ | 305.8 | 321.5 | 349.3 | 368 | 401.3 | 109 | 33.3 |
| Хонь | 18 141.4 | 20 066.4 | 23 214.8 | 24 943.1 | 27 856.6 | 111.7 | 2 913.5 |
| Ямаа | 17 558.7 | 19 227.6 | 22 008.9 | 23 592.9 | 25 574.9 | 108.4 | 1 982.0 |

ЗУРАГ 5. 2016 ОНЫ ЭЦЭСТ ТООЛОГДСОН МАЛЫН ТОО, аймаг, сумаар



Нийт 799.6 мянган сарлаг 2016 онд тоологдсон нь нийт үхэр сүргийн 19.6 хувийг эзэлж байна. Сарлагийн тоо өмнөх оныхоос 7.2 хувь буюу 53.9 мянган толгойгоор өссөн байна.

ЗУРАГ 6. НИЙТ САРЛАГИЙН ТОО, мянган толгой




Нийт малын 86.8 хувийг бог мал, 5.9 хувийг адуу, 6.6 хувийг үхэр, 0.7 хувийг тэмээ эзэлж байна. Малын тоо Дорноговь аймагт 48.3 мянга, Сүхбаатар аймагт 39.8 мянгаар буурч, бусад бүх аймаг, Улаанбаатар хотод 14.5-697.6 мянгаар өссөн байна (Хавсралт Хүснэгт 10).

Өвөрхангай, Хөвсгөл, Архангай, Төв, Баянхонгор аймгууд 4.2-5.2 сая мал тоолуулж, нийт малын тоогоороо тэргүүлж байна (Хавсралт хүснэгт 6).

Нийт малын 37.6 хувь буюу 23.2 сая толгой нь Хангайн бүсэд, 24.6 хувь буюу 15.1 сая толгой нь Баруун бүсэд, 23.0 хувь буюу 14.2 сая толгой нь Төвийн бүсэд, 14.1 хувь буюу 8.7 сая нь Зүүн бүсэд, 0.7 хувь буюу 438.3 мянга нь Улаанбаатарт байна (Хүснэгт 12).

ХҮСНЭГТ 12. МАЛЫН ТОО, бүсээр

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мянган толгой | | | | | хувь | зөрүү |
| **Бүгд** | **40 920.9** | **45 144.3** | **51 982.6** | **55 979.8** | **61 549.2** | **109.9** | **5569.4** |
| Баруун | 9 670.8 | 10 832.7 | 12 544.5 | 13 711.2 | 15 135.8 | 110.4 | 1424.6 |
| Хангай | 15 379.5 | 16 790.7 | 19 283.8 | 20 481.6 | 23 163.7 | 113.1 | 2682.1 |
| Төв | 9 463.9 | 10 604.9 | 12 288.4 | 13 206.5 | 14 154.4 | 107.2 | 947.9 |
| Зүүн | 6 098.2 | 6 586.9 | 7 480.5 | 8 176.9 | 8 656.9 | 105.9 | 480 |
| Улаанбаатар | 308.5 | 329.1 | 385.4 | 403.7 | 438.3 | 108.6 | 34.6 |

2016 онд тоологдсон малын тоог бүс тус бүрээр өмнөх оныхтой харьцуулахад Хангайн бүсийнх 2.6 сая буюу 13.1 хувь, Баруун бүсийнх 1.4 сая буюу 10.4 хувь, Төвийн бүсийнх 0.9 сая буюу 7.2 хувь, Зүүн бүсийнх 0.5 сая буюу 5.9 хувь, Улаанбаатарынх 34.6 мянга буюу 8.6 хувиар өссөн байна.

Нийт малын тооны өсөлтийн 48.2 хувь нь Хангайн бүсэд, 25.6 хувь нь Баруун бүсэд, 17.0 хувь нь Төвийн бүсэд, 8.6 хувь нь Зүүн бүсэд, 0.6 хувь нь Улаанбаатарт ногдож байна.

Малын тоог төрлөөр нь өмнөх онтой харьцуулан аймгаар авч үзэхэд Дорноговь аймагт адуу 12.9 мянга, үхэр 6.9 мянга, Сүхбаатар аймагт үхэр 5.2 мянга, тэмээ 0.4 мянга, ямаа 79.7 мянга, Дорноговь ямаа аймагт 37.1, Говьсүмбэр аймагт ямаа 1.7 мянгаар буурчээ. Харин бусад аймаг болон Улаанбаатар хотод мал таван төрөлдөө өссөн байна (Хавсралт хүснэгт 8).

2016 оны байдлаар нийт мал сүргийн 86.8 хувийг бог мал, 13.2 хувийг бод мал эзэлж байна.

Баруун бүсийн нийт малын 9.6 хувийг бод, 90.4 хувийг бог, Хангайн бүсийн нийт малын 14.0 хувийг бод, 86.0 хувийг бог, Төвийн бүсийн малын 12.9 хувийг бод, 87.1 хувийг бог, Зүүн бүсийн малын 17.1 хувийг бод, 82.9 хувийг бог, Улаанбаатар хотын малын 30.8 хувийг бод, 69.2 хувийг бог мал тус тус эзэлж байна (Хүснэгт 13).

ХҮСНЭГТ 13. МАЛЫН ТОО, бүсээр, төрлөөр

| | 2016 | Адуу | Үхэр | Тэмээ | Хонь | Ямаа |
|---|---|---|---|---|---|---|
| **Бүгд** | **61 549.2** | **3 635.5** | **4 080.9** | **401.3** | **27 856.6** | **25 574.9** |
| Баруун | 15 135.8 | 607.2 | 742.2 | 96.2 | 6 417.6 | 7 272.7 |
| Хангай | 23 163.7 | 1 348.3 | 1 806.8 | 80.6 | 10 694.3 | 9 233.6 |
| Төв | 14 154.4 | 854.4 | 761.0 | 206.9 | 6 256.2 | 6 076.0 |
| Зүүн | 8 656.9 | 780.4 | 681.1 | 17.4 | 4 311.7 | 2 866.3 |
| Улаанбаатар | 438.3 | 45.2 | 89.8 | 0.2 | 176.8 | 126.3 |

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувийн жинг авч үзвэл адуу 5.9, үхэр 6.6, тэмээ 0.7, хонь 45.3, ямаа 41.6 хувийг тус тус эзэлж байна. Өмнөх оныхтой харьцуулахад нийт малд эзлэх хувь хонь 0.7 пунктээр өсөж, ямаа, үхрийнх 0.2-0.5 пунктээр буурч, адуу, тэмээнийх өмнөх оны түвшинд байна (Хүснэгт 14).

ХҮСНЭГТ 14. НИЙТ СҮРЭГТ ТАВАН ТӨРЛИЙН МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
|---|---|---|---|---|---|
| **Бүгд** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** |
| **Бод мал** | **12.7** | **12.9** | **13.1** | **13.3** | **13.2** |
| Адуу | 5.7 | 5.8 | 5.8 | 5.9 | 5.9 |
| Үхэр | 6.3 | 6.4 | 6.6 | 6.8 | 6.6 |
| Тэмээ | 0.7 | 0.7 | 0.7 | 0.7 | 0.7 |
| **Бог мал** | **87.2** | **87.1** | **86.9** | **86.7** | **86.8** |
| Хонь | 44.3 | 44.5 | 44.6 | 44.6 | 45.2 |
| Ямаа | 42.9 | 42.6 | 42.3 | 42.1 | 41.6 |

ЗУРАГ 7. 2016 ОНЫ ЭЦЭСТ ТООЛОГДСОН ХОНИНЫ ТОО, аймаг, сумаар



Малын тоо толгой сүүлийн жилүүдэд нэмэгдсэнээс гадна таван төрлийн малын харьцаа, сүргийн бүтцэд томоохон өөрчлөлт гарсан байна. 1926-1992 оны улсын мал тооллогын 66 жилийн дүнгээс үзэхэд сүрэгт бод мал 21.7 хувь, бог мал 78.3 хувийг эзэлдэг байсан бол 2016 оны байдлаар бод мал 13.2 хувь, бог мал 86.8 хувийг эзлэх болж, бод малын хувийн жин 8.5 пунктээр буурч, бог малынх 8.5 пунктээр нэмэгджээ. Дөрвөн бог мал тутмын гурав нь хонь, нэг нь ямаа гэсэн харьцаатай өсгөн үржүүлж ирсэн олон жилийн уламжлал маань сүүлийн 10 жилийн дунджаар авч үзэхэд 2 хонь 2 ямаа гэсэн харьцаатай болж өөрчлөгдсөн байна.

Сүүлийн 80 гаруй жилийн хугацаанд тэмээний тоо толгой дунджаар 2.2 дахин буурсан байхад ямааны тоо 4.1 дахин нэмэгджээ. Үүний дүнд бог малын 25.4 хувийг эзэлж байсан ямааны тоо 50.0 хувийг эзлэх болсон байна. Ямааны тоо толгойн эрс өсөлт 1993 оноос эхэлж, ноолуур үнэд орсонтой холбогдон 1994-2004 онд дунджаар хонины тоонд дөхөж очин, 2005-2016 онд хонины тоо толгойтой дүйцсэн байна. (Хүснэгт 15).

1942 оны үед зөвхөн Өмнөговь аймагт ямааны тоо хониныхоосоо илүү байсан бол 1994 онд Баянхонгор, 1996 онд Говь-Алтай, 1998 онд Ховд аймагт ямааны тооны давамгайлал эхэлж, 2016 оны байдлаар Баянхонгор, Говь-Алтай, Өмнөговь, Ховд, Баян-Өлгий, Дорноговь аймгуудад ямааны тоо хонины тооноос давсан байна. Бог малд хонь 75.0 орчим хувь, ямааны тоо 25.0 орчим хувь байхад сүргийн бүтцэд болон малын бэлчээр ашиглалтад зохистой байсан уламжлалт харьцаа алдагдсаар 20 орчим жил болж байна.

## ХҮСНЭГТ 15. МАЛЫН ЖИЛИЙН ДУНДАЖ ТОО ТОЛГОЙ

| | 1926-1992 оны дундаж | 1994-2004 оны дундаж | 2005-2016 оны дундаж | 1994-2004* / 1926-1992* % | 2005-2016* / 1926-1992* % |
|---|---|---|---|---|---|
| | мянган толгой | | | хувь | |
| Бүгд | 22 940.2 | 28 735.9 | 43 118.3 | 125.3 | 188.0 |
| Адуу | 2 146.5 | 2 526.8 | 2 475.1 | 117.7 | 115.3 |
| Үхэр | 2 197.2 | 2 877.1 | 2 745.4 | 130.9 | 125.0 |
| Тэмээ | 647.9 | 321.2 | 300.6 | 49.6 | 46.4 |
| Хонь | 13 391.8 | 13 091.8 | 18 891.5 | 97.8 | 141.1 |
| Ямаа | 4 556.8 | 9 922.2 | 18 705.7 | 217.7 | 410.5 |
| Малын дүнд төрлийн эзлэх хувь | 100.0 | 100.0 | 100.0 | | |
| Адуу | 9.3 | 8.8 | 5.7 | | |
| Үхэр | 9.6 | 10 | 6.4 | | |
| Тэмээ | 2.8 | 1.1 | 0.7 | | |
| Хонь | 58.4 | 43.2 | 43.8 | | |
| Ямаа | 19.9 | 34.5 | 43.4 | | |
| Бог малын дүнд ямааны эзлэх хувь | 25.4 | 43.1 | 49.8 | | |
| Хонь, ямааны тооны харьцаа | 3 : 1 | 1 : 0.8 | 1 : 1 | | |

*жилийн дундаж үзүүлэлт

2016 оны мал тооллогын дүнгээр Өвөрхангай аймаг нийт малын тоогоор, Төв аймаг адууны тоогоор, Архангай аймаг үхэр, хонины тоогоор, Өмнөговь аймаг тэмээний тоогоор, Баянхонгор аймаг ямааны тоогоор тус тус тэргүүлж байна.

Улсын хэмжээнд нийт малын тоогоор Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, адуугаар Сүхбаатар аймгийн Баруун-урт, үхрээр Архангай аймгийн Их тамир, тэмээгээр Өмнөговь аймгийн Ханбогд, хониор Архангай аймгийн Эрдэнэмандал, ямаагаар Өвөрхангай аймгийн Богд сумд тэргүүлж байна (Хавсралт хүснэгт 6).

ЗУРАГ 8. 2016 ОНЫ ЭЦЭСТ ТООЛОГДСОН АДУУНЫ ТОО, аймаг, сумаар




Улсын хэмжээнд нийт малын тоогоор 400.0 мянгаас дээш малтай Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Архангай аймгийн Эрдэнэмандал, Дундговь аймгийн Эрдэнэдалай, Төв аймгийн Эрдэнэсант, Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумд орж байна. Харин хамгийн бага буюу 1.0-50.0 мянган малтай 20 сум байгаагийн хамгийн бага нь Хөвсгөл аймгийн Цагааннуур сум 17.0 мянган толгой, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум 19.4 мянган толгой малтай байна.

ЗУРАГ 9. 2016 ОНЫ ЭЦЭСТ ТООЛОГДСОН ҮХРИЙН ТОО, аймаг, сумаар



ЗУРАГ 10. 2016 ОНЫ ЭЦЭСТ ТООЛОГДСОН ТЭМЭЭНИЙ ТОО, аймаг, сумаар




ЗУРАГ 11. 2016 ОНЫ ЭЦЭСТ ТООЛОГДСОН ЯМААНЫ ТОО, аймаг, сумаар



***Өрхийн аж ахуйн буюу хувийн малын тоо.*** Хувийн мал 2016 онд 61.2 сая толгой болж, нийт малын 99.4 хувийг эзэлж байна. Адууны 99.4, үхрийн 99.1, тэмээний 99.4 хувь, хонины 99.3, ямааны 99.6 хувь нь өрхийн аж ахуйд байна.

Өрхийн аж ахуйн малын тоо өмнөх оныхоос 5.6 сая толгой буюу 10.0 хувиар өслөө. (Хүснэгт 16).

ХҮСНЭГТ 16. ӨРХИЙН АЖ АХУЙН БУЮУ ХУВИЙН МАЛЫН ТОО

| | Бүгд | адуу | үхэр | тэмээ | хонь | ямаа |
|---|---|---|---|---|---|---|
| | | мянган толгой | | | | |
| 2012 | 40 566.9 | 2 310.3 | 2 558.2 | 303.3 | 17 929.4 | 17 465.7 |
| 2013 | 44 793.2 | 2 598.5 | 2 881.9 | 318.8 | 19 860.8 | 19 133.3 |
| 2014 | 51 611.9 | 2 973.6 | 3 383.4 | 346.7 | 23 001.5 | 21 906.8 |
| 2015 | 55 607.3 | 3 273.5 | 3 745.3 | 365.3 | 24 730.8 | 23 492.5 |
| 2016 | 61 183.9 | 3 612.2 | 4 045.8 | 398.7 | 27 648.2 | 25 478.9 |

Өрхийн аж ахуйн нийт мал 2016 оны байдлаар 45.2 хувийг хонь, 41.6 хувийг ямаа, 6.6 хувийг үхэр, 5.9 хувийг адуу, 0.7 хувийг тэмээ эзэлж байна.

***Малтай өрхийн бүлэглэлт.*** Малтай 223.8 мянган өрхийг малын тоогоор нь бүлэглэвэл, 11 хүртэлх малтай 14.2 мянган өрх буюу нийт мал бүхий өрхийн 6.3 хувь, 11-30 малтай 19.6 мянган өрх буюу нийт мал бүхий өрхийн 8.8 хувь, 31-50 малтай 15.3 мянган өрх буюу нийт мал бүхий өрхийн 6.8 хувь, 51-100 малтай 29.1 мянган өрх буюу нийт мал бүхий өрхийн 13.0 хувь, 101-200 малтай 45.9 мянган өрх буюу нийт мал бүхий өрхийн 20.5 хувь, 201-500 малтай 63.1 мянган өрх буюу нийт мал бүхий өрхийн 28.2 хувь, 501-ээс дээш малтай 36.6 мянган өрх буюу нийт мал бүхий өрхийн 16.4 хувийг тус тус эзэлж байна. (Хүснэгт 17).

ХҮСНЭГТ 17. МАЛТАЙ ӨРХИЙН МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ

| Бүлэглэлт | Малтай өрхийн тоо | | Нийт дүнд эзлэх хувь | | Хувийн малын тоо, мянган толгой | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2015 | 2016 | 2015 | 2016 | 2015 | 2016 |
| **Дүн** | **216 734** | **223 761** | **100** | **100** | **55 607.3** | **61 183.8** |
| < 11 | 14 226 | 14 176 | 6.6 | 6.3 | 80.8 | 80.4 |
| 11-30 | 19 933 | 19 611 | 9.2 | 8.8 | 401.8 | 395.3 |
| 31-50 | 15 478 | 15 323 | 7.1 | 6.8 | 628.3 | 621.4 |
| 51-100 | 29 266 | 29 075 | 13.5 | 13 | 2 167.1 | 2 158.0 |
| 101-200 | 46 250 | 45 870 | 21.3 | 20.5 | 6 800.8 | 6 755.3 |
| 201-500 | 60 075 | 63 120 | 27.7 | 28.2 | 19 093.6 | 20 190.7 |
| 501-1000 | 23 070 | 26 632 | 10.6 | 11.9 | 15 496.7 | 18 036.1 |
| 1001-1500 | 6 950 | 8 144 | 3.2 | 3.6 | 8 015.6 | 9 412.7 |
| 1501-2000 | 993 | 1 203 | 0.5 | 0.5 | 1 679.5 | 2 020.6 |
| 2001< | 493 | 607 | 0.2 | 0.3 | 1 243.1 | 1 513.3 |

Малтай өрхийн дийлэнх хувийг эзэлдэг 200 хүртэлх малтай өрхийн тоо 2016 онд 55.4 хувь болж, өмнөх оныхоос 2.3 пунктээр буурчээ. Мөн цөөн малтай буюу 200 хүртэлх малтай өрхийн тоо өмнөх оныхоос 1098 өрхөөр буурсан байна.

201-500 хүртэл толгой малтай өрхийн эзлэх хувийн жин өмнөх оныхоос 0.5 пунктээр, 500-аас дээш бүлгийн малтай өрхийн эзлэх хувийн жин 1.9 пунктээр өссөн байна.

Бүсээр авч үзвэл, 2015 онд 200 хүртэл толгой малтай өрхийн нийт малтай өрхөд эзлэх хувь Баруун бүсэд 61.5, Хангайн бүсэд 55.6, Төвийн бүсэд 56.1 хувь, Зүүн

бүсэд 52.3 хувь, Улаанбаатарт 89.3 хувь байсан бол 2016 онд Баруун бүсийнх 59.6 хувь, Хангайн бүсийнх 51.6 хувь, Төвийн бүсийнх 54.7 хувь, Зүүн бүсийнх 52.0 хувь, Улаанбаатарынх 88.8 хувь болсон байна. Үүнээс үзвэл цөөн малтай буюу 200 хүртэл толгой малтай өрхийн хувийн жин бүх бүсэд буурсан байна (Хавсралт хүснэгт 4).

ХҮСНЭГТ 18. МАЛТАЙ ӨРХ, малын тооны бүлэглэлт, 2016 он, бүсээр

| Бүлэглэлт | Бүгд | Баруун | Хангай | Төв | Зүүн | Улаанбаатар |
|---|---|---|---|---|---|---|
| Бүгд | 223 761 | 62 019 | 81 614 | 48 415 | 26 443 | 5 270 |
| < 11 | 14 176 | 3 947 | 2 638 | 4 661 | 1 293 | 1 637 |
| 11-30 | 19 611 | 5 191 | 5 577 | 5 121 | 2 235 | 1 487 |
| 31-50 | 15 323 | 4 525 | 5 233 | 3 240 | 1 776 | 549 |
| 51-100 | 29 075 | 8 668 | 10 586 | 5 719 | 3 515 | 587 |
| 101-200 | 45 870 | 14 656 | 18 119 | 7 745 | 4 932 | 418 |
| 201-500 | 63 120 | 16 941 | 26 135 | 12 510 | 7 096 | 438 |
| 501-1000 | 26 632 | 5 936 | 9 927 | 6 724 | 3 927 | 118 |
| 1001-1500 | 8 144 | 1 841 | 2 906 | 2 188 | 1 187 | 22 |
| 1501-2000 | 1 203 | 222 | 347 | 337 | 288 | 9 |
| 2001< | 607 | 92 | 146 | 170 | 194 | 5 |

1000 ба түүнээс дээш малтай 9954 өрх 2016 онд тоологдсон нь өмнөх оныхоос 1518 өрх буюу 18.0 хувиар өссөн байна. 1000-аас дээш малтай өрхийн 21.6 хувь нь Баруун бүсэд, 34.1 хувь нь Хангайн бүсэд, 27.1 хувь нь Төвийн бүсэд, 16.8 хувь нь Зүүн бүсэд, 0.4 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.1000-аас дээш малтай өрхийн тоогоор Төв аймаг тэргүүлж байна (Хавсралт хүснэгт 5).

ХҮСНЭГТ 19. МАЛТАЙ НЭГ ӨРХӨД НОГДОХ МАЛЫН ТОО,
малын тооны бүлэглэлтээр

| Бүлэглэлт | 2015 | 2016 | Адуу | Үхэр | Тэмээ | Хонь | Ямаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Дүн** | **257** | **273** | **16** | **18** | **2** | **124** | **114** |
| < 11 | 6 | 6 | 1 | 4 | 0 | 0 | 1 |
| 11-30 | 20 | 20 | 2 | 8 | 0 | 4 | 7 |
| 31-50 | 41 | 41 | 3 | 9 | 0 | 11 | 17 |
| 51-100 | 74 | 74 | 6 | 11 | 0 | 24 | 33 |
| 101-200 | 147 | 147 | 10 | 14 | 1 | 56 | 67 |
| 201-500 | 318 | 320 | 18 | 20 | 2 | 134 | 146 |
| 501-1000 | 672 | 677 | 37 | 33 | 5 | 325 | 278 |
| 1001-1500 | 1 153 | 1 156 | 64 | 53 | 8 | 614 | 417 |
| 1501-2000 | 1 691 | 1 680 | 119 | 82 | 11 | 956 | 511 |
| 2001 < | 2 522 | 2 493 | 198 | 135 | 15 | 1455 | 689 |

Улсын дунджаар малтай нэг өрхөд 273 толгой мал ногдож байгаа нь өмнөх оныхоос 16 толгой малаар өссөн байна. Малтай нэг өрхөд адуу 16, үхэр 18, тэмээ 2, хонь 124, ямаа 114 ногдож байна (Хүснэгт 19).

Нэг өрхөд ногдох малын бүтцийг авч үзэхэд 87.0 хувь нь бог мал, 13.0 хувь нь бод мал байна. Мөн 500 хүртэлх малтай өрхөд ямааны тоо хонины тооноос давсан бол 500-аас дээш малтай өрхүүдийн хувьд хонины тоо ямаанаас давсан байна.

Малтай өрхийн дунд дийлэнх хувийг эзэлж байгаа 200 хүртэл толгой малтай нэг өрхөд дунджаар 81 толгой, 201-999 малтай нэг өрхөд 425 толгой, 1000 ба түүнээс дээш малтай өрхөд 1301 толгой мал тус тус ногдож байна.

ЗУРАГ 12. МАЛТАЙ ӨРХИЙН ТОО, малын тооны бүлэглэлтээр




Малтай нэг өрхөд ногдох малын тоо Хэнтий, Дундговь, Говьсүмбэр, Говь-Алтай, Дорноговь, Булган, Өмнөговь, Төв, Сүхбаатар, Баянхонгор, Ховд, Архангай, Өвөрхангай аймгуудад 281-388 толгойд хүрч, улсын дунджаас 8-115 толгойгоор дээгүүр, бусад аймаг, Улаанбаатар хотод 81-263 толгой болж, улсын дунджаас 10-192 толгойгоор доогуур байна (Хавсралт хүснэгт 12).

Бүсээр авч үзвэл, нэг өрхөд ногдох малын тоо Зүүн бүсэд 323, Төвийн бүсэд 290, Хангайн бүсэд 283, Баруун бүсэд 243 Улаанбаатарт 81 толгой болж, Зүүн, Төв, Хангайн бүсэд нэг өрхөд ногдох малын тоо улсын дунджаас 10-50 толгойгоор илүү байна.

***Малчин өрхийн бүлэглэлт.*** Амьжиргааны гол эх үүсвэр нь мал аж ахуй болсон малчин өрхийн эзэмшилд 2016 оны байдлаар нийт малын 89.0 хувь буюу 54.8 сая толгой мал байна (Хүснэгт 20)

ХҮСНЭГТ 20. МАЛЧИН ӨРХИЙН МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ, малын төрлөөр

| Бүлэг | Өрхийн тоо | | Өрхийн малын тоо, мянган толгой | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2015 | 2016 | 2015 | 2016 | Адуу | Үхэр | Тэмээ | Хонь | Ямаа |
| **Дүн** | **153 085** | **160 650** | **49 504.8** | **54 766.5** | **3 183.8** | **3 398.1** | **376.4** | **25 043.6** | **22 764.6** |
| <11 | 2 835 | 3 016 | 17.9 | 19.3 | 2.1 | 12.8 | 0.1 | 1.6 | 2.7 |
| 11-30 | 7 694 | 7 995 | 160.7 | 166.8 | 14.8 | 64.6 | 0.5 | 33.6 | 53.4 |
| 31-50 | 7 483 | 7 863 | 306.1 | 320.6 | 26.2 | 77.9 | 1.4 | 87.1 | 128.0 |
| 51-100 | 17 234 | 17 462 | 1 291.4 | 1 308.9 | 106.4 | 212.0 | 7.1 | 421.1 | 562.3 |
| 101-200 | 34 315 | 33 519 | 5 104.6 | 4 996.0 | 329.8 | 499.6 | 31.4 | 1 859.8 | 2 275.2 |
| 201-500 | 53 218 | 55 575 | 17 096.9 | 17 987.8 | 1 005.5 | 1 108.4 | 123.1 | 7 476.2 | 8 274.6 |
| 501-1000 | 22 034 | 25 459 | 14 823.9 | 17 273.2 | 929.0 | 829.6 | 124.6 | 8 267.8 | 7 122.2 |
| 1001-1500 | 6 827 | 7 989 | 7 871.8 | 9 235.8 | 512.2 | 417.0 | 65.9 | 4 905.6 | 3 335.2 |
| 1501-2000 | 970 | 1 177 | 1 639.8 | 1 976.8 | 139.2 | 95.8 | 13.1 | 1 126.9 | 601.9 |
| 2001< | 475 | 595 | 1 191.7 | 1 481.3 | 118.6 | 80.5 | 9.2 | 864.0 | 409.1 |

Нэг малчин өрхөд 2015 оны байдлаар дунджаар 323 толгой мал ногдож, үүний дотор адуу 19, үхэр 20, тэмээ 2, хонь 146, ямаа 136 тус тус ногдож байсан бол 2016 онд дунджаар 341 толгой мал ногдож, үүний дотор адуу 20, үхэр 21, тэмээ 2, хонь 156, ямаа 142 ногдож байна. 2016 онд нэг малчин өрхөд ногдох малын тоо дунджаар өмнөх оныхоос 18 толгойгоор нэмэгдсэн байна (Хүснэгт 21).

ХҮСНЭГТ 21. МАЛЧИН НЭГ ӨРХӨД НОГДОХ МАЛЫН ТОО

| Бүлэглэлт | 2015 | 2016 | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Адуу | Үхэр | Тэмээ | Хонь | Ямаа |
| **Дүн** | **323** | **341** | **20** | **21** | **2** | **156** | **142** |
| < 11 | 6 | 6 | 1 | 4 | - | 1 | 1 |
| 11-30 | 21 | 21 | 2 | 8 | - | 4 | 7 |
| 31-50 | 41 | 41 | 3 | 10 | - | 11 | 16 |
| 51-100 | 75 | 75 | 6 | 12 | - | 24 | 32 |
| 101-200 | 149 | 149 | 10 | 15 | 1 | 55 | 68 |
| 201-500 | 321 | 324 | 18 | 20 | 2 | 135 | 149 |
| 501-999 | 673 | 678 | 36 | 33 | 5 | 325 | 280 |
| 1000-1500 | 1 153 | 1 156 | 64 | 52 | 8 | 614 | 417 |
| 1501-2000 | 1 691 | 1 680 | 118 | 81 | 11 | 957 | 511 |
| 2001< | 2 509 | 2 490 | 199 | 135 | 15 | 1452 | 687 |

Малчин өрхийг малын тоо толгойгоор нь бүлэглэвэл, 2015 онд малчин өрхийн 23.0 хувь нь 100 хүртэл малтай, 22.4 хувь нь 101-200 хүртэл малтай, 34.8 хувь нь 201-500 малтай, 14.4 хувь нь 501-999 малтай, 5.4 хувь нь 1000-аас дээш малтай байсан бол 2016 онд малчин өрхийн 22.6 хувь нь 100 хүртэл малтай, 20.9 хувь нь 101-200 хүртэл малтай, 34.6 хувь нь 201-500 малтай, 15.8 хувь нь 501-999 малтай, 6.1 хувь нь 1000-аас дээш малтай болсон байна (Хавсралт хүснэгт 4.1).

ЗУРАГ 13. МАЛЧИН ӨРХИЙН ТОО, малын тооны бүлэглэлтээр




***Хээлтэгч мал.*** 2016 оны эцэст 26477.2 мянган толгой хээлтэгч мал тоологдсон нь өмнөх оныхоос 2613.3 мянган толгой буюу 11.0 хувиар өссөн байна. Төрлөөр авч үзвэл, гүү 123.5 мянган толгой буюу 12.5 хувь, үнээ 129.7 мянган толгой буюу 8.9 хувь, ингэ 11.6 мянган толгой буюу 9.1 хувь, эм хонь 1373.2 мянган толгой буюу 12.3 хувь, эм ямаа 975.4 мянган толгой буюу 9.7 хувиар тус тус өсжээ (Хүснэгт 22).

ХҮСНЭГТ 22. ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мянган толгой | | | | | хувь | зөрүү |
| **Бүгд** | **17 748.9** | **19 436.7** | **22 248.6** | **23 863.8** | **26 477.2** | **111.0** | **2 613.3** |
| Гүү | 700.9 | 784.7 | 895.5 | 990.0 | 1 113.5 | 112.5 | 123.5 |
| Үнээ | 1 046.0 | 1151.0 | 1 333.4 | 1 458.1 | 1 587.8 | 108.9 | 129.7 |
| Ингэ | 105.1 | 112.0 | 120.2 | 127.8 | 139.4 | 109.1 | 11.6 |
| Эм хонь | 8 257.1 | 9 094.9 | 10 478.0 | 11 205.4 | 12 578.6 | 112.3 | 1 373.2 |
| Эм ямаа | 7 639.7 | 8 294.3 | 9 421.6 | 10 082.4 | 11 057.8 | 109.7 | 975.4 |

Хээлтэгч мал нийт малын 43.0 хувийг эзэлж байгаа бөгөөд адуун сүргийн 30.6 хувь, үхэр сүргийн 38.9 хувь, тэмээн сүргийн 34.7 хувь, хонин сүргийн 45.2 хувь, ямаан сүргийн 43.2 хувийг тус тус эзэлж байна (Хүснэгт 23). Сүрэгт хээлтэгч малын эзлэх хувийн жин гүү, эм хонь, эм ямаа, үнээний хувьд өмнөх оныхоос 0.3-0.6 пунктээр өсөж, ингэний хувьд өмнөх оныхоос өөрчлөлтгүй байна.

ХҮСНЭГТ 23. СҮРЭГТ ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
|---|---|---|---|---|---|
| **Бүгд** | **43.4** | **43.1** | **42.8** | **42.6** | **43.0** |
| Гүү | 30.1 | 30.0 | 29.9 | 30.0 | 30.6 |
| Үнээ | 40.5 | 39.6 | 39.1 | 38.6 | 38.9 |
| Ингэ | 34.4 | 34.8 | 34.4 | 34.7 | 34.7 |
| Эм хонь | 45.5 | 45.3 | 45.1 | 44.9 | 45.2 |
| Эм ямаа | 43.5 | 43.1 | 42.8 | 42.7 | 43.2 |

Эрдэмтэн, судлаачдын үзэж байгаагаар мал аж ахуйн нөхөн үйлдвэрлэлийг хэвийн хэмжээнд байлгахад бод малын хувьд хээлтэгч мал сүргийн 50.0-55.0 хувь, бог малын хувьд сүргийн 60.0-65.0 хувийг эзэлж байвал зохимжтой гэж үздэг байна. Сүүлийн 5 жилийн байдлаар сүрэгт хээлтэгч малын эзлэх хувь бод малд дунджаар 35.0 хувь, бог малд 44.2 хувь байна.

ЗУРАГ 14. ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО, сая толгойгоор




Бүх бүс болон Улаанбаатар хотод хээлтэгч малын тоо 7.0-12.8 хувь буюу 18.0-1115.4 мянган толгойгоор өссөн байна.

ХҮСНЭГТ 24. ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО, бүсээр

| | 2015 | 2016 | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Гүү | Үнээ | Ингэ | Эм хонь | Эм ямаа |
| | мянган толгой | | | | | | |
| БҮГД | **23 863.8** | **26 477.2** | **1 113.5** | **1 587.8** | **139.4** | **12 578.6** | **11 057.8** |
| Баруун | 5 590.3 | 6 296.0 | 176 | 282.8 | 31.1 | 2 772.9 | 3 033.2 |
| Хангай | 8 692.1 | 9 807.6 | 414.5 | 684.9 | 27.9 | 4 763.4 | 3 916.8 |
| Төв | 5 738.8 | 6 255.6 | 272.5 | 313.5 | 73.6 | 2 892.2 | 2 703.7 |
| Зүүн | 3 654.4 | 3 912.0 | 235.6 | 264.2 | 6.7 | 2 063.3 | 1 342.2 |
| Улаанбаатар | 188.4 | 206 | 14.9 | 42.4 | 0.1 | 86.7 | 61.9 |

Баруун бүсэд нийт малын  41.6 хувь, Хангайн бүсэд 42.3 хувь, Төвийн бүсэд 44.2 хувь, Зүүн бүсэд 45.2 хувь, Улаанбаатар хотын нийт малын 47.0 хувийг хээлтэгч мал эзэлж байна. Нийт малд хээлтэгч малын эзлэх хувийн жин Баруун, Төв, Зүүн бүс болон Улаанбаатарт өмнөх оныхоос 0.4-0.8 пунктээр өсөж, харин Хангайн бүсэд өмнөх оныхоос 0.1 пунктээр буурсан байна.

Аймгаар авч үзвэл 20 аймаг, Улаанбаатар хотод 5.5-278.2 мянган толгой буюу 2.4-19.2 хувиар өсөж, Дорноговь аймагт 7.1 мянган толгой буюу 0.9 хувиар буурчээ.

***Төл бойжилт.*** 2016 оны байдлаар оны эхний эх малын 85.8 хувь буюу 20481.4 мянган эх мал төллөж, өмнөх оныхоос 550.2 мянган толгой буюу 2.8 хувиар өсжээ. (Хүснэгт 25).

ХҮСНЭГТ  25. ТӨЛЛӨСӨН ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО, бүсээр

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|---|---|
| | мянган толгой | | | | | хувь |
| **БҮГД** | **13 741.5** | **15 694.6** | **17 518.6** | **19 931.2** | **20 481.4** | **102.8** |
| Баруун | 3 275.9 | 3 812.7 | 4 306.5 | 4 927.0 | 5 038.5 | 102.3 |
| Хангай | 5 046.4 | 5 734.0 | 6 402.8 | 7 169.5 | 7 553.3 | 105.4 |
| Төв | 3 070.1 | 3 660.9 | 4 051.5 | 4 641.6 | 4 627.6 | 99.7 |
| Зүүн | 2 225.5 | 2 355.1 | 2 616.4 | 3 023.8 | 3 091.7 | 102.2 |
| Улаанбаатар | 123.6 | 131.8 | 141.4 | 169.3 | 170.3 | 100.6 |

Гарсан төлийн 95.9 хувь буюу 19721.7 мянган төл бойжуулав. Бойжсон төлийн тоо өмнөх оныхоос 542.2 мянган толгой буюу 2.8 хувиар өсөж, бойжилтын хувь 0.1 пунктээр өссөн байна (Хүснэгт 26).

Гарсан унаганы 96.6 хувь, тугалын 97.2 хувь, ботгоны 98.3 хувь, хурганы 96.6, ишигний 94.9 хувийг бойжуулсан байна. Өмнөх оныхтой харьцуулахад бойжуулсан төл 5 төрөлдөө 8.0-419.5 мянган толгойгоор өсжээ.

ХҮСНЭГТ 26. ТӨЛ БОЙЖИЛТ

| | 2016 | Унага | Тугал | Ботго | Хурга | Ишиг |
|---|---|---|---|---|---|---|
| | мянган толгой | | | | | |
| Гарсан төл | 20 557.1 | 765.9 | 1192.2 | 66.1 | 10 065.6 | 8 467.3 |
| Бойжсон төл | 19 721.7 | 740.0 | 1158.5 | 65.0 | 9 719.3 | 8 038.8 |
| Бойжилтын хувь | 95.9 | 96.6 | 97.2 | 98.3 | 96.6 | 94.9 |

ЗУРАГ 15. БОЙЖУУЛСАН ТӨЛИЙН ТОО, сая толгойгоор



Бойжуулсан төлийн тоо Увс, Сүхбаатар, Дорноговь, Төв, Завхан, Дархан-Уул, Орхон, Баянхонгор аймгууд, Улаанбаатар хотод 0.7-187.1 мянган толгой буюу 0.3-19.0 хувиар буурч, бусад аймагт 3.8-237.9 мянган толгой буюу 0.4-16.5 хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 27. БОЙЖУУЛСАН ТӨЛ, төрлөөр

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
|---|---|---|---|---|---|
| | мянган толгой | | | | |
| **Бүгд** | **13 379.0** | **15 221.0** | **17 246.0** | **19 179.5** | **19 721.7** |
| Унага | 476.9 | 550.6 | 638.5 | 726.4 | 740.0 |
| Тугал | 751.3 | 845.6 | 974.1 | 1 135.8 | 1 158.5 |
| Ботго | 52.5 | 49.2 | 59.2 | 57.0 | 65.0 |
| Хурга | 6 327.9 | 7 287.5 | 8 299.5 | 9 299.9 | 9 719.3 |
| Ишиг | 5 770.5 | 6 488.2 | 7 274.7 | 7 960.5 | 8 038.8 |

Нийт бойжуулсан төлийн 24.2 хувь нь Баруун бүсэд, 37.1 хувь нь Хангайн бүсэд, 22.9 хувь нь Төвийн бүсэд, 15.0 хувь нь Зүүн бүсэд, 0.8 хувь нь Улаанбаатарт ногдож байна (Хавсралт хүснэгт 27).

Бойжуулсан төлийн тоо Баруун бүсэд 34.3 (0.7%) мянга, Төвийн бүсэд 70.5 (1.5%) мянга, Улаанбаатар хотод 0.7 (0.4%) мянган толгойгоор буурч, харин Хангайн бүсэд 589.9 (8.8%) мянга, Зүүн бүсэд 57.8 (2.0%) мянган толгойгоор өссөн байна (Хүснэгт 28).

ХҮСНЭГТ 28. БОЙЖУУЛСАН ТӨЛ, бүсээр

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|---|---|
| | мянган толгой | | | | | хувь |
| **Бүгд** | **13 379.0** | **15 221.0** | **17 246.0** | **19 179.5** | **19 721.7** | **102.8** |
| Баруун | 3 143.7 | 3 678.4 | 4 196.5 | 4 797.5 | 4 763.2 | 99.3 |
| Хангай | 4 885.6 | 5 476.4 | 6 256.5 | 6 732.5 | 7 322.5 | 108.8 |
| Төв | 3 086.4 | 3 651.6 | 4 078.2 | 4 579.5 | 4 508.9 | 95.5 |
| Зүүн | 2 141.4 | 2 284.8 | 2 575.6 | 2 903.1 | 2 960.9 | 106.5 |
| Улаанбаатар | 121.9 | 129.7 | 139.2 | 166.8 | 166.2 | 99.6 |

Улсын дунджаар 2016 онд 100 эхээс 83 төл бойжуулсан нь өмнөх оныхоос 3 төлөөр буурсан байна (Зураг 16).

ЗУРАГ 16. 100 ЭХЭЭС БОЙЖУУЛСАН ТӨЛ, улсын дундаж



100 эхээс бойжуулсан төлийн тоо Хөвсгөл, Сэлэнгэ, Өвөрхангай, Булган, Говь-Алтай, Архангай аймгуудад өмнөх оныхоос 1-6 толгойгоор өсөж, бусад бүх аймаг, Улаанбаатар хотод 1-21 толгойгоор буурчээ. (Хавсралт хүснэгт 28).

ЗУРАГ 17. 100 ЭХЭЭС БОЙЖУУЛСАН ТӨЛ, аймгаар




100 эхээс бойжуулсан төлийн тоо улсын дунджаас Баян-Өлгий аймагт 11, Өвөрхангай аймагт 10, Говь-Алтай аймагт 8, Ховд аймагт 7 толгойгоор илүү байна. Харин Өмнөговь аймагт 9, Дорноговь аймагт 6, Увс аймагт 4 толгойгоор бага байна.

ХҮСНЭГТ 29. 100 ЭХЭЭС БОЙЖУУЛСАН ТӨЛ, малын төрлөөр

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
|---|---|---|---|---|---|
| | толгой | | | | |
| **Бүгд** | **85** | **86** | **89** | **86** | **83** |
| Унага | 74 | 79 | 81 | 81 | 75 |
| Тугал | 78 | 81 | 85 | 85 | 79 |
| Ботго | 55 | 47 | 53 | 47 | 51 |
| Хурга | 89 | 88 | 91 | 89 | 87 |
| Ишиг | 84 | 85 | 88 | 84 | 80 |

Бүсээр авч үзвэл, Хангайн бүсэд бүсэд 100 эхээс бойжуулсан төлийн тоо өмнөх оныхоос 1 толгойгоор өсөж, бусад бүх бүс, Улаанбаатар хотод 4-7 толгойгоор буурчээ (Хавсралт хүснэгт 28).

ХҮСНЭГТ 30. 100 ЭХЭЭС БОЙЖУУЛСАН ТӨЛ, бүсээр

| | Бүгд | Унага | Тугал | Ботго | Хурга | Ишиг |
|---|---|---|---|---|---|---|
| | толгой | | | | | |
| **Бүгд** | 83 | 75 | 79 | 51 | 87 | 80 |
| Баруун | 85 | 82 | 84 | 48 | 88 | 83 |
| Хангай | 84 | 76 | 78 | 50 | 88 | 82 |
| Төв | 79 | 67 | 78 | 53 | 86 | 73 |
| Зүүн | 81 | 76 | 80 | 41 | 83 | 79 |
| Улаанбаатар | 88 | 85 | 80 | 35 | 92 | 90 |

Баруун болон Хангайн бүс, Улаанбаатар хотод 100 эхээс бойжуулсан төлийн тоо улсын дунджаас 1-5 толгойгоор дээгүүр, Төв, Зүүн бүсэд 2-4 толгойгоор доогуур байна (Хүснэгт 30).

***Том малын зүй бус хорогдол***. 2016 онд оны эхний нийт малын 2.6 хувьтай тэнцэх 1452.1 мянган толгой мал хорогдсон нь өмнөх оныхоос 826.5 мянгаар буюу 2.3 дахин өссөн байна. Нийт хорогдсон малын 48.1 хувийг ямаа, 38.0 хувийг хонь, 9.4 хувийг үхэр, 4.4 хувийг адуу, 0.1 хувийг тэмээ эзэлж байна (Хүснэгт 31).

Нийт хорогдсон малын 15.9 хувь буюу 231.2 мянга нь зуд, гэнэтийн аюулаар, 5.1 хувь буюу 73.8 мянга нь өвчнөөр хорогджээ.

ХҮСНЭГТ 31. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мянган толгой | | | | | хувь | зөрүү |
| **Бүгд** | **428.9** | **792.6** | **401.4** | **625.6** | **1452.1** | 232.1 | 826.5 |
| Адуу | 21 | 35.9 | 23.3 | 31.2 | 64.1 | 205.4 | 32.9 |
| Үхэр | 36.5 | 75 | 34 | 41.2 | 136.7 | 331.8 | 95.5 |
| Тэмээ | 1.4 | 1.8 | 1.5 | 1.9 | 1.6 | 84.2 | -0.3 |
| Хонь | 175.5 | 347.2 | 155.6 | 269.6 | 551.5 | 204.6 | 281.9 |
| Ямаа | 194.4 | 332.7 | 186.9 | 281.8 | 698.2 | 247.8 | 416.4 |

Том малын зүй бус хорогдол өмнөх оныхоос Өвөрхангай, Булган, Хөвсгөл, Өмнөговь, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон аймгуудад 0.3-26.8 мянга буюу 19.7-59.4 хувиар буурч, бусад аймаг, Улаанбаатар хотод том малын зүй бус хорогдол өссөн байна.

ХҮСНЭГТ 32. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, бүсээр

| Бүс, нийслэл | Бүгд | Адуу | Үхэр | Тэмээ | Хонь | Ямаа |
|---|---|---|---|---|---|---|
| | мянган толгой | | | | | |
| **Бүгд** | **1 452.1** | **64.1** | **136.7** | **1.6** | **551.6** | **698.2** |
| Баруун | 452.3 | 9.7 | 24.9 | 0.6 | 178.0 | 239.2 |
| Хангай | 407.1 | 19.9 | 65.7 | 0.2 | 155.4 | 165.9 |
| Төв | 339.1 | 23.4 | 24.3 | 0.7 | 118.3 | 172.4 |
| Зүүн | 247.2 | 10.8 | 20 | 0.1 | 97.3 | 119.0 |
| Улаанбаатар | 6.4 | 0.3 | 1.9 | 0.0 | 2.5 | 1.7 |

Нийт хорогдлын 70.4 хувь нь Увс, Сүхбаатар, Архангай, Завхан, Төв, Баянхонгор, Дорноговь аймгуудад ногдож байна (Хавсралт хүснэгт 29).

ЗУРАГ 18. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, сая толгой



Нийт хорогдлын 31.1 хувь нь Баруун бүсэд, 28.0 хувь нь Хангайн бүсэд, 23.4 хувь нь Төвийн бүсэд, 17.0 хувь нь Зүүн бүсэд, 0.4 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна (Хавсралт хүснэгт 29).

ХҮСНЭГТ 33. ОНЫ ЭХНИЙ МАЛД ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
|---|---|---|---|---|---|
| **Бүгд** | **1.2** | **1.9** | **0.9** | **1.2** | **2.6** |
| Адуу | 1.0 | 1.5 | 0.9 | 1.0 | 1.9 |
| Үхэр | 1.6 | 2.9 | 1.2 | 1.2 | 3.6 |
| Тэмээ | 0.5 | 0.6 | 0.5 | 0.5 | 0.4 |
| Хонь | 1.1 | 1.9 | 0.8 | 1.2 | 2.2 |
| Ямаа | 1.2 | 1.9 | 1.0 | 1.3 | 3.0 |

Баруун бүсэд оны эхний малын 3.3 хувь, Хангайн бүсэд 2.0 хувь, Төвийн бүсэд 2.6 хувь, Зүүн бүсэд 3.0 хувь, Улаанбаатарт 1.6 хувь нь хорогдсон байна (Хавсралт хүснэгт 29).

ХҮСНЭГТ 34. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, бүсээр, төрлөөр

| | Бүгд | Адуу | Үхэр | Тэмээ | Хонь | Ямаа |
|---|---|---|---|---|---|---|
| | мянган толгой | | | | | |
| **Бүгд** | **1452.1** | **64.1** | **136.7** | **1.6** | **551.6** | **698.2** |
| Баруун | 452.3 | 9.7 | 24.9 | 0.6 | 178.0 | 239.2 |
| Хангай | 407.1 | 19.9 | 65.7 | 0.2 | 155.4 | 165.9 |
| Төв | 339.1 | 23.4 | 24.3 | 0.7 | 118.3 | 172.4 |
| Зүүн | 247.2 | 10.8 | 20.0 | 0.1 | 97.3 | 119.0 |
| Улаанбаатар | 6.4 | 0.3 | 1.9 | 0.01 | 2.5 | 1.7 |
| | Оны эхний малд эзлэх хувь | | | | | |
| **Бүгд** | **2.6** | **1.9** | **3.6** | **0.4** | **2.2** | **3.0** |
| Баруун | 3.3 | 1.8 | 3.7 | 0.7 | 3.1 | 3.6 |
| Хангай | 2.0 | 1.6 | 4.0 | 0.3 | 1.7 | 2.0 |
| Төв | 2.6 | 2.9 | 3.3 | 0.4 | 2.1 | 3.0 |
| Зүүн | 3.0 | 1.5 | 3.1 | 0.6 | 2.4 | 4.2 |
| Улаанбаатар | 1.6 | 0.8 | 2.2 | 0.0 | 1.5 | 1.4 |

2016 онд 73.8 мянган толгой мал өвчнөөр хорогдсон нь өмнөх оныхоос 23.1 мянган толгой буюу 45.6 хувиар нэмэгдсэн байна (Хүснэгт 35).

ХҮСНЭГТ 35. ӨВЧНӨӨР ХОРОГДСОН МАЛЫН ТОО, бүсээр

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мянган толгой | | | | | хувь | зөрүү |
| **Бүгд** | **40.2** | **94** | **57.8** | **50.7** | **73.8** | 145.6 | 23.1 |
| Баруун | 10.3 | 16.9 | 10 | 7.9 | 30.5 | 386.1 | 22.6 |
| Хангай | 12.2 | 50.6 | 20.6 | 20.6 | 15.1 | 73.3 | -5.5 |
| Төв | 8.9 | 15.9 | 13.4 | 12.7 | 18.3 | 144.1 | 5.6 |
| Зүүн | 7.8 | 9.9 | 13.2 | 8.6 | 8.8 | 102.3 | 0.2 |
| Улаанбаатар | 1.0 | 0.8 | 0.6 | 0.8 | 1.1 | 137.5 | 0.3 |

Зуд, гэнэтийн аюулаар 2016 онд 231.2 мянган толгой мал 2016 онд хорогдсон нь өмнөх оныхоос 105.3 мянган толгой буюу 83.6 хувиар нэмэгдсэн байна (Хүснэгт 36).

ХҮСНЭГТ 36. ГЭНЭТИЙН АЮУЛААР ХОРОГДСОН МАЛЫН ТОО, төрлөөр

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
|---|---|---|---|---|---|
| | мянган толгой | | | | |
| **Бүгд** | **69.7** | **105.1** | **47.4** | **125.9** | **231.2** |
| Адуу | 4.1 | 4.9 | 3.1 | 5.9 | 13.1 |
| Үхэр | 5.7 | 9.8 | 3.5 | 6.3 | 16.5 |
| Тэмээ | 0.3 | 0.3 | 0.2 | 0.4 | 0.3 |
| Хонь | 27.9 | 44.4 | 18 | 58 | 85.6 |
| Ямаа | 31.8 | 45.8 | 22.7 | 55.3 | 115.6 |

Гэнэтийн аюулаар хорогдсон малын 83.7 хувь нь Дорноговь, Увс, Төв, Баянхонгор, Хэнтий аймгуудад ногдож байна. Бүсээр авч үзвэл гэнэтийн аюулаар хорогдсон малын 48.6 хувь нь Төвийн бүсэд, 30.5 хувь нь Баруун бүсэд, 12.2 хувь нь Хангайн бүсэд, 7.9 хувь нь Зүүн бүсэд, 0.7 хувь нь Улаанбаатар хотод тус тус ногдож байна (Хавсралт хүснэгт 30)

ХҮСНЭГТ 37. ГЭНЭТИЙН АЮУЛААР ХОРОГДСОН МАЛЫН ТОО, бүсээр

| | Бүгд | Адуу | Үхэр | Тэмээ | Хонь | Ямаа |
|---|---|---|---|---|---|---|
| | мянган толгой | | | | | |
| **БҮГД** | **231.2** | **13.1** | **16.5** | **0.3** | **85.6** | **115.6** |
| Баруун | 70.6 | 1.4 | 4.0 | 0.1 | 29.0 | 36.0 |
| Хангай | 28.2 | 1.5 | 2.5 | 0.1 | 8.9 | 15.4 |
| Төв | 112.5 | 9.2 | 8.4 | 0.1 | 38.9 | 55.8 |
| Зүүн | 18.2 | 0.9 | 1.2 | 0.0 | 8.1 | 8.0 |
| Улаанбаатар | 1.7 | 0.1 | 0.5 | - | 0.7 | 0.4 |
| | дүнд эзлэх хувь | | | | | |
| **БҮГД** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** |
| Баруун | 30.5 | 10.7 | 23.9 | 37.5 | 33.9 | 31.2 |
| Хангай | 12.2 | 11.2 | 14.8 | 16.6 | 10.4 | 13.3 |
| Төв | 48.6 | 70.2 | 51.0 | 41.8 | 45.4 | 48.3 |
| Зүүн | 7.9 | 7.0 | 7.4 | 4.0 | 9.5 | 6.9 |
| Улаанбаатар | 0.7 | 0.9 | 2.8 | - | 0.8 | 0.4 |

***Хээл хаялт, сувайралт*.** 2016 онд оны эхний хээлтэгч малын 14.5 хувьтай тэнцэх 3.5 сая мал хээл хаяж, сувайрсны улмаас төл өгөөгүй байна. Хээл хаяж, сувайрсан хээлтэгч малын тоо өмнөх оныхоос 58.0 хувь буюу 1268.5 мянган толгойгоор нэмэгдсэн байна (Хүснэгт 38).

Төл өгөөгүй хээлтэгч малын 77.0 хувь буюу 2661.2 мянга нь сувайрсан хээлтэгч, 23.0 хувь буюу 794.2 мянга нь хээл хаясан эх мал байна.

ХҮСНЭГТ 38. ХЭЭЛ ХАЯЖ, СУВАЙРСАН ЭХ МАЛЫН ТОО

| | Сувайрсан | | | | | Хээл хаясан | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
| | мянган толгой | | | | | | | | | |
| **Бүгд** | **1 308.8** | **1 462.6** | **1 465.6** | **1 801.2** | **2 661.2** | **464.0** | **435.4** | **303.6** | **385.7** | **794.2** |
| Гүү | 103 | 100.2 | 103.2 | 116.7 | 178.4 | 18.5 | 17.5 | 15.1 | 15.1 | 41.7 |
| Үнээ | 133.2 | 136.6 | 132.3 | 141.8 | 216.7 | 30 | 21.7 | 19.7 | 21.4 | 38.1 |
| Ингэ | 2.3 | 2.1 | 2 | 2.3 | 2.6 | 0.2 | 0.2 | 0.1 | 0.2 | 0.2 |
| Эм хонь | 493.1 | 586.8 | 543.4 | 688.4 | 1013.8 | 122.7 | 137.1 | 100.0 | 120.5 | 229.8 |
| Эм ямаа | 577.4 | 636.9 | 684.7 | 851.9 | 1249.7 | 292.5 | 258.9 | 168.6 | 228.5 | 484.4 |

Аймгаар авч үзвэл, төл өгөөгүй хээлтэгч малын тоо өмнөх оныхоос Орхон аймагт 2.0 мянган толгойгоор буурч, бусад аймагт 2.5-199.8 мянган толгойгоор өссөн байна (Хавсралт хүснэгт 31).

ХҮСНЭГТ 39. ОНЫ ЭХНИЙ ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТООНД ХЭЭЛ ХАЯСАН, СУВАЙРСАН МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ

| | Сувайрсан | | | | | Хээл хаясан | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
| | хувь | | | | | | | | | |
| **Бүгд** | **8.3** | **8.2** | **7.5** | **8.1** | **11.2** | **3.0** | **2.5** | **1.6** | **1.7** | **3.3** |
| Гүү | 16.1 | 14.3 | 13.1 | 13.0 | 18.0 | 2.9 | 2.5 | 1.9 | 1.7 | 4.2 |
| Үнээ | 13.8 | 13.1 | 11.5 | 10.6 | 14.9 | 3.1 | 2.1 | 1.7 | 1.6 | 2.6 |
| Ингэ | 2.4 | 2.0 | 1.8 | 1.9 | 2.0 | 0.2 | 0.2 | 0.1 | 0.2 | 0.2 |
| Эм хонь | 6.9 | 7.1 | 6.0 | 6.6 | 9.0 | 1.7 | 1.7 | 1.1 | 1.2 | 2.1 |
| Эм ямаа | 8.4 | 8.3 | 8.3 | 9.0 | 12.4 | 4.3 | 3.4 | 2.0 | 2.4 | 4.8 |

Хээл хаяж, сувайрсан эх малын 38.6 хувь нь Хангайн бүс, 28.3 хувь нь Төвийн бүс, 17.2 хувь нь Баруун бүс, 15.1 хувь нь Зүүн бүсэд, 0.8 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.

ХҮСНЭГТ 40. ХЭЭЛ ХАЯЖ, СУВАЙРСАН ЭХ МАЛ, бүсээр

| | Сувайрсан | | | | | Хээл хаясан | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
| | мянган толгой | | | | | | | | | |
| **Бүгд** | **1 308.8** | **1 462.6** | **1 465.6** | **1 801.2** | **2 661.2** | **464.0** | **435.4** | **303.6** | **385.7** | **794.2** |
| Баруун | 181.8 | 203.1 | 184.4 | 251.5 | 363.1 | 179.4 | 96.3 | 75.7 | 73.4 | 232.5 |
| Хангай | 557.6 | 632.5 | 587.6 | 743.3 | 1 042.6 | 169.6 | 223.6 | 148.6 | 219.7 | 290.7 |
| Төв | 335.0 | 351.8 | 420.7 | 518.2 | 811.1 | 60.1 | 59.3 | 35.3 | 49.0 | 167.1 |
| Зүүн | 219.0 | 262.2 | 256.9 | 273.6 | 421.8 | 51.9 | 53.3 | 41.9 | 41.2 | 100.1 |
| Улаанбаатар | 15.5 | 13.1 | 16.1 | 14.7 | 22.6 | 3.0 | 2.9 | 2.0 | 2.4 | 3.8 |

***Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо*.** 492.5 мянган хээлтүүлэгч мал 2016 онд тоологдож, өмнөх оноос 28.4 мянган толгойгоор буюу 6.1 хувиар өсжээ (Хүснэгт 41).

ХҮСНЭГТ 41. ХЭЭЛТҮҮЛЭГЧ МАЛЫН ТОО, малын төрлөөр

| | 1966-1968** | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | мянган толгой | | | | | | хувь | зөрүү |
| **Бүгд** | **337** | **362.9** | **387** | **434.7** | **464.1** | **492.5** | **106.1** | **28.4** |
| Азарга | 64 | 88.3 | 95.7 | 106.2 | 115.5 | 127.1 | 110.0 | 11.6 |
| Бух | 36.3 | 34.5 | 38.5 | 44.8 | 48.8 | 53.2 | 109.0 | 4.4 |
| Буур | 6.3 | 3.9 | 3.9 | 4.1 | 4.3 | 4.6 | 107.0 | 0.3 |
| Хуц | 173.9 | 124.8 | 131.7 | 148.1 | 158 | 167.9 | 106.3 | 9.9 |
| Ухна | 56.5 | 111.3 | 117.1 | 131.5 | 137.6 | 139.7 | 101.5 | 2.1 |

****** жилийн дундаж

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироог авч үзвэл, бод малын хувьд үржлийн нормоор харин бог малын хувьд хуц, ухна зудад ихээр хорогдсоноос үржлийн норм алдагджээ. Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох

ёстой байхад 2016 онд улсын дунджаар 1 хуцанд 75 эм хонь, 1 ухнад 79 эм ямаа ногдож байгаа нь норм 2.6 дахин хэтэрсэн үзүүлэлт болж байна (Хүснэгт 42).

1966-1968 оны дунджаар нэг хуц, ухнад 39-40 эм хонь, ямаа ногддог байсан нь үржлийн нормтой ойролцоо байжээ.

ХҮСНЭГТ 42. ХЭЭЛТЭГЧ, ХЭЭЛТҮҮЛЭГЧИЙН ТОХИРОО

| | Үржлийн норм | 1966-1968** | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
|---|---|---|---|---|---|---|---|
| Гүү | 12-15 | 10 | 8 | 8 | 8 | 9 | 9 |
| Үнээ | 35-45 | 24 | 30 | 30 | 30 | 30 | 30 |
| Ингэ | 20-25 | 29 | 27 | 29 | 29 | 30 | 30 |
| Эм хонь | 25-30 | 39 | 66 | 69 | 71 | 71 | 75 |
| Эм ямаа | 25-30 | 40 | 69 | 71 | 72 | 73 | 79 |

**жилийн дундаж

***__Малын хэрэглээний зарлага.__*** 2016 онд оны эхний нийт малын 22.7 хувьтай тэнцэх 12.7 сая малыг хэрэглээнд зарцуулсан байна.

Малын хэрэглээний зарлага өмнөх оныхоос 1856.7 мянган толгой буюу 12.8 хувиар буурсан байна. Малын төрлөөр авч үзвэл, адууны хувьд өмнөх оныхоос 59.9 мянган толгой буюу 15.1 хувь, үхрийнх 6.7 мянган толгой буюу 0.9 хувь, тэмээнийх 6.3 мянган толгой буюу 17.3 хувь, хониных 1047.6 мянган толгой буюу 14.3 хувь, ямааных 736.1 мянган толгой буюу 12.1 хувиар тус тус буурсан байна. (Хүснэгт 43).

Малтай нэг өрх жилд дунджаар 57 толгой малыг өөрийн болон бусдын хэрэглээнд зориулан зарцуулсан дүн гарч байна.

ХҮСНЭГТ 43. МАЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРЛАГА

| | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | мянган толгой | | | | | | хувь | зөрүү |
| **Бүгд** | **8 283.2** | **8 365.0** | **10 205.0** | **10 006.4** | **14 556.7** | **12 700.0** | **87.2** | **-1 856.7** |
| Адуу | 208.9 | 238.3 | 225.8 | 238.8 | 395.6 | 335.7 | 84.9 | - 59.9 |
| Үхэр | 446.3 | 469.9 | 445.6 | 435.7 | 728.0 | 721.3 | 99.1 | - 6.7 |
| Тэмээ | 29.4 | 25.2 | 31.7 | 29.8 | 36.4 | 30.1 | 82.7 | - 6.3 |
| Хонь | 4 415.8 | 3 679.6 | 5 015.3 | 4 995.5 | 7 301.9 | 6 254.3 | 85.7 | -1 047.6 |
| Ямаа | 3182.8 | 3 952.0 | 4 486.6 | 4 306.5 | 6 094.7 | 5 358.6 | 87.9 | - 736.1 |
| | оны эхний малд эзлэх хувь | | | | | | | |
| **Бүгд** | **25.3** | **23** | **24.9** | **22.2** | **28** | **22.7** | | **- 5.3** |
| Адуу | 10.9 | 11.3 | 9.7 | 9.1 | 13.2 | 10.2 | | - 3.0 |
| Үхэр | 20.5 | 20.1 | 17.2 | 15 | 21.3 | 19.1 | | - 2.2 |
| Тэмээ | 10.9 | 9 | 10.4 | 9.3 | 10.4 | 8.2 | | - 2.2 |
| Хонь | 30.5 | 23.5 | 27.6 | 24.9 | 31.5 | 25.1 | | - 6.4 |
| Ямаа | 22.9 | 24.8 | 25.6 | 22.4 | 27.7 | 22.7 | | - 5.0 |

Хэрэглээнд зарцуулсан малын 91.4 хувийг бог мал, 8.6 хувийг бод мал эзэлж байгаа бөгөөд оны эхэнд байсан адууны 10.2 хувь, үхрийн 19.1 хувь, тэмээний 8.2 хувь, хонины 25.1 хувь, ямааны 22.7 хувийг хүнсний хэрэглээнд зарцуулсан байна (Хүснэгт 43).

Бүсээр авч үзвэл, Баруун бүсэд оны эхний малынхаа 21.1 хувь, Хангайн бүсэд 20.7 хувь, Төвийн бүсэд 24.4 хувь, Зүүн бүсэд 27.3 хувь, Улаанбаатар хотод 31.0 хувийг тус тус хэрэглээнд зарцуулсан байна (Хавсралт хүснэгт 31).

Хэрэглээнд зарцуулсан малын 33.3 хувь нь Хангайн бүсэд, 25.4 хувь нь Төвийн бүсэд, 22.7 хувь нь Баруун бүсэд, 17.6 хувь нь Зүүн бүсэд, 1.0 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна (Хавсралт хүснэгт 34).

ХҮСНЭГТ 44. МАЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРЛАГА, бүсээр

| | Бүгд | Адуу | Үхэр | Тэмээ | Хонь | Ямаа |
|---|---|---|---|---|---|---|
| | мянган толгой | | | | | |
| **БҮГД** | **12 700.1** | **335.8** | **721.3** | **30.1** | **6 254.3** | **5 358.6** |
| Баруун | 2 886.2 | 42.1 | 120.3 | 5.4 | 1 320.0 | 1 398.4 |
| Хангай | 4 233.2 | 122.9 | 256.1 | 3.7 | 2 101.7 | 1 748.8 |
| Төв | 3 221.9 | 95.3 | 170.3 | 18.5 | 1615.6 | 1 322.2 |
| Зүүн | 2 233.7 | 74.3 | 148.4 | 2.5 | 1161.4 | 847.1 |
| Улаанбаатар | 125.1 | 1.1 | 26.1 | 0.0 | 55.7 | 42.2 |
| | оны эхний малд эзлэх хувь | | | | | |
| **БҮГД** | **22.7** | **10.2** | **19.1** | **8.2** | **25.1** | **22.7** |
| Баруун | 21.0 | 7.9 | 17.8 | 6.1 | 22.9 | 21.0 |
| Хангай | 20.7 | 10.1 | 15.6 | 5.1 | 22.6 | 21.2 |
| Төв | 24.4 | 11.8 | 23.4 | 9.7 | 28.2 | 23.0 |
| Зүүн | 27.3 | 10.6 | 22.9 | 14.5 | 29.1 | 30.1 |
| Улаанбаатар | 31.0 | 3.0 | 30.3 | 0.0 | 34.3 | 35.6 |

2016 онд нийт 6803.2 мянган толгой малыг зах зээлд худалдан борлуулж, 3422.9 мянган толгой малыг аж ахуйн дотоодод хэрэглэсэн байна. (Хүснэгт 45).

ХҮСНЭГТ 45. ЗАХ ЗЭЭЛД ХУДАЛДАН БОРЛУУЛСАН БОЛОН АЖ АХУЙН ДОТООДОД ХЭРЭГЛЭСЭН МАЛЫН ТОО

| | Зах зээлд худалдан борлуулсан | | | | | Аж ахуйн дотоодод хэрэглэсэн | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
| | мянган толгой | | | | | | | | | |
| **Бүгд** | **3 980.0** | **4 611.3** | **4 993.0** | **6 650.9** | **6 803.2** | **2 530.4** | **2 751.9** | **2 842.6** | **3 287.0** | **3 422.9** |
| Адуу | 148.9 | 155.6 | 177.1 | 234 | 267.9 | 79.6 | 77.9 | 81.4 | 93.2 | 101.2 |
| Үхэр | 244.2 | 249.5 | 276 | 383.3 | 450.7 | 144.3 | 145.5 | 152.2 | 179.2 | 197.9 |
| Тэмээ | 15.6 | 17.6 | 18.5 | 18.5 | 19.0 | 7.9 | 8.2 | 8.0 | 8.4 | 8.7 |
| Хонь | 1 873.5 | 2 303.2 | 2564.4 | 3 467.4 | 3 506.0 | 1 103.3 | 1 255.0 | 1 303.1 | 1 522.6 | 1 571.7 |
| Ямаа | 1 697.8 | 1 885.4 | 1956.9 | 2 547.7 | 2 559.6 | 1 195.2 | 1 265.2 | 1 297.4 | 1 483.6 | 1 543.4 |

Малтай нэг өрх дунджаар 30 толгой малыг зах зээлд борлуулж, мөн 15 толгой малыг өөрийн хүнсэндээ хэрэглэжээ.

***Сүргийн бүтэц.*** 2016 оны байдлаар нийт сүргийн 31.6 хувь буюу 19445.3 мянган толгой нь төл, өсвөр насны мал, 24.6 хувь буюу 15134.3 мянган толгой нь нас гүйцсэн эр мал, 43.0 хувь буюу 26477.2 мянган толгой нь хээлтэгч мал, 0.8 хувь буюу 492.5 мянган толгой нь хээлтүүлэгч мал байна (Хүснэгт 46).

## ХҮСНЭГТ 46. СҮРГИЙН БҮТЭЦ, 2016 ОН

| | Бүгд | Төл, өсвөр насны мал | Нас гүйцсэн эр мал | Хээлтэгч | Хээлтүүлэгч |
|---|---|---|---|---|---|
| | | мянган толгой | | | |
| **Бүгд** | **61 549.2** | **19 445.3** | **15 134.3** | **26 477.2** | **492.5** |
| Адуу | 3 635.5 | 1 530.1 | 864.8 | 1 113.5 | 127.1 |
| Үхэр | 4 080.9 | 1 840.0 | 599.9 | 1 587.8 | 53.2 |
| Тэмээ | 401.3 | 174.0 | 83.3 | 139.4 | 4.6 |
| Хонь | 27 856.6 | 8 902.8 | 6 207.3 | 12 578.6 | 167.9 |
| Ямаа | 25 574.9 | 6 998.5 | 7 378.9 | 11 057.8 | 139.7 |
| | дүнд эзлэх хувь | | | | |
| **Бүгд** | **100.0** | **31.6** | **24.6** | **43.0** | **0.8** |
| Адуу | 100.0 | 42.1 | 23.8 | 30.6 | 3.5 |
| Үхэр | 100.0 | 45.1 | 14.7 | 38.9 | 1.3 |
| Тэмээ | 100.0 | 43.4 | 20.8 | 34.7 | 1.2 |
| Хонь | 100.0 | 32.0 | 22.3 | 45.2 | 0.6 |
| Ямаа | 100.0 | 27.4 | 28.9 | 43.2 | 0.5 |

Малын нас, хүйсээр нийт сүрэгт эзлэх хувийн жинг өмнөх оныхтой харьцуулж үзэхэд 2016 оны байдлаар төл, өсвөр насны малын сүрэгт эзлэх хувь 1.5 пунктээр буурч, хээлтэгчийн эзлэх хувь 0.4 пункт, нас гүйцсэн эр малын эзлэх хувь 1.2 пунктээр өсөж, хээлтүүлэгчийн эзлэх хувь өөрчлөлтгүй байна.

1966-1968 оны төлөвлөгөөт эдийн засгийн үеийнхтэй зэрэгцүүлж үзвэл сүргийн бүтцэд гарсан нэг томоохон өөрчлөлт нь үхэр сүрэг, бог малд эр, сувай малын нөөцтэй болсон явдал юм. Бог малд эр, сувай малын эзлэх хэмжээ 1966-1968 онд 12.2-13.0 хувь байсан бол 2016 онд 18.0-20.4 хувь болж 1.5-2.7 дахин нэмэгджээ. Энэ хугацаанд үхэр сүрэгт хээлтүүлэгчээс бусад нас гүйцсэн эр малын 9.2 хувь эзэлж байснаа 14.7 хувь болж нэмэгдсэн байна (Хүснэгт 46).

## ХҮСНЭГТ 46. СҮРГИЙН БҮТЭЦ, хувиар

| | Адуу | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 1966-1968** | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
| **Бүгд** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** |
| Төл, өсвөр насны | 31.6 | 39.4 | 41.4 | 42.7 | 43.1 | 42.1 |
| Нас гүйцсэн эр | 37.7 | 26.7 | 25 | 23.8 | 23.3 | 23.8 |
| Хээлтэгч | 27.9 | 30.1 | 30 | 29.9 | 30 | 30.6 |
| Хээлтүүлэгч | 2.8 | 3.8 | 3.6 | 3.6 | 3.5 | 3.5 |
| | Үхэр | | | | | |
| | 1966-1968** | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
| **Бүгд** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** |
| Төл, өсвөр насны | 46.5 | 45.5 | 46.4 | 46.7 | 46.6 | 45.1 |
| Нас гүйцсэн эр | 9.2 | 12.7 | 12.7 | 13 | 13.5 | 14.7 |
| Хээлтэгч | 42.5 | 40.5 | 39.6 | 39 | 38.6 | 38.9 |
| Хээлтүүлэгч | 1.8 | 1.3 | 1.3 | 1.3 | 1.3 | 1.3 |

| | 1966-1968** | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
|---|---|---|---|---|---|---|
| | Тэмээ | | | | | |
| **Бүгд** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** |
| Төл, өсвөр насны | 31.7 | 40.7 | 44.9 | 43.9 | 43.6 | 43.4 |
| Нас гүйцсэн эр | 13.0 | 23.6 | 19.1 | 20.5 | 20.5 | 20.8 |
| Хээлтэгч | 54.0 | 34.4 | 34.8 | 34.4 | 34.7 | 34.7 |
| Хээлтүүлэгч | 1.3 | 1.3 | 1.2 | 1.2 | 1.2 | 1.1 |
| | Хонь | | | | | |
| | 1966-1968** | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
| **Бүгд** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | 100.0 |
| Төл, өсвөр насны | 34.5 | 33.3 | 33.7 | 33.5 | 33.4 | 32.0 |
| Нас гүйцсэн эр | 12.2 | 20.5 | 20.3 | 20.7 | 21.1 | 22.3 |
| Хээлтэгч | 51.9 | 45.5 | 45.3 | 45.1 | 44.9 | 45.1 |
| Хээлтүүлэгч | 1.4 | 0.7 | 0.7 | 0.6 | 0.6 | 0.6 |
| | Ямаа | | | | | |
| | 1966-1968** | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
| **Бүгд** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** |
| Төл, өсвөр насны | 31.7 | 30.7 | 30.6 | 30.2 | 29.2 | 27.4 |
| Нас гүйцсэн эр | 13.0 | 25.1 | 25.7 | 26.4 | 27.5 | 28.9 |
| Хээлтэгч | 54.0 | 43.6 | 43.1 | 42.8 | 42.7 | 43.2 |
| Хээлтүүлэгч | 1.3 | 0.6 | 0.6 | 0.6 | 0.6 | 0.5 |

** жилийн дундаж

Сүрэгт хээлтүүлэгчээс бусад нас гүйцсэн эр малын нөөц ихэссэн нь махны үйлдвэрлэл нэмэгдүүлэхэд эергээр нөлөөлөх боловч бас анхаарах зүйл байна. 2013-2016 оны дунджийг 1966-1968 оны дундажтай харьцуулахад хээлтүүлэгчээс бусад нас гүйцсэн эр малын тоо үхэрт 2.6 дахин, хонинд 3.3 дахин, ямаанд 11.3 дахин нэмэгджээ (Хүснэгт 48). Харин энэ хугацаанд нийт ямааны тоо 4.1 дахин өссөн байхад эр ямааны тоо 11.3 дахин өссөн нь ноолуурын үйлдвэрлэл нэмэгдүүлэхэд түлхэц болсон боловч ноолуурын чанарт сөрөг нөлөөтэй байв.

ХҮСНЭГТ 48. ХЭЭЛТҮҮЛЭГЧЭЭС БУСАД НАС ГҮЙЦСЭН ЭР МАЛЫН ӨСӨЛТ

| | Жилийн дундаж | | | |
|---|---|---|---|---|
| | 1966-1968 | 2000-2002 | 2013-2016 | $\frac{2013\text{-}2016}{1966\text{-}1968}$ % |
| | мянган толгой | | | хувь |
| Үхэр | 187.2 | 361.5 | 480.9 | 256.9 |
| Хонь | 1 562.4 | 2 648.4 | 5 087.8 | 325.6 |
| Ямаа | 544.3 | 2 745.2 | 6 156.2 | 1131.0 |

### II.2.3 Эрчимжсэн мал аж ахуй

***<u>Цэвэр үүлдрийн болон эрлийз, нутгийн шилдэг омгийн мал</u>.*** Цэвэр үүлдрийн мал 2016 онд 1873.4 мянга, эрлийз 518.7 мянга, нутгийн шилдэг омгийн 1825.8 мянган, сайжруулсан нутгийн үүлдрийн 560.2 мянган толгой хонь тоологдов.

Өмнөх онтой харьцуулахад цэвэр үүлдрийн мал 2.8 хувь буюу 50.5 мянган толгойгоор, нутгийн шилдэг омгийн мал 15.4 хувь буюу 243.6 мянган толгойгоор, сайжруулсан нутгийн үүлдрийн хонь 1.6 хувь буюу 8.8 мянган толгойгоор тус тус өссөн байна. Харин эрлийз мал 12.8 хувь буюу 76.3 мянган толгойгоор буурчээ (Хүснэгт 49).

ХҮСНЭГТ 49. ЦЭВЭР ҮҮЛДРИЙН БОЛОН ЭРЛИЙЗ, НУТГИЙН ШИЛДЭГ ОМГИЙН МАЛЫН ТОО

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мянган толгой | | | | | хувь | зөрүү |
| **Цэвэр үүлдрийн** | **1 261.9** | **1 195.9** | **1 404.4** | **1 822.9** | **1 873.4** | **102.8** | **50.5** |
| Үхэр | 42.4 | 41.2 | 46.5 | 67.0 | 76.1 | 113.6 | 9.1 |
| Хонь | 933 | 949.1 | 1 234.9 | 1 561.1 | 1625 | 104.1 | 63.9 |
| Ямаа | 286.5 | 205.5 | 123.0 | 194.8 | 172.3 | 88.4 | -22.5 |
| **Эрлийз** | **565.3** | **225.7** | **385.8** | **595.0** | **518.7** | **87.2** | **-76.3** |
| Үхэр | 68.1 | 75.6 | 99.5 | 118.3 | 110.1 | 93.1 | -8.2 |
| Хонь | 76.2 | 34.9 | 41.9 | 33.6 | 24.9 | 74.1 | -8.7 |
| Ямаа | 420.9 | 115.2 | 244.4 | 443.1 | 383.7 | 86.6 | -59.4 |
| **Нутгийн шилдэг омгийн** | **789.6** | **1 012.6** | **1 309.3** | **1 582.2** | **1 825.8** | **115.4** | **243.6** |
| Адуу | 24.1 | 79.1 | 57.2 | 87.7 | 90.7 | 103.4 | 3.0 |
| Үхэр | 5.9 | 5.5 | 8.5 | 6.2 | 5.1 | 82.3 | -1.1 |
| Тэмээ | 14.3 | 16.4 | 14.4 | 20.4 | 17.5 | 85.8 | -2.9 |
| Хонь | 132.9 | 82.9 | 125.2 | 256.0 | 381.1 | 148.9 | 125.1 |
| Ямаа | 612.6 | 828.6 | 1 104.0 | 1 211.9 | 1 331.4 | 109.9 | 119.5 |
| **Сайжруулсан нутгийн үүлдрийн** | **984.2** | **498.8** | **530.1** | **551.4** | **560.2** | **101.6** | **8.8** |
| Хонь | 984.2 | 498.8 | 530.1 | 551.4 | 560.2 | 101.6 | 8.8 |

Нийт малын 3.0 хувийг цэвэр үүлдрийн мал, 0.8 хувийг эрлийз мал, 3.0 хувийг нутгийн шилдэг омгийн мал эзэлж байгаа бол нийт хонин сүргийн 2.0 хувийг сайжруулсан нутгийн үүлдрийн хонь тус тус эзэлж байна.

### II.2.4 Малын бэлчээр, тэжээлийн хүрэлцээ, хангамж

***Бэлчээрийн хүрэлцээ.*** Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын 2016 оны газрын нэгдмэл сангийн урьдчилсан тайлангаар манай улсын бэлчээр хадлангийн талбай 112.2 сая га байгаа нь өмнөх оныхоос 0.1 сая га буюу 0.1 хувиар буурч, 1964 оныхоос 8.1 хувь буюу 9.9 сая га-гаар буурчээ (Хүснэгт 50).

100 га хадлан, бэлчээрийн талбайд хонин толгойд шилжүүлснээр 2016 онд 92 толгой мал ногдож байгаа нь өмнөх оныхоос 9 толгойгоор өссөн байна.

ХҮСНЭГТ 50. БЭЛЧЭЭРИЙН ХҮРЭЛЦЭЭ ХАНГАМЖ

| | 1964 | 2013 | 2014 | 2015 | 2016 | Өөрчлөлт, 1964 оноос | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хувь | зөрүү |
| Бэлчээр, хадлангийн талбай, сая га | 122.1 | 112.7 | 112.4 | 112.3 | 112.2 | 91.9 | -9.9 |
| Хонин толгойд шилжүүлсэн малын тоо, сая толгой | 49.3 | 74.7 | 86.2 | 93.8 | 102.8 | 208.5 | 53.5 |
| 100 га бэлчээр хадлангийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо | 40 | 66 | 77 | 83 | 92 | 229 | -52 |

Өнгөрсөн 52 жилийн хугацаанд буюу 1964 оныхтой харьцуулбал бэлчээрийн талбай 9.9 сая га-гаар багасаж, хонин толгойд шилжүүлсэн нийт малын тоо 53.5 сая толгойгоор өссөн байна. Үүнтэй холбогдон 100 га бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо 2.3 дахин нэмэгджээ.

ЗУРАГ 19. 100 ГА БЭЛЧЭЭРИЙН ТАЛБАЙД НОГДОХ ХОНИН ТОЛГОЙД ШИЛЖҮҮЛСЭН МАЛЫН ТОО




100 га бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо Орхон аймагт 743, Улаанбаатар хотод 525, Дархан-Уул аймагт 354, Архангай аймагт 262, Булган аймагт 250, Хөвсгөл аймагт 190, Сэлэнгэ аймагт 186 толгой байгаа нь улсын дунджаас 2.0-8.1 дахин өндөр байна (Хавсралт хүснэгт 39).

Бүсээр авч үзвэл, Хангайн бүс, Улаанбаатар хотод 100 га бэлчээрийн талбайд хонин толгойд шилжүүлснээр 156-525 толгой мал ногдож байгаа нь улсын дунджаас 64-433 толгойгоор өндөр байна. Дээрх байдлаас үзэхэд төвлөрсөн хот, суурин газар, мал ихтэй бүс нутаг, аймагт бэлчээрийн даац хэтэрсэн хэвээр байна (Хавсралт хүснэгт 39).

***Малын тэжээлийн үйлдвэрлэл, хангамж.*** Улсын хэмжээгээр 2016 онд тэжээлийн нэгжид шилжүүлснээр 697.7 мянган тонн тэжээл үйлдвэрлэсэн нь өмнөх оныхоос 20.9 хувь буюу 120.8 мянган тонноор өссөн байна (Хүснэгт 51).

Бэлтгэсэн тэжээлийг нэр төрлөөр, өмнөх оныхтой харьцуулан авч үзвэл бэлтгэсэн дарш 2.1 дахин, байгалийн хадлан 24.0 хувиар, гар тэжээл 14.8 хувиар, сүрэл 7.1 хувиар, эрдэс тэжээл 2.4 хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 51. БЭЛТГЭСЭН ТЭЖЭЭЛ, нэр төрлөөр

| | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2016/2015 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мянган тонн | | | | | | хувь |
| Байгалийн хадлан | 1 195.2 | 1 175.1 | 1 169.3 | 1 178.7 | 1 028.7 | 1275.4 | 124.0 |
| Сүрэл | 7.9 | 4.6 | 3.1 | 7.9 | 8.5 | 9.1 | 107.1 |
| Гар тэжээл | 46.7 | 39.1 | 36.6 | 40.3 | 39.9 | 45.8 | 114.8 |
| Бэлтгэсэн дарш | 8.5 | 2.1 | 3.9 | 4.0 | 1.6 | 3.4 | 212.5 |
| Эрдэс тэжээл | 55.6 | 36.6 | 31.8 | 29.7 | 61.3 | 62.8 | 102.4 |
| Үйлдвэрлэсэн тэжээл-бүгд, (тэжээлийн нэгж) | 663.2 | 624.6 | 609.8 | 614.0 | 576.9 | 697.7 | 120.9 |

Тэжээл бэлтгэлтийн хэмжээ /тэжээлийн нэгжээр/ 2016 онд Хэнтий, Өвөрхангай, Дархан-Уул аймгуудад өмнөх оныхоос 0.3-3.4 мянган тонноор буурч, Улаанбаатар хот болон бусад аймагт 0.8-28.6 мянган тонноор өссөн байна (Хавсралт хүснэгт 40).

ЗУРАГ 20. БЭЛТГЭСЭН ХАДЛАН, мянган тонн



Тэжээл үйлдвэрлэлийн хэмжээ /тэжээлийн нэгжээр/ бүх бүс, Улаанбаатар хотод 7.6-78.3 хувь буюу 5.2-46.0 мянган тонноор өссөн байна (Хавсралт хүснэгт 40).

Бэлтгэсэн тэжээлийн хэмжээнд үйлдвэрийн аргаар боловсруулсан тэжээлийн хэмжээ ороогүй, зөвхөн малчид, аж ахуйн нэгжүүдийн гар аргаар бэлтгэсэн тэжээлийн хэмжээ орсон болно.

ХҮСНЭГТ 52. БЭЛТГЭСЭН ТЭЖЭЭЛ, бүсээр

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | Дүнд эзлэх |
|---|---|---|---|---|---|---|
| | тэжээлийн нэгж | | | | | хувь |
| **Бүгд** | **624 601.0** | **609 790.5** | **613 968.5** | **576 855.0** | **697 717.2** | **100.0** |
| Баруун | 109 702.4 | 109 170.0 | 108 949.2 | 101 266.9 | 118 254.2 | 16.9 |
| Хангай | 200 804.5 | 209 362.0 | 209 182.9 | 193 683.0 | 238 297.0 | 34.2 |
| Төв | 201 503.2 | 185 538.2 | 193 418.6 | 168 765.1 | 214 769.6 | 30.8 |
| Зүүн | 102 439.7 | 96 873.5 | 95 955.0 | 106 510.0 | 114 572.0 | 16.4 |
| Улаанбаатар | 10 151.2 | 8 846.7 | 6 462.7 | 6 630.1 | 11 824.4 | 1.7 |

Нийт тэжээлийн 34.2 хувь нь Хангайн бүсэд, 30.8 хувь нь Төвийн бүсэд, 16.9 хувь нь Баруун бүсэд, 16.4 хувь нь Зүүн бүсэд, 1.7 хувь нь Улаанбаатар хотод бэлтгэгдсэн байна (Хавсралт хүснэгт 40).

ХҮСНЭГТ 53. ҮЙЛДВЭРЛЭСЭН ТЭЖЭЭЛИЙН ХАНГАМЖ

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
|---|---|---|---|---|---|
| Хонин толгойд шилжүүлсэн мал, мянган толгой | 67 294.1 | 74 771.0 | 86 222.7 | 93 766.5 | 102 814.8 |
| Хонин толгойд шилжүүлсэн нэг малд ногдох тэжээл, тэжээлийн нэгж, кг | 9.3 | 8.2 | 7.1 | 6.2 | 6.8 |

2016 онд хонин толгойд шилжүүлсэн нэг малд 6.8 кг тэжээл ногдож байгаа нь өмнөх оныхоос 0.6 кг-аар нэмэгдэв.

### II.2.5 Тэжээвэр амьтад

2016 онд 31.5 мянган гахай, 718.7 мянган шувуу, 2044 цаа буга, 40 илжиг, 527 туулай, 8.1 мянган бүл зөгий тоологдсон бөгөөд өмнөх оныхтой харьцуулахад цаа буга 180 толгой, зөгий 80 бүл, илжиг 17 толгой, туулай 10 толгойгоор нэмэгдэж, гахай 2.0 мянган толгой, шувуу 86.4 мянган толгойгоор буурсан байна (Хүснэгт 54).

Тэжээвэр амьтдын дундаас гахай, шувууны аж ахуйг бусад аж ахуйгаас илүүтэйгээр эрхэлж байгаа бөгөөд 2016 онд гахайг 1.0 мянган өрх, шувууг 1.6 мянган өрх өсгөн үржүүлж байна.

ХҮСНЭГТ 54. ТЭЖЭЭВЭР АМЬТАД, ТЭДГЭЭРИЙГ ӨСГӨН ҮРЖҮҮЛДЭГ ӨРХИЙН ТОО

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
|---|---|---|---|---|---|
| Гахай, мянган толгой | 40.4 | 51.9 | 46.3 | 33.5 | 31.5 |
| Шувуу, мянган толгой | 469.4 | 489.3 | 794.6 | 805.1 | 718.7 |
| Цаа буга | 1 421 | 1 574 | 1 759 | 1 864 | 2044 |
| Илжиг | 75 | 51 | 40 | 23 | 40 |
| Зөгий, бүл | 2 128 | 3 677 | 6 645 | 8 038 | 8 118 |
| Туулай | 1 533 | 1 262 | 1 102 | 517 | 527 |
| Гахайтай өрхийн тоо, мянгаар | 2.2 | 2.9 | 2.5 | 1.4 | 1.0 |
| Шувуутай өрхийн тоо, мянгаар | 1.6 | 1.7 | 1.8 | 1.7 | 1.6 |

Өсгөн үржүүлж байгаа гахайны 64.2 хувь нь Улаанбаатар хотод, 23.8 хувь нь Төвийн бүсэд, 6.4 хувь нь Хангайн бүсэд, 3.4 хувь нь Зүүн бүсэд, 2.1 хувь нь Баруун бүсэд ногдож байна. Шувууны 37.9 хувь нь Төвийн бүсэд, 58.2 хувь Улаанбаатар хотод байна (Хавсралт хүснэгт 45).

ХҮСНЭГТ 55. ТЭЖЭЭВЭР АМЬТАД, бүсээр, эзлэх хувь

| | Гахай | мэгж | Шувуу | өндөглөгч | Гахай | Шувуу |
|---|---|---|---|---|---|---|
| | Толгой | | | | дүнд эзлэх хувь | |
| **Бүгд** | **31 489** | **9 836** | **718 658** | **577 352** | **100.0** | **100.0** |
| Баруун | 668 | 265 | 7 286 | 6 791 | 2.1 | 1.0 |
| Хангай | 2 017 | 545 | 4 856 | 3 970 | 6.4 | 0.5 |
| Төв | 7 495 | 2 201 | 271 952 | 262 216 | 23.8 | 37.9 |
| Зүүн | 1 083 | 437 | 16 886 | 15 834 | 3.4 | 2.4 |
| Улаанбаатар | 20 226 | 6 388 | 417 678 | 288 541 | 64.2 | 58.2 |

## II.2.6 Хашаа, худгийн тооллого

ҮСХ-ноос хашаа, худгийн тооллогыг 3 жил тутамд мал тооллоготой хамтатган явуулж байна. 2015 оны тооллогоор хүн, мал ундаалах зориулалт бүхий 42.1 мянган худаг, 269 усан сан тоологдлоо. Тоологдсон худгийн 36.6 хувь буюу 15.4 мянга нь инженерийн хийцтэй худаг байна. Нийт худгийн 51.6 хувь буюу 21.7 мянган худаг нь бэлчээрт байршилтай байна (Хүснэгт 45).

ХҮСНЭГТ 56. ХУДАГ, УСАН САНГИЙН ТОО, тооллого явагдсан оноор

| | 2006 | 2009 | 2012 | 2015 |
|---|---|---|---|---|
| | мянган ширхэг | | | |
| **Худаг – бүгд** | **38.7** | **42.3** | **29.5** | **42.1** |
| Инженерийн хийцтэй | 10.1 | 10.2 | 8.1 | 15.4 |
| Энгийн уурхайн | 28.6 | 32.1 | 21.4 | 26.7 |
| Бэлчээрт байршилтай | 24.8 | 26.8 | 21.5 | 21.7 |
| Ашиглагддаггүй | 4.8 | 3 | 0.6 | 1.1 |
| **Усан сан** | **0.8** | **0.5** | **0.2** | **0.3** |
| Багтаамж /мянган $м^3$/ | 71.8 | 92.5 | 98.8 | 109.8 |

2015 онд 66.8 сая толгой малын багтаамж бүхий 209.0 мянган хашаа тоологдсон байна. Нийт тоологдсон хашааны 16.1 хувь буюу 33.6 мянга нь 6.1 сая малын багтаамжтай дулаан байр, 57.0 хувь буюу 119.1 мянга нь 40.1 сая малын багтаамжтай саравчтай хашаа, 27.0 хувь буюу 56.4 мянга нь 20.6 сая малын багтаамжтай саравчгүй хашаа тус тус байна. Нийт хашааны 10.5 хувь буюу 21.9 мянга нь 3.7 сая малын багтаамжтай бод малын хашаа байна.

ХҮСНЭГТ 57. МАЛЫН ХАШААНЫ ТОО, ХАНГАМЖ, тооллого явагдсан оноор

| | 2006 | 2009 | 2012 | 2015 |
|---|---|---|---|---|
| | мянган ширхэг | | | |
| **Хашаа-бүгд** | **129.5** | **140.7** | **167.1** | **209** |
| Багтаамж /сая толгой/ | 37.2 | 45 | 55.2 | 66.8 |
| Дулаан байр | 17.2 | 16.3 | 20.1 | 33.6 |
| Багтаамж /сая толгой/ | 3.6 | 2.9 | 3.6 | 6.1 |
| Саравчтай хашаа | 79.3 | 85 | 102.5 | 119.1 |
| Багтаамж /сая толгой/ | 21.5 | 28.4 | 35.5 | 40.1 |
| Саравчгүй хашаа | 33 | 39.3 | 44.4 | 56.4 |
| Багтаамж /сая толгой/ | 12.1 | 13.6 | 16.1 | 20.6 |
| **Нийт хашаанаас** | | | | |
| Бодын | 30.9 | 32.3 | 31.7 | 21.9 |
| Багтаамж /сая толгой/ | 3.4 | 3.4 | 7.8 | 3.7 |
| **Хашааны хангамж:** | | | | |
| бог малын /хувь/ | 112 | 113.3 | 132.9 | 130.1 |
| бод малын /хувь/ | 156.8 | 130 | 148.5 | 97.2 |

## II.3 Мал эмнэлгийн үйлчилгээ

ХХААХҮЯ-ны Мал эмнэлэг, үржлийн газрын мэдээгээр 2016 онд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд давхардсан тоогоор 36.8 сая толгой мал хамрагдаж, нэг малд 145 төгрөг, лабораторийн оношилгоо, шинжилгээнд давхардсан тоогоор 0.4 сая толгой мал хамрагдаж, нэг малд 1.8 мянган төгрөг, гоц халдварт өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтад давхардсан тоогоор 26.8 сая толгой мал хамрагдаж, нэг малд 626 төгрөгийг тус тус зарцуулсан байна (Хүснэгт 58).

ХҮСНЭГТ 58. МАЛ ЭМНЭЛГИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ МЭДЭЭ

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
|---|---|---|---|---|---|
| Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ | | | | | |
| Хамрагдсан малын тоо, мян.тол | 52 760.5 | 47 318.1 | 39 671.6 | 38 703.0 | 36 795.4 |
| Зарцуулсан зардал, сая төгрөг | 10 517.3 | 8 217.9 | 5 905.2 | 7 976.6 | 5 328.5 |
| 1 малд ногдох зардал, төг | 119.3 | 173.7 | 149 | 206.1 | 144.8 |
| Лабораторийн оношилгоо, шинжилгээ | | | | | |
| Хамрагдсан малын тоо, мян.тол | 718 | 489.2 | 627.5 | 404.3 | 401.5 |
| Зарцуулсан зардал, сая төгрөг | 437.9 | 691.6 | 20 204.6 | 755.3 | 735.5 |
| 1 малд ногдох зардал, төг | 610 | 1 414 | 32 199 | 1 868.3 | 1 831.9 |
| Гоц халдварт өвчний вакцинжуулалтын зардал | | | | | |
| Хамрагдсан малын тоо, мян.тол | 27 034.3 | 27 200.0 | 14 840 | 6 595.0 | 26 816.0 |
| Зарцуулсан зардал, сая төгрөг | 4 016.4 | 4 000.0 | 2 305.9 | 4 330.0 | 16 777.9 |
| 1 малд ногдох зардал, төг | 148.6 | 147 | 155.3 | 656.5 | 625.7 |

Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны мэдээ

## II.4 Малын индексжүүлсэн даатгалын үйлчилгээ

ҮСХ нь Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн Банктай хамтран 2005 оны 7-р сараас эхлэн “Малын Индексжүүлсэн Даатгал” (МИД) төслийг Хэнтий, Баянхонгор, Увс аймгуудад хэрэгжүүлснээс хойших хугацаанд уг төслийн нэгжтэй хамтран ажиллаж байсан бөгөөд 2015 оноос эхлэн албан ёсны статистик мэдээлэл болсон.

Ийнхүү ҮСХ нь малчдад олгох даатгалын нөхөн төлбөрийн хэмжээг тооцоход шаардагдах мэдээллээр хангах зорилгоор хагас жилийн мал тооллогын түүвэр судалгааг бүх аймаг, нийслэл, сум, дүүргийг хамруулан явуулж байна.

ХҮСНЭГТ 59. ДААТГАЛД ХАМРАГДСАН ӨРХ, малын тоо

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
|---|---|---|---|---|---|
| Даатгуулсан өрхийн тоо | 15 988 | 19 445 | 14 331 | 10 317 | 18 738 |
| Мал бүхий өрхөд эзлэх хувь | 7.7 | 9.3 | 6.7 | 4.8 | 8.4 |
| Даатгуулсан малын тоо, мян.тол | 2 461.7 | 3 487.0 | 3 257.7 | 2 657.9 | 4185.2 |
| Оны эхний малд эзлэх хувь | 6.8 | 8.5 | 7.2 | 5.1 | 7.5 |
| Даатгалд төлсөн хураамж, сая.төг | 1 469.8 | 1 799.0 | 1 374.1 | 1 301.5 | 1 774.1 |
| Даатгалаас олгосон нөхөн олговор, сая төгрөг | 278.9 | 40.6 | 62.8 | 413.6 | - |

Эх сурвалж: ХАА-н давхар даатгал ХК

ХАА-н давхар даатгал ХК-иас гаргасан мэдээгээр 2016 онд 18.7 мянган өрхийн 4.2 сая толгой малыг индексжүүлсэн даатгалд хамруулсан байна. 2016 онд даатгуулсан өрх нийт малтай өрхийн 8.4 хувийг эзэлж, 2015 оныхоос 81.6 хувиар буюу 8.4 мянган өрхөөр өсөв.

Мөн 2016 онд оны эхний малын 7.5 хувьтай тэнцэх 4185.2 мянган толгой малыг даатгалд хамруулж, 2015 оныхоос 1.5 мянган толгой буюу 57.5 хувиар өссөн байна.

## III. ГАЗАР ТАРИАЛАН

### III.1 Тариалсан талбай

***Тариалсан талбай***. Улсын хэмжээгээр 2016 онд нийт 505.3 мянган га-д тариалалт хийсэн нь өмнөх оныхоос 19.7 мянган га буюу 3.7 хувиар буурчээ.

ХҮСНЭГТ 60. ТАРИАЛСАН ТАЛБАЙ

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мянган га | | | | | хувь | зөрүү |
| Нийт тариалсан талбай | 379.8 | 415.4 | 440.6 | 525.0 | 505.3 | 96.3 | -19.7 |
| Үр тариа | 306.2 | 293.3 | 315.0 | 390.7 | 377.8 | 96.7 | -12.9 |
| Буудай | 297.3 | 275.6 | 291.2 | 361.2 | 355.1 | 98.3 | -6.1 |
| Төмс | 16.8 | 15.5 | 13.2 | 12.8 | 15.0 | 117.0 | 2.2 |
| Хүнсний ногоо | 7.9 | 8.3 | 8.7 | 7.7 | 9.1 | 118.2 | 1.4 |
| Тэжээлийн ургамал | 13.8 | 14.4 | 17.0 | 23.8 | 29.9 | 125.4 | 6.1 |
| Техникийн ургамал | 33.2 | 83.9 | 86.7 | 84.5 | 66.2 | 78.4 | -18.3 |
| Жимс, жимсгэнэ | 1.9 | 2.7 | 2.7 | 2.7 | 3.0 | 111.1 | 0.3 |

2016 онд тариалсан талбайг ургамлын нэр төрлөөр авч үзвэл, төмсний тариалсан талбай 2015 оныхоос 2.2 мянган га-аар буюу 17.0 хувиар, хүнсний ногооных 1.4 мянган га-аар буюу 18.2 хувиар, тэжээлийн ургамлынх 6.1 мянган га-аар буюу 25.4 хувиар, жимс жимсгэнийнх 0.3 га-аар буюу 11.1 хувиар нэмэгдэж, үр тарианых 12.9 мянган га-аар буюу 3.3 хувиар, техникийн ургамлынх 18.3 мянган га-аар буюу 21.6 хувиар буурчээ. (Хүснэгт 60).

ЗУРАГ 21. ҮР ТАРИА, ТӨМС, ХҮНСНИЙ НОГООНЫ ТАРИАЛСАН ТАЛБАЙ




2016 онд тариалсан талбайн 74.8 хувийг үр тариа, 3.0 хувийг төмс, 1.8 хувийг хүнсний ногоо, 5.9 хувийг тэжээлийн ургамал, 13.1 хувийг техникийн ургамал, 1.4 хувийг эмийн ургамал эзэлж байна. Үүнийг 2015 оныхтой харьцуулахад нийт тариалсан талбайд хүнсний ногооны тариалсан талбайн эзлэх хувь 0.3 пунктээр, төмснийх 0.6 пунктээр, тэжээлийн ургамлынх 1.4 пунктээр, үр тарианых 0.4 пунктээр өсөж, техникийн ургамлынх 3.0 пунктээр буурсан байна.

Нийт тариалсан талбайг бүсээр авч үзвэл, Хангайн болон Зүүн бүсэд 1.6-8.4 хувиар өсөж, Төвийн, Баруун бүс болон Улаанбаатарт 5.2-8.1 хувиар буурсан байна (Хүснэгт 61).

ХҮСНЭГТ 61. НИЙТ ТАРИАЛСАН ТАЛБАЙ, бүсээр

| Бүс | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | Өсөлт/бууралт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мянган га | | | | | хувь | зөрүү |
| **Бүгд** | **379.8** | **415.4** | **440.6** | **525.0** | **505.3** | **96.3** | **-19.7** |
| Баруун | 20.8 | 19.9 | 17.5 | 14.8 | 14.0 | 94.8 | -0.8 |
| Хангайн | 66.2 | 60.7 | 66.3 | 76.9 | 83.3 | 108.4 | 6.4 |
| Төвийн | 257.7 | 287.1 | 294.3 | 337.6 | 310.8 | 92.1 | -26.7 |
| Зүүн | 33.6 | 46.5 | 61.2 | 94.6 | 96.0 | 101.6 | 1.5 |
| Улаанбаатар | 1.4 | 1.2 | 1.3 | 1.2 | 1.1 | 91.9 | -0.1 |

2016 онд тариалалт хийсэн нийт талбайг аж ахуйн төрлөөр нь авч үзвэл, ААНБ-д үр тарианы талбайн 93.2 хувь, тэжээлийн ургамлын талбайн 75.3 хувь нь ногдож байгаа бол иргэд, өрхийн аж ахуйд төмсний талбайн 72.9 хувь, хүнсний ногооны 82.1 хувь, тэжээлийн ургамлын 24.7 хувь нь тус тус ногдож байна (Хүснэгт 62).

ХҮСНЭГТ 62. ТАРИАЛСАН ТАЛБАЙ, 2016 ОН, аж ахуй, ургамлын төрлөөр

| | Үр тариа | Төмс | Хүнсний ногоо | Тэжээлийн ургамал | Үр тариа | Төмс | Хүнсний ногоо | Тэжээлийн ургамал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | мянган га | | | | дүнд эзлэх хувь | | | |
| **Бүгд** | **377.8** | **15.0** | **9.1** | **29.9** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** |
| Аж ахуйн нэгж, байгууллага | 352.1 | 4.1 | 1.6 | 22.5 | 93.2 | 27.1 | 17.9 | 75.3 |
| Иргэд, өрхийн аж ахуй | 25.7 | 11.0 | 7.4 | 7.4 | 6.8 | 72.9 | 82.1 | 24.7 |

Тариалан эрхэлдэг өрхийн тоо 2015 онд 18440 байсан бол 2016 онд 17145 болж 1295 буюу 7.0 хувиар буурч, харин аж ахуйн нэгж, байгууллагын тоо 1414-т хүрч, өмнөх оныхоос 19-өөр буюу 1.4 хувиар нэмэгджээ (Хүснэгт 63).

ХҮСНЭГТ 63. ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХ, АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА, бүсээр

| Бүс | 2014 | | 2015 | | 2016 | | 2016/2015 | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Өрх | ААНБ | Өрх | ААНБ | Өрх | ААНБ | Өрх | ААНБ |
| | | | | | | | хувь | |
| **Бүгд** | **20 459** | **1 352** | **18 440** | **1 395** | **17 145** | **1 414** | **93.0** | **101.4** |
| Баруун | 3 212 | 193 | 3 344 | 174 | 3 099 | 166 | 92.7 | 95.4 |
| Хангайн | 4 414 | 255 | 3 641 | 263 | 3 332 | 307 | 91.5 | 116.7 |
| Төвийн | 8 451 | 729 | 7 819 | 758 | 7 466 | 745 | 95.5 | 98.3 |
| Зүүн | 1 926 | 117 | 1 670 | 135 | 1 549 | 156 | 92.8 | 115.6 |
| Улаанбаатар | 2 456 | 58 | 1 966 | 65 | 1 699 | 40 | 86.4 | 61.5 |

Үр тариа тариалсан талбай 2016 онд Булган, Төв, Сэлэнгэ, Баян-Өлгий, Хэнтий, Дорнод, Увс, Дархан-Уул, Баянхонгор, Завхан аймгуудад өмнөх оныхоос 0.1-49.1 хувиар буурч харин Сүхбаатар, Хөвсгөл, Архангай, Говь-Алтай, Өвөрхангай, Ховд, Орхон аймгуудад 1.1-45.1 хувиар өссөн байна (Хавсралт хүснэгт 55).

Төмс тариалсан талбай Улаанбаатар хот болон Баян-Өлгий, Өвөрхангай, Говь-Алтай, Булган, Завхан, Дорноговь, Хэнтий, Дундговь, Сэлэнгэ, Хөвсгөл, Увс, Дорнод, Өмнөговь, Төв, Орхон, Дархан-Уул аймгуудад 0.1-73.4 хувиар, Говьсүмбэр аймагт 2.8 дахин нэмэгдэж, Архангай, Баянхонгор, Ховд, Сүхбаатар аймгуудад 2.4-13.3 хувиар буурсан байна (Хавсралт хүснэгт 55).

Жимс, жимсгэнэ тариалсан талбай Баян-Өлгий, Өмнөговь, Өвөрхангай, Завхан, Говь-Алтай, Дундговь аймгуудад 5.8-90.9 хувиар, Архангай, Ховд, Төв, Булган, Дорнод аймгуудад 2.6-13.5 дахин нэмэгдэж, Баянхонгор, Сэлэнгэ, Увс, Дархан-Уул, Орхон, Хэнтий аймгууд болон Улаанбаатар хотод 3.5-54.0 хувиар буурсан байна (Хавсралт хүснэгт 58).

Байцаа тариалалт Улаанбаатар хот болон Хэнтий, Хөвсгөл, Увс, Өвөрхангай, Дорнод, Орхон, Булган, Дундговь, Төв аймгуудад 0.8-57.9 хувиар, Говьсүмбэр, Дорноговь аймагт 4.2-6.1 дахин нэмэгдэж, Өмнөговь, Говь-Алтай, Архангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Дархан-Уул, Завхан, Баян-Өлгий, Ховд, Баянхонгор аймагт 0.7-63.9 хувиар буурсан байна (Хавсралт хүснэгт 55).

Лууван тариалсан талбай Өвөрхангай, Хөвсгөл, Завхан, Булган, Төв, Дундговь, Орхон, Сэлэнгэ, Увс, Дархан-Уул, Сүхбаатар, Хэнтий аймгуудад 0.5-92.8 хувиар, Дорноговь аймагт 2.0 дахин нэмэгдэж, Улаанбаатар хот болон Өмнөговь, Баян-Өлгий, Ховд, Баянхонгор, Говь-Алтай, Дорнод, Архангай, Говьсүмбэр аймгуудад 3.6-37.2 хувиар буурчээ (Хавсралт хүснэгт 55).

***Уринш.*** 335.6 мянган га талбайд уринш 2016 онд хийсэн нь 2015 оныхоос 0.2 мянган га-гаар буурсан байна. 2003-2007 онуудад жилд дунджаар нийт тариалсан талбайн 72.8 хувьд уринш хийж байсан бол 2016 онд тариалсан талбайн 66.4 хувьтай тэнцэх хэмжээний талбайд уринш хийсэн байна.

ЗУРАГ 22. ТАРИАЛАЛТ, УРИНШ ХИЙСЭН ТАЛБАЙ




## III.2 Газар тариалангийн үйлдвэрлэл, хураасан ургац

Газар тариалангийн салбарын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр, оны үнээр 655.6 тэрбум төгрөг, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 396.8 тэрбум төгрөгт хүрч, 2015 оныхтой харьцуулахад оны үнээр 16.7 хувиар, зэрэгцүүлэх үнээр 33.3 хувиар тус тус өссөн байна. (Хүснэгт 64).

ХҮСНЭГТ 64. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016* | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тэрбум төгрөг | | | | | хувь | зөрүү |
| Тайлант оны үнээр | 454.6 | 507.4 | 630.7 | 561.7 | 655.6 | 116.7 | 93.9 |
| 2010 оны зэрэгцүүлэх үнээр | 440.7 | 392.2 | 418.6 | 297.7 | 396.8 | 133.3 | 99.1 |

***Хураасан ургац***. Манай улс 2016 онд 483.5 мянган тонн үр тариа, 165.3 мянган тонн төмс, 94.4 мянган тонн хүнсний ногоо, 53.4 мянган тонн тэжээлийн ургамал, 21.5 мянган тонн техникийн ургамал, 1.6 мянган тонн жимс, жимсгэнэ хураасан нь 2015 оныхоос төмс 1.0 хувиар буюу 1.6 мянган тонноор, тэжээлийн ургамал 8.7 хувиар буюу 4.3 мянган тонн, үр тариа 2.2 дахин буюу 267.2 мянган тонн, хүнсний ногоо 30.5 хувиар буюу 22.1 мянган тонн, жимс, жимсгэнэ 14.3 хувь буюу 0.2 мянган тонноор өсөж, харин техникийн ургамал 7.3 хувь буюу 1.7 мянган тонноор буурсан байна (Хүснэгт 65).

ХҮСНЭГТ 65. ХУРААСАН УРГАЦ, ургамлын төрлөөр

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мянган тонн | | | | | хувь | зөрүү |
| Үр тариа | 479.3 | 387.0 | 518.8 | 216.3 | 483.5 | 223.5 | 267.2 |
| Улаан буудай | 465.3 | 368.4 | 488.3 | 203.9 | 467.1 | 229.1 | 263.2 |
| Арвай | 5.9 | 4.4 | 8.5 | 2.4 | 6.5 | 265.4 | 4.0 |
| Овьёос | 5.9 | 10.1 | 18.8 | 3.3 | 7.9 | 239.7 | 4.6 |
| Төмс | 245.9 | 191.6 | 161.5 | 163.8 | 165.3 | 101.0 | 1.6 |
| Хүнсний ногоо | 98.9 | 101.8 | 104.8 | 72.3 | 94.4 | 130.5 | 22.1 |
| Тэжээлийн ургамал | 46.2 | 42.6 | 44.3 | 49.2 | 53.4 | 108.7 | 4.3 |
| Техникийн ургамал | 21.0 | 41.7 | 52.1 | 23.1 | 21.5 | 92.7 | -1.7 |
| Жимс, жимсгэнэ | 0.6 | 1.6 | 1.2 | 1.4 | 1.6 | 114.3 | 0.2 |

ЗУРАГ 23. ХУРААСАН УРГАЦ, ургамлын төрлөөр




2016 онд хураан авсан ургацыг "Атрын III аян"-ы өмнөх таван жил буюу 2003-2007 оны дундажтай зэрэгцүүлж үзвэл хураасан үр тариа 3.8 дахин буюу 357.0 мянган тонн, төмс 77.6 хувь буюу 72.2 мянган тонн, хүнсний ногоо 47.8 хувь буюу 30.5 мянган тонноор тус тус өссөн байна. Хураасан үр тарианы хэмжээ "Атрын II аян" хэрэгжүүлсний дараагийн жил буюу 1979 оныхоос үр тариа 123.0 мянган тонн, төмс 91.6 мянган тонн, хүнсний ногоо 67.6 мянган тонноор нэмэгджээ (Хүснэгт 66).

ХҮСНЭГТ 66. УРГАЦ ХУРААЛТ, сонгосон онуудаар

| | 1962 | 1979 | 2003-2007 оны дундаж | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2016 / 2003-2007 оны дундаж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | мянган тонн | | | | | | | | хувь | зөрүү |
| Үр тариа | 326.5 | 360.5 | 126.5 | 479.3 | 387.0 | 518.8 | 216.3 | 483.5 | 382.2 | 357.0 |
| Төмс | 23.9 | 73.7 | 93.1 | 245.9 | 191.6 | 161.5 | 163.8 | 165.3 | 177.6 | 72.2 |
| Хүнсний ногоо | 13.3 | 26.8 | 63.9 | 98.9 | 101.8 | 104.8 | 72.3 | 94.4 | 147.8 | 30.5 |

2016 онд 483.5 мянган тонн үр тариа, 165.3 мянган тонн төмс, 94.4 мянган тонн хүнсний ногоо хураан авч өмнөх оны мөн үеийнхээс үр тариа 267.2 мянган тонн буюу 123.5 хувиар, төмс 1.5 мянган тонн буюу 0.9 хувиар, хүнсний ногоо 22.1 мянган тонн буюу 30.6 хувиар өссөн байна (Хүснэгт 66).

Аж ахуйн нэгж байгууллага 2016 онд үр тарианы 94.1 хувь, төмсний 28.0 хувь, хүнсний ногооны 18.6 хувь, тэжээлийн ургамлын 55.7 хувийг тус тус хураасан бол иргэд, өрхийн аж ахуй үр тарианы 5.9 хувь, төмсний 72.0 хувь, хүнсний ногооны 81.4 хувь, тэжээлийн ургамлын 44.3 хувийг тус тус хураасан байна (Хүснэгт 67).

ХҮСНЭГТ 67. ХУРААСАН УРГАЦ, 2016 ОН, аж ахуйн төрлөөр

| | Үр тариа | Төмс | Хүнсний ногоо | Тэжээлийн ургамал | Үр тариа | Төмс | Хүнсний ногоо | Тэжээлийн ургамал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | мянган тонн | | | | дүнд эзлэх хувь | | | |
| **Бүгд** | **483.5** | **165.3** | **94.4** | **53.4** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** |
| ААНБ | 454.8 | 46.3 | 17.6 | 29.7 | 94.1 | 28.0 | 18.6 | 55.7 |
| Өрх | 28.7 | 119.1 | 76.8 | 23.7 | 5.9 | 72.0 | 81.4 | 44.3 |

2016 онд үр тариа хураалтын хэмжээ Баян-Өлгий, Хэнтий, Сүхбаатар, Завхан, Баянхонгор, Дорнод аймгуудад 1.6-53.0 хувиар буурч, Говь-Алтай, Ховд, Булган аймгуудад 10.6-85.5 хувиар, Өвөрхангай, Хөвсгөл, Увс, Төв, Архангай, Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул аймгуудад 2.1-4.8 дахин өссөн байна (Хавсралт хүснэгт 59).

ХХААХҮЯ-ны мэдээгээр Төвийн болон Хангайн бүсэд буудайн "Орхон", "Дархан-34", "Дархан-74", "Бурятская-34", "Бурятская-79", "Халх гол-1" сортыг, Баруун бүсэд

“Халх гол-1”, “Цагаан дэглий” сортыг, Зүүн бүсэд “Халх гол-1”, “Дархан-74” сортыг зөвлөмж болгосны дагуу голлон тариалж байна.

Улаан буудай хураалтын 2016 онд хэмжээ Төв, Булган, Хөвсгөл, Сүхбаатар, Архангай, Говь-Алтай, Өвөрхангай, Орхон аймгуудад 0.2-45.2 хувиар өсөж, Дорнод, Сэлэнгэ, Хэнтий, Увс, Дархан-Уул, Завхан, Ховд аймгуудад 0.7-84.4 хувиар буурсан (Хавсралт хүснэгт 59).

Төмс хураалтын хэмжээ Улаанбаатар хот болон Архангай, Баян-Өлгий, Говь-Алтай, Булган, Ховд, Дорноговь, Хэнтий, Төв, Өмнөговь, Сүхбаатар аймгуудад 0.2-14.4 хувиар буурч, Баянхонгор, Өвөрхангай, Дундговь, Сэлэнгэ, Увс, Хөвсгөл, Завхан, Орхон, Дорнод, Говьсүмбэр аймгуудад 4.7-97.8 хувиар, Дархан-Уул аймагт 2.5 дахин өссөн байна (Хавсралт хүснэгт 59).

Хүнсний ногооны хураалт Хэнтий, Өмнөговь, Архангай, Дорноговь, Дорнод, Булган аймгуудад 2.6-19.0 хувиар буурч, Улаанбаатар хот болон бусад аймагт 1.2-54.6 хувиар, Дархан-Уул аймагт 3.0 дахин өссөн байна (Хавсралт хүснэгт 59).

Хадлан бэлтгэл Улаанбаатар хот болон Дархан-Уул, Дорнод, Говьсүмбэр, Ховд, Өвөрхангай, Баян-Өлгий, Сэлэнгэ, Булган, Архангай, Орхон, Увс, Өмнөговь, Дорноговь, Хөвсгөл, Завхан, Төв аймгуудад 0.5-82.5 хувиар, Баянхонгор, Сүхбаатар аймгуудад 2.4-2.5 дахин, Хэнтий, Говь-Алтай, Дундговь аймгуудад 2.6-13.9 хувиар буурчээ (Хавсралт хүснэгт 59).

Жимс, жимсгэнэ хураалтын хэмжээ Баян-Өлгий, Дорнод, Баянхонгор, Завхан, Өвөрхангай, Хэнтий, Архангай, Ховд аймгуудад 14.3-98.2 хувиар, Сүхбаатар, Сэлэнгэ, Булган, Дархан-Уул, Орхон аймгуудад 2.0-6.0 дахин өсөж, Улаанбаатар хот болон Увс, Говь-Алтай, Өмнөговь, Төв аймгуудад 0.5-62.6 хувиар буурчээ (Хавсралт хүснэгт 59).

***Ургац хураалтад нөлөөлсөн хүчин зүйл.*** Үр тарианы тариалсан талбайн хэмжээ 2016 онд өмнөх оныхоос буурч, га-гаас хураасан ургац 2.3 дахин өссөн. Харин төмсний тариалсан талбайн хэмжээ өссөн ч га-аас авсан ургацын хэмжээ буурсан байна. Хураан авсан үр тарианы ургацын хэмжээнд нөлөөлсөн тариалсан талбайн болон га-гийн ургацын хүчин зүйлийн нөлөөллийг авч үзье (Хүснэгт 68).

Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн мэдээгээр сүүлийн таван жилийн байдлаар 7-9 дүгээр сард орсон хур тунадасны дундаж хэмжээ Төвийн бүсийн аймгуудад 17.8-63.1 мм, Хангайн бүсийн аймгуудад 42.5-90.0 мм, Баруун бүсийн аймгуудад 20.1-45.7 мм, Зүүн бүсийн аймгуудад 49.2-54.2 мм байв.

ХҮСНЭГТ 68. 2016 ОНЫ УРГАЦ ХУРААЛТЫГ 2015 ОНЫХТОЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

| | Нийт өсөлт, бууралт | | Га-гийн ургац | | Тариалсан талбайн | |
|---|---|---|---|---|---|---|
| | хувь | зөрүү(мянган тонн) | хувь | зөрүү(мянган тонн) | хувь | зөрүү(мянган тонн) |
| Үр тариа | 223.5 | 267.2 | 231.2 | 7.3 | -3.3 | -12.9 |
| Улаан буудай | 229.1 | 263.2 | 233.0 | 7.5 | 98.3 | -6.1 |
| Төмс | 1.0 | 1.6 | -13.7 | -17.5 | 17.0 | 2.2 |

Үр тарианы ургац хураалтын 50.6 хувийг Сэлэнгэ аймаг, 17.7 хувийг Төв аймаг, 11.1 хувийг Булган аймагт тус тус хураан авчээ. Төмсний ургацын 39.1 хувь нь Төв аймагт, 25.7 хувь нь Сэлэнгэ аймагт, 5.7 хувь нь Ховд аймагт, хүнсний ногооны ургацын 34.6 хувь нь Сэлэнгэ аймагт, 15.2 хувь нь Дархан-Уул аймагт, 9.6 хувь нь Ховд аймагт ногдож байна.

ХҮСНЭГТ 69. ӨРХИЙН ХУРААСАН УРГАЦ, бүс, нийслэлээр, ургамлын төрлөөр

| Бүс | 2014 | | | | 2015 | | | | 2016 | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Үр тариа | Төмс | Хүнсний ногоо | Тэжээлийн ургамал | Үр тариа | Төмс | Хүнсний ногоо | Тэжээлийн ургамал | Үр тариа | Төмс | Хүнсний ногоо | Тэжээлийн ургамал |
| | мянган тонн | | | | | | | | | | | |
| **Бүгд** | **43.3** | **113.8** | **87.6** | **19.0** | **12.1** | **117.9** | **57.6** | **19.9** | **28.7** | **119.1** | **76.8** | **23.7** |
| Баруун | 3.2 | 15.1 | 17.6 | 6.3 | 1.6 | 16.3 | 13.1 | 7.1 | 3.4 | 16.4 | 14.5 | 10.4 |
| Хангайн | 9.8 | 19.0 | 13.0 | 3.4 | 4.3 | 15.9 | 10.5 | 3.0 | 9.3 | 17.2 | 11.4 | 4.2 |
| Төвийн | 29.9 | 72.7 | 51.4 | 7.0 | 5.7 | 79.8 | 29.5 | 5.8 | 15.7 | 79.1 | 44.7 | 7.5 |
| Зүүн | 0.4 | 5.5 | 3.8 | 0.0 | 0.6 | 3.8 | 2.8 | 0.0 | 0.4 | 4.0 | 2.5 | - |
| Улаанбаатар | - | 1.5 | 1.9 | 2.4 | - | 2.0 | 1.7 | 4.0 | - | 2.4 | 3.8 | 1.6 |

Улсын хэмжээнд өрхийн хураасан төмс 2015 онд 3.6 хувиар, тэжээлийн ургамал 4.7 хувиар өсөж, үр тариа 72.0 хувиар, хүнсний ногоо 34.2 буурч байсан бол, 2016 онд төмс 1.0 хувиар, тэжээлийн ургамал 19.1 хувиар, хүнсний ногоо 33.3 хувиар, үр тариа 2.4 дахин өссөн байна (Хүснэгт 69).

ЗУРАГ 24. ӨРХИЙН ХУРААСАН УРГАЦ, ургамлын төрлөөр




***Газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлт***. Монгол Улсын ГЕГ, ҮСХ-ны албан ёсны статистик мэдээлэлд үндэслэн газар тариалангийн гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийг тооцож үзэхэд 2016 онд улсын хэмжээгээр 625.5 мянган тонн улаан буудай, 166.0 мянган тонн төмс, 164.6 мянган тонн хүнсний ногоо зах зээлд нийлүүлэгдсэнээс улаан буудайн 74.7 хувь, төмсний 99.6 хувь, хүнсний ногооны 57.4 хувийг дотоодын үйлдвэрлэлээр, үлдсэн хувийг импортоор хангасан байна (Хүснэгт 70).

Хүнсний ногооны нөөцөд дотоодын үйлдвэрлэлийн хувийн жин 1.0 пунктээр өссөн байна.

ХҮСНЭГТ 70. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, НИЙЛҮҮЛЭЛТ

| | Нийт нийлүүлэлт = дотоодын үйлдвэрлэл+импорт | | | | | Дотоодын үйлдвэрлэл | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
| | мянган тонн | | | | | | | | | |
| Улаан буудай | 469.4 | 368.6 | 522.5 | 225.0 | 625.5 | 465.3 | 368.5 | 488.3 | 203.9 | 467.1 |
| Төмс | 249.1 | 191.7 | 166.9 | 180.8 | 166.0 | 245.9 | 191.6 | 161.5 | 163.8 | 165.3 |
| Хүнсний ногоо | 180.1 | 173.1 | 175.1 | 126.3 | 163.2 | 98.9 | 101.8 | 104.8 | 72.3 | 94.4 |

Хүснэгт 70-ын үргэлжлэл

| | Импорт | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
| | мянган тонн | | | | |
| Улаан буудай | 4.1 | 0.1 | 34.2 | 21.1 | 158.5 |
| Төмс | 3.2 | 0.0 | 5.4 | 17.1 | 0.7 |
| Хүнсний ногоо | 81.1 | 71.4 | 71.3 | 54.8 | 69.4 |

ГЕГ-ын статистик мэдээгээр манай улс 2016 онд 69.4 мянган тонн хүнсний ногоо импортоор оруулсан нь өмнөх оныхоос 14.6 мянган тонноор өссөн байна (Хүснэгт 71).

ХҮСНЭГТ 71. ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ НИЙТ НИЙЛҮҮЛЭЛТЭД, ИМПОРТЫГ ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛД ХАРЬЦУУЛСАН ХАРЬЦАА

| | Дотоодын үйлдвэрлэл/Нийт нийлүүлэлт | | | | | Импорт/Дотоодын үйлдвэрлэл | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
| | Хувь | | | | | | | | | |
| Улаан буудай | 99.1 | 100.0 | 93.4 | 90.6 | 74.7 | 0.9 | - | 7.0 | 10.3 | 33.9 |
| Төмс | 98.7 | 100.0 | 96.8 | 90.6 | 99.6 | 1.3 | - | 3.3 | 10.4 | 0.4 |
| Хүнсний ногоо | 180.1 | 173.1 | 176.1 | 127.2 | 163.9 | 82.0 | 70.1 | 68.0 | 75.8 | 73.5 |

### III.3 Га-гийн ургац

Нэг га-гаас дунджаар 2016 онд 12.8 центнер үр тариа, үүнээс 13.2 центнер буудай, 9.4 центнер арвай, 10.6 центнер овьёос, 110.0 центнер төмс, 17.9 тэжээлийн ургамал, 3.2 техникийн ургамал хураан авсан бөгөөд нэг га-гаас авсан үр тариа 7.3 центнерээр, улаан буудай 7.6 центнерээр, овьёос 8.0 центнерээр, техникийн ургамал 0.5 центнерээр өсөж, төмс 17.5 центнерээр, тэжээлийн ургамал 2.7 центнерээр буурсан байна (Хүснэгт 72).

ХҮСНЭГТ 72. ГА-ГИЙН УРГАЦ, ургамлын төрлөөр

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
|---|---|---|---|---|---|
| | центнер | | | | |
| Үр тариа | 15.7 | 13.2 | 16.5 | 5.5 | 12.8 |
| Улаан буудай | 15.6 | 13.4 | 16.8 | 5.6 | 13.2 |
| Арвай | 15.4 | 13.6 | 12.3 | 3.8 | 9.4 |
| Овьёос | 18.0 | 13.4 | 17.9 | 2.6 | 10.6 |
| Төмс | 146.2 | 123.6 | 122.3 | 127.5 | 110.0 |
| Тэжээлийн ургамал | 33.5 | 29.6 | 26.1 | 20.6 | 17.9 |
| Техникийн ургамал | 6.3 | 5.0 | 6.0 | 2.7 | 3.2 |

Манай улсын түүхэнд 1985 онд хамгийн их буюу 886.2 мянган тонн үр тариа хурааж байх үед га-гаас 13.9 центнер үр тариа авч байсан дээд үзүүлэлт 2014 онд 16.5 центнер болж шинэчлэгдсэн бол 2016 онд га-гаас авсан ургацын хэмжээ 12.8 центнер болж буурсан байна (Хүснэгт 73).

ХҮСНЭГТ 73. ХУРААСАН УРГАЦ, ТАРИАЛСАН ТАЛБАЙ, ГА-ГИЙН УРГАЦЫН ДЭЭД ХЭМЖЭЭ, ургамлын төрлөөр

| | Хураасан ургац | | Тариалсан талбай | | Га-гийн ургац | |
|---|---|---|---|---|---|---|
| | он | мянган тонн | он | мянган га | он | центнер |
| Үр тариа | 1985 | 886.2 | 1989 | 673.4 | 2014 | 16.5 |
| Буудай | 1985 | 688.5 | 1990 | 532.9 | 2014 | 16.8 |
| Төмс | 2012 | 245.9 | 2012 | 16.8 | 2012 | 146.2 |
| Хүнсний ногоо | 2014 | 104.8 | 2016 | 9.1 | - | - |
| Тэжээлийн ургамал | 1987 | 607.9 | 1988 | 169.5 | - | - |
| Хадлан | 1958 | 1 781.0 | - | - | - | - |

Нэг га-гаас 2016 онд хураан авсан үр тариаг өмнөх онтой харьцуулбал Баян-Өлгий, Завхан, Өвөрхангай, Төв, Булган, Хөвсгөл, Архангай, Увс, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон аймгуудад 0.3-20.0 центнерээр өсөж, Ховд, Сүхбаатар, Баянхонгор, Говь-Алтай, Дорнод аймгуудад 0.2-4.0 центнерээр буурсан байна (Хавсралт хүснэгт 57).

Нэг га-гаас хураан авсан хүнсний ногоо Баруун бүсэд 5.5 центнер, Хангайн бүсэд 6.5 центнер, Төвийн бүсэд 16.2 центнерээр өсөж, Зүүн бүсэд 47.2 центнерээр буурсан байна. Харин га-аас хураан авсан төмс Баруун бүсэд 2.5 центнер, Хангайн бүсэд 1.2 центнерээр өсөж, Зүүн бүсэд 5.3 центнер, Улаанбаатар хотод 7.6 центнер, Төвийн бүсэд 27.9 центнерээр буурсан байна (Хавсралт хүснэгт 57).

ХҮСНЭГТ 74. ГА-ГААС ХУРААСАН ҮР ТАРИА, ТӨМСНИЙ УРГАЦ, аж ахуйн төрлөөр

| | Үр тариа | | | | | Төмс | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
| | Центнер | | | | | | | | | |
| Нийт | 15.7 | 13.2 | 16.5 | 5.5 | 12.8 | 146.4 | 123.6 | 122.3 | 127.5 | 110.0 |
| ААНБ | 16.0 | 13.4 | 16.7 | 5.7 | 12.9 | 133.7 | 131.9 | 151.0 | 139.0 | 113.8 |
| Өрх | 12.9 | 11.3 | 14.3 | 3.5 | 11.2 | 153.2 | 120.5 | 113.3 | 123.6 | 108.6 |

Аж ахуйн нэгж, байгууллагын нэг га-аас хураасан үр тариа 2016 онд 12.9 болж өмнөх оны мөн үеийнхээс 125.5 хувь буюу 7.2 центнер, өрхийн нэг га-аас хураасан үр тариа 3.2 дахин буюу 7.7 центнерээр өссөн байна. Харин аж ахуйн нэгж, байгууллагын нэг га-аас хураасан төмс 2016 онд 113.8 болж өмнөх оны мөн үеэс 18.1 хувиар буюу 25.1 центнер, өрхийн нэг га-аас хураасан төмс 108.6 центнер болж өмнөх оны мөн үеэс 12.1 хувиар буюу 15.0 центнерээр буурсан байна (Хүснэгт 74).

## III.4 Хөдөө аж ахуйн эдэлбэр газар

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын мэдээгээр 2016 онд хөдөө аж ахуйн эдэлбэр газрын хэмжээ 114931.1 мянган га болж өмнөх онтой харьцуулахад 51.7 мянган га-гаар буурсан байна.

Хөдөө аж ахуйн эдэлбэр газрын 96.1 хувийг бэлчээрийн талбай, 1.5 хувийг хадлангийн талбай, 0.9 хувийг тариалангийн талбай, 1.5 хувийг бусад газар эзэлж байна (Хүснэгт 75).

ХҮСНЭГТ 75. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЭДЭЛБЭР ГАЗАР

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2016/2015 |
|---|---|---|---|---|---|---|
| | мянган га | | | | | хувь |
| **Хөдөө аж ахуйн газар** | **115 399.9** | **115 361.4** | **115 008.6** | **114 982.8** | **114 931.1** | **100.0** |
| Бэлчээрийн газар | 111 032.5 | 111 026.2 | 110 646.7 | 110 613.6 | 110 490.0 | 99.9 |
| Хадлангийн талбай | 1 712.3 | 1 712.3 | 1 717.6 | 1 717.7 | 1 742.4 | 101.4 |
| Тариалангийн газар | 1 031.1 | 986.8 | 1 012.8 | 1 028.2 | 1 067.7 | 103.8 |
| Атаршсан газар | 292.0 | 305.0 | 305.0 | 305.0 | 260.6 | 85.5 |
| Хөдөө аж ахуйн барилга, байгууламжийн дэвсгэр | 70.3 | 71.4 | 76.8 | 74.4 | 110.6 | 148.8 |
| Бусад | 1 261.6 | 1 259.7 | 1 259.7 | 1 259.7 | 1 259.7 | 100.0 |

## ДҮГНЭЛТ

2016 онд малтай 223.8 мянган өрх байгаагийн 160.7 мянга нь малчин өрх байна. Мал аж ахуйн салбарт нийт 311.4 мянган малчид ажиллаж байна.

Мал тооллогын 2016 оны жилийн эцсийн дүнгээр малын тоо толгой 61.5 саяд хүрч, өмнөх оныхоос 5.6 сая буюу 9.9 хувиар өслөө. Өмнөх оныхоос өссөн малын тоо толгойн 86.8 хувийг бог мал, 6.6 хувийг үхэр, 5.9 хувийг адуу, 0.7 хувийг тэмээ эзэлж байна.

Нийт малын 89.0 хувь буюу 54.8 сая нь малчин өрхийн эзэмшилд байгаа бөгөөд нэг малчин өрхөд дунджаар 341 толгой мал, үүний дотор тэмээ 2, адуу 20, үхэр 21, хонь 156, ямаа 142 ногдож байна.

2016 оны мал тооллогоор нийт малчин өрхийн 86.1 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 73.9 хувь нь телевизортой, 39.9 хувь нь автомашинтай, 44.9 хувь нь мотоциклтой, 3.5 хувь нь трактортой байна.

Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр, зэрэгцүүлэх үнээр 2618.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхтой харьцуулахад 1.5 хувиар буурлаа. 2016 онд нядалгааны жингээр 400.0 мянган тонн мах, 891.5 мянган тонн сүү, 27.4 мянган тонн хонины ноос, 9.4 мянган тонн ноолуур, 1.7 мянган тонн тэмээний ноос, 14.0 сая ширхэг арьс, шир үйлдвэрлэсэн нь өмнөх оныхоос махны үйлдвэрлэл, нядалгааны жингээр 48.3 мянган тонн, арьс, шир 1.2 сая ширхгээр буурч, хонины ноос 1.6 мянган тонн, ноолуур 0.6 мянган тонн, сүүний үйлдвэрлэл 17.1 мянган литр, тэмээний ноос 91.1 тонноор нэмэгдсэн байна.

Бэлтгэсэн махны 2.3 хувь, сүүний 8.0 хувьтай тэнцэх хэмжээний бүтээгдэхүүнийг үйлдвэрийн аргаар боловсруулжээ. Тэрчлэн нийт үйлдвэрлэсэн хонины ноосны 24.0 хувьтай тэнцэх угаасан ноос, ноолуурын 8.3 хувьтай тэнцэх самнасан ноолуурыг үйлдвэрийн аргаар бэлтгэсэн байна. Мөн улсын хэмжээнд бэлтгэсэн үхрийн ширний 35.3 хувь, хонины арьсны 7.4 хувь, ямааны арьсны 10.4 хувийг дотоодын үйлдвэрт боловсруулжээ.

2016 онд бэлтгэсэн хонины ноосны 59.7 хувь буюу 16.4 мянган тонн, бэлтгэсэн ямааны ноолуурын 57.3 хувь буюу 5.4 мянган тонн бохир ноолуур, адууны ширний 31.4 хувь буюу 110.9 мянган ширхгийг боловсруулалт хийлгүйгээр экспортод гаргажээ.

Мах, сүүн бүтээгдэхүүнийг орон нутагт үндсэндээ гар аргаар боловсруулсан хэвээр байгаа бөгөөд харин арьс, шир, ноос, ноолуурын маш багахан хувийг дотоодын үйлдвэрт боловсруулж, ихэнх хэсэг нь нэмэгдсэн өртөг шингээгүй, боловсруулалт хийлгүйгээр угаасан, самнасан байдлаар гадаад зах зээлд гаргаж байна. Иймд бүс нутгийн тулгуур төв болон шаардлагатай газруудад нь мал аж ахуйн түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх, хагас боловсруулсан бүтээгдэхүүн, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрүүдийг барьж байгуулах нь хүлээгдэж байгаа зорилт хэвээр байна.

Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлд гарч байгаа өсөлт нь малын тооноос хамаарч байгаа бөгөөд цаашид нэг малын ашиг шим, чанарын үзүүлэлтэд анхаарлаа хандуулж, энэ чиглэлээр тодорхой арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх шаардлага хэвээр байна. Ялангуяа газар тариалангийн бүс нутагт ашиг шим өндөртэй мал өсгөж үржүүлэх үүднээс, малын тоо толгойг газар тариалангийн үйлдвэрлэлтэй зөв харьцаатай хөгжүүлэх, малыг чанаржуулахад чиглэсэн үржлийн бодлогыг эрчимтэй явуулах, малчдын хөдөлмөрийг хоршуулах, бэлчээрийг усжуулахад чиглэсэн арга хэмжээ ихээхэн чухал байна.

Манай улсын бэлчээрийн нөөц өнгөрсөн 50 гаруй жилийн хугацаанд 9.8 сая га-гаар багассан байхад хонин толгойд шилжүүлсэн малын тоо 54.1 сая толгойгоор өсжээ. Нөгөөтэйгүүр, бэлчээр маань жилээс жилд урдаасаа хойшоогоо чиглэсэн цөлжилтөд автагдан, өвс ургамлын бүтэц, гарц нь хомсодсоор байна. Бэлчээрт сөргөөр бодитой нөлөөлж байгаа бас нэг зүйл бол ус, худагтай газар хэт олон айл, мал улирал дамжин бөөгнөрөн нутаглаж, бэлчээрийг талхлан доройтуулж байгаа явдал юм.

Бэлчээрийг сэлгэн ашиглах, отор нүүдлийг зайлшгүй хийдэг болгох хөшүүрэг бүхий механизмыг малчдын дунд бий болгох шаардлагатай байна.

Бэлчээрийн доройтол нь малын тоо толгойг хязгаартай байлгахыг шаардаж байна. Ялангуяа бэлчээрт халтай ямаан сүргийн тоо толгойг хязгаарлах, бог малын хувьд өсгөж үржүүлж ирсэн уламжлалт харьцаа 75:25 хувь буюу 3 хонь, 1 ямаа гэсэн харьцаагаар өсгөж үржүүлэхэд татварын бодлогоор зохицуулах нь зүйтэй.

Манай улс 2016 онд 505.3 мянган га талбайд тариалалт хийж, 483.5 мянган тонн үр тариа, 165.3 мянган тонн төмс, 94.4 мянган тонн хүнсний ногоо, 53.4 мянган тонн тэжээлийн ургамал хурааж, 1275.4 мянган тонн өвс хадлан бэлтгэсэн нь 2015 оныхоос үр тариа 2.2 дахин, хүнсний ногоо 30.5 хувь, өвс хадлан 24.0 хувь, төмс 1.0 хувь, тэжээлийн ургамал 8.7 хувиар өссөн байна.

Газар тариалангийн салбарын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр, зэрэгцүүлэх үнээр 396.8 тэрбум төгрөгт хүрч, 2015 оныхоос 33.3 хувиар өслөө.

2016 онд газар тариалангийн салбарын нийт үйлдвэрлэлт, хураасан ургацын хэмжээ өсөж, үр тариа, төмсний дотоодын хэрэгцээг бүрэн хангаж байгаа бөгөөд цаашид экспортын бүтээгдэхүүний эх сурвалж болгох нь ихээхэн ач холбогдолтой юм. Үүнийг амжилттай хэрэгжүүлэх, нөгөөтэйгүүр малын тэжээлийн найдвартай нөөц бүрдүүлэхэд усалгаатай газар тариаланг хөгжүүлэх явдлыг шинэ шатанд гаргах шаардлагатай байна.

Манай орны гол мөрний усны нөөцийн 60 хувь нь гадагшаа гардаг гэсэн судалгаа байдаг. Ийм онцлог нөхцөлийг харгалзан үзвэл хаврын цасны ус, зуны борооны үерийн усны нөөцийн тодорхой хэсгийг далан хаалт байгуулж усан санд хуримтлуулах замаар газар тариалан, мал аж ахуйд ашиглах нь хуурай уур амьсгалтай манай орны хувьд зайлшгүй хийгдэх ажил болж байна.

Хамгийн гол асуудал бол орон нутагт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг хадгалах, боловсруулах, борлуулах чиглэлээр жижиг, дунд үйлдвэрүүдийг байгуулах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг бэлтгэх төвлөрсөн цэгүүд, хадгалах, хөргөх агуулах, зоорийг бий болгох, сэргээх нь чухал байна.

**ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО**

# ХАВСРАЛТ

ХҮСНЭГТ 1. **МАЛТАЙ ӨРХ, МАЛЧИН ӨРХИЙН ТОО, бүс, аймаг, нийслэлээр**

| Бүс, аймаг, нийслэл | Малтай өрхийн тоо | | | | | Малчин өрхийн тоо | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
| **Бүгд** | **207 818** | **209 933** | **213 363** | **216 734** | **223 761** | **146 081** | **145 311** | **149 735** | **153 085** | **160 650** |
| **Баруун** | **57 560** | **58 455** | **59 513** | **59 886** | **62 019** | **38 557** | **37 741** | **38 521** | **38 967** | **40 593** |
| Баян-Өлгий | 13 520 | 14 104 | 14 636 | 14 608 | 14 961 | 8 383 | 8 392 | 8 921 | 8 872 | 8 888 |
| Говь-Алтай | 9 264 | 9 396 | 9 428 | 9 602 | 9 932 | 6 644 | 6 537 | 6 436 | 6 658 | 6 903 |
| Завхан | 11 759 | 11 886 | 11 983 | 12 176 | 12 931 | 8 033 | 7 764 | 7 978 | 8 258 | 8 807 |
| Увс | 12 186 | 12 035 | 12 179 | 12 142 | 12 569 | 8 072 | 8 005 | 8 027 | 7 991 | 8 588 |
| Ховд | 10 831 | 11 034 | 11 287 | 11 358 | 11 626 | 7 425 | 7 043 | 7 159 | 7 188 | 7 407 |
| **Хангай** | **77 475** | **77 809** | **78 330** | **79 395** | **81 614** | **60 368** | **59 908** | **61 674** | **63 007** | **65 393** |
| Архангай | 17 255 | 17 148 | 17 219 | 17 362 | 17 797 | 13 692 | 13 709 | 13 858 | 14 126 | 14 436 |
| Баянхонгор | 13 174 | 13 302 | 13 424 | 13 644 | 14 162 | 10 453 | 10 356 | 10 614 | 10 607 | 11 171 |
| Булган | 9 524 | 9 738 | 10 089 | 10 337 | 10 614 | 7 173 | 7 333 | 7 870 | 8 057 | 8 301 |
| Орхон | 1 355 | 1 321 | 1 039 | 1 081 | 1 130 | 896 | 920 | 717 | 765 | 811 |
| Өвөрхангай | 17 272 | 17 595 | 17 752 | 17 959 | 18 520 | 13 603 | 13 570 | 14 115 | 14 658 | 15 407 |
| Хөвсгөл | 18 895 | 18 705 | 18 807 | 19 012 | 19 391 | 14 551 | 14 020 | 14 500 | 14 794 | 15 267 |
| **Төв** | **44 117** | **44 854** | **45 959** | **47 011** | **48 415** | **29 153** | **29 638** | **30 784** | **32 054** | **33 993** |
| Говьсүмбэр | 798 | 872 | 950 | 994 | 1 055 | 528 | 563 | 640 | 673 | 721 |
| Дархан-уул | 2 412 | 2 476 | 2 475 | 2 408 | 2 501 | 941 | 1 020 | 1 166 | 1 100 | 1 193 |
| Дорноговь | 4 593 | 4 716 | 4 824 | 5 020 | 5 141 | 3 552 | 3 685 | 3 777 | 3 988 | 4 137 |
| Дундговь | 6 946 | 7 071 | 7 280 | 7 516 | 7 947 | 5 743 | 5 699 | 5 880 | 6 181 | 6 590 |
| Өмнөговь | 6 619 | 6 713 | 6 771 | 6 963 | 7 172 | 5 131 | 5 173 | 5 216 | 5 417 | 5 647 |
| Сэлэнгэ | 8 968 | 8 987 | 9 270 | 9 406 | 9 565 | 4 056 | 4 051 | 4 125 | 4 193 | 4 427 |
| Төв | 13 781 | 14 019 | 14 389 | 14 704 | 15 034 | 9 202 | 9 447 | 9 980 | 10 502 | 11 278 |
| **Зүүн** | **23 739** | **23 988** | **24 575** | **25 307** | **26 443** | **16 434** | **16 560** | **17 050** | **17 805** | **18 943** |
| Дорнод | 5 819 | 5 911 | 6 124 | 6 342 | 6 641 | 3 744 | 3 738 | 3 910 | 4 043 | 4 398 |
| Сүхбаатар | 9 209 | 9 162 | 9 314 | 9 492 | 9 852 | 6 530 | 6 466 | 6 552 | 6 858 | 7 256 |
| Хэнтий | 8 711 | 8 915 | 9 137 | 9 473 | 9 950 | 6 160 | 6 356 | 6 588 | 6 904 | 7 289 |
| **Улаанбаатар** | **4 927** | **4 827** | **4 986** | **5 135** | **5 270** | **1 569** | **1 464** | **1 706** | **1 252** | **1 728** |

ХҮСНЭГТ 2. **МАЛЧДЫН ТОО, бүс, аймаг, нийслэлээр**

| Бүс, аймаг, нийслэл | Малчдын тоо | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 16-34 настай | эр 35-59, эм 35-54 настай | эр 60, эм 55-аас дээш насны | Нийт малчдаас эмэгтэй |
| **Бүгд** | **289 646** | **285 691** | **293 620** | **297 828** | **311 373** | **108 265** | **172 252** | **30 856** | **143 749** |
| **Баруун** | **79 150** | **77 137** | **78 351** | **79 220** | **82 239** | **28 508** | **45 686** | **8 045** | **38 738** |
| Баян-Өлгий | 17 808 | 17 723 | 18 302 | 18 398 | 18 411 | 6 927 | 9 884 | 1 600 | 8 712 |
| Говь-Алтай | 13 311 | 13 118 | 12 949 | 13 294 | 13 691 | 4 634 | 7 741 | 1 316 | 6 451 |
| Завхан | 15 990 | 15 386 | 15 762 | 16 081 | 16 960 | 5 084 | 9 818 | 2 058 | 8 023 |
| Увс | 16 540 | 16 263 | 16 218 | 16 215 | 17 498 | 6 405 | 9 407 | 1 686 | 8 261 |
| Ховд | 15 501 | 14 647 | 15 120 | 15 232 | 15 679 | 5 458 | 8 836 | 1 385 | 7 291 |
| **Хангай** | **119 514** | **117 555** | **121 149** | **123 056** | **127 687** | **46 728** | **68 936** | **12 023** | **59 886** |
| Архангай | 26 145 | 26 151 | 26 591 | 26 915 | 27 474 | 9 873 | 15 021 | 2 580 | 12 849 |
| Баянхонгор | 20 917 | 20 574 | 20 962 | 21 062 | 21 990 | 9 314 | 11 071 | 1 605 | 10 278 |
| Булган | 13 861 | 13 942 | 14 853 | 15 200 | 15 579 | 4 273 | 9 613 | 1 693 | 7 103 |
| Орхон | 1 665 | 1 740 | 1 290 | 1 364 | 1 496 | 288 | 940 | 268 | 710 |
| Өвөрхангай | 26 687 | 26 254 | 27 580 | 28 446 | 29 993 | 11 087 | 15 757 | 3 149 | 14 083 |
| Хөвсгөл | 30 239 | 28 894 | 29 873 | 30 069 | 31 155 | 11 893 | 16 534 | 2 728 | 14 863 |
| **Төв** | **55 098** | **55 287** | **57 348** | **58 759** | **61 722** | **19 106** | **35 222** | **7 394** | **27 655** |
| Говьсүмбэр | 931 | 983 | 1 122 | 1 160 | 1 231 | 338 | 740 | 153 | 558 |
| Дархан-уул | 1 837 | 1 972 | 2 223 | 2 108 | 2 279 | 604 | 1 390 | 285 | 1 050 |
| Дорноговь | 6 858 | 6 950 | 7 086 | 7 221 | 7 477 | 2 649 | 3 955 | 873 | 3 257 |
| Дундговь | 11 185 | 10 938 | 11 214 | 11 633 | 12 171 | 3 948 | 6 748 | 1 475 | 5 485 |
| Өмнөговь | 9 279 | 9 226 | 9 449 | 9 588 | 9 846 | 3 408 | 5 353 | 1 085 | 4 503 |
| Сэлэнгэ | 7 741 | 7 710 | 7 952 | 8 051 | 8 522 | 2 563 | 5 075 | 884 | 3 888 |
| Төв | 17 267 | 17 508 | 18 302 | 18 998 | 20 196 | 5 596 | 11 961 | 2 639 | 8 914 |
| **Зүүн** | **32 935** | **32 914** | **33 685** | **34 483** | **36 547** | **13 362** | **20 247** | **2 938** | **16 020** |
| Дорнод | 7 360 | 7 377 | 7 604 | 7 681 | 8 471 | 3 050 | 4 601 | 820 | 3 659 |
| Сүхбаатар | 13 988 | 13 742 | 13 868 | 14 288 | 14 835 | 5 889 | 8 123 | 823 | 6 582 |
| Хэнтий | 11 587 | 11 795 | 12 213 | 12 514 | 13 241 | 4 423 | 7 523 | 1 295 | 5 779 |
| **Улаанбаатар** | **2 949** | **2 798** | **3 087** | **2 310** | **3 178** | **561** | **2 161** | **456** | **1 450** |

ХҮСНЭГТ 3. **МАЛЧДЫН СОЁЛ, АХУЙН НӨХЦӨЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ, бүс, аймаг, нийслэлээр, 2016 онд**

| Бүс, аймаг, нийслэл | Малчин өрхийн тоо | Сум, дүүргийн тоо | Баг, хорооны тоо | Цахилгаан үүсгүүртэй өрхийн тоо | | | | Телевизортой өрхийн тоо | Авто машинтай | | Мотоциклтой | | Трактортой | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Нарны | Салхины | Бусад | | Өрхийн тоо | Машины тоо | Өрхийн тоо | Мотоциклийн тоо | Өрхийн тоо | Тракторын тоо |
| **Бүгд** | **160 650** | **339** | **1 765** | **138 343** | **130 419** | **768** | **8 776** | **118 699** | **64 074** | **74 162** | **72 057** | **73 063** | **5 575** | **5 834** |
| **Баруун** | **40 593** | **91** | **476** | **34 118** | **33 388** | **19** | **786** | **27 915** | **16 924** | **18 689** | **19 992** | **20 228** | **676** | **696** |
| Баян-Өлгий | 8 888 | 13 | 90 | 5 928 | 5 780 | 9 | 174 | 3 401 | 2 526 | 2 855 | 2 775 | 2 788 | 43 | 43 |
| Говь-Алтай | 6 903 | 18 | 87 | 6 128 | 6 079 | 6 | 53 | 5 311 | 3 212 | 3 507 | 4 094 | 4 166 | 37 | 37 |
| Завхан | 8 807 | 24 | 115 | 7 896 | 7 832 | 2 | 89 | 7 451 | 4 639 | 5 124 | 4 999 | 5 035 | 114 | 117 |
| Увс | 8 588 | 19 | 93 | 7 399 | 7 046 | 2 | 354 | 5 872 | 2 762 | 2 997 | 4 142 | 4 163 | 149 | 157 |
| Ховд | 7 407 | 17 | 91 | 6 767 | 6 651 | - | 116 | 5 880 | 3 785 | 4 206 | 3 982 | 4 076 | 333 | 342 |
| **Хангай** | **65 393** | **99** | **539** | **56 543** | **54 402** | **124** | **2 308** | **48 099** | **20 916** | **23 551** | **30 216** | **30 676** | **1 505** | **1 518** |
| Архангай | 14 436 | 19 | 101 | 12 882 | 12 580 | 59 | 379 | 10 760 | 5 501 | 6 258 | 6 629 | 6 823 | 171 | 174 |
| Баянхонгор | 11 171 | 20 | 104 | 9 709 | 9 701 | 7 | 15 | 8 453 | 3 890 | 4 210 | 6 380 | 6 492 | 42 | 42 |
| Булган | 8 301 | 16 | 75 | 7 244 | 6 853 | 7 | 441 | 5 990 | 3 164 | 3 752 | 3 207 | 3 224 | 573 | 580 |
| Орхон | 811 | 2 | 25 | 901 | 471 | - | 430 | 848 | 295 | 348 | 179 | 183 | 36 | 36 |
| Өвөрхангай | 15 407 | 19 | 109 | 12 737 | 12 146 | 21 | 619 | 10 685 | 4 178 | 4 626 | 7 365 | 7 448 | 60 | 61 |
| Хөвсгөл | 15 267 | 23 | 125 | 13 070 | 12 651 | 30 | 424 | 11 363 | 3 888 | 4 357 | 6 456 | 6 506 | 623 | 625 |
| **Төв** | **33 993** | **95** | **377** | **29 816** | **26 442** | **335** | **3 980** | **26 902** | **17 154** | **20 914** | **14 160** | **14 411** | **2 310** | **2 489** |
| Говьсүмбэр | 721 | 3 | 10 | 619 | 583 | 6 | 32 | 481 | 43 | 48 | 30 | 30 | 12 | 15 |
| Дархан-уул | 1 193 | 4 | 26 | 1 162 | 832 | 3 | 336 | 1 029 | 862 | 1 112 | 363 | 370 | 348 | 374 |
| Дорноговь | 4 137 | 14 | 64 | 3 405 | 3 139 | 99 | 373 | 2 947 | 1 877 | 2 259 | 2 120 | 2 176 | 18 | 19 |
| Дундговь | 6 590 | 15 | 66 | 5 422 | 5 136 | 14 | 318 | 4 889 | 2 559 | 2 900 | 2 975 | 3 008 | 20 | 20 |
| Өмнөговь | 5 647 | 15 | 58 | 4 614 | 4 448 | 188 | 576 | 4 126 | 2 449 | 2 901 | 2 638 | 2 721 | 24 | 25 |
| Сэлэнгэ | 4 427 | 17 | 56 | 4 192 | 3 689 | 4 | 540 | 3 890 | 3 849 | 4 912 | 1 631 | 1 649 | 1 049 | 1 110 |
| Төв | 11 278 | 27 | 97 | 10 402 | 8 615 | 21 | 1 805 | 9 540 | 5 515 | 6 782 | 4 403 | 4 457 | 839 | 926 |
| **Зүүн** | **18 943** | **45** | **221** | **16 400** | **15 545** | **221** | **931** | **14 625** | **7 956** | **9 542** | **7 358** | **7 409** | **1 024** | **1 069** |
| Дорнод | 4 398 | 14 | 66 | 3 643 | 3 166 | 130 | 437 | 3 268 | 1 612 | 1 921 | 1 257 | 1 270 | 372 | 388 |
| Сүхбаатар | 7 256 | 13 | 67 | 6 466 | 6 370 | 47 | 92 | 5 857 | 3 328 | 3 963 | 3 797 | 3 819 | 34 | 43 |
| Хэнтий | 7 289 | 18 | 88 | 6 291 | 6 009 | 44 | 402 | 5 500 | 3 016 | 3 658 | 2 304 | 2 320 | 618 | 638 |
| **Улаанбаатар** | **1 728** | **9** | **152** | **1 466** | **642** | **69** | **771** | **1 158** | **1 124** | **1 466** | **331** | **339** | **60** | **62** |

Хүснэгт 3-ын үргэлжлэл

| Бүс, аймаг, нийслэл | Хийсэн эсгий /м/ | Малын хашаатай өрхийн тоо | Худагтай өрхийн тоо | Малчин өрхийн тоонд харьцуулснаар | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Цахилгаан гэрэлтэй | | Телевизортой | | Машинтай | | Мотоциклтой | | Трактортой | | Малын хашаатай өрх | Худагтай өрх |
| | | | | 2015 | 2016 | 2015 | 2016 | 2015 | 2016 | 2015 | 2016 | 2015 | 2016 | | |
| | | | | хувь | | | | | | | | | | | |
| **Бүгд** | **36 427** | **141 188** | **42 323** | **88.3** | **86.1** | **77.3** | **73.9** | **41.3** | **39.9** | **49.4** | **44.9** | **3.7** | **3.5** | **87.9** | **26.3** |
| **Баруун** | **21 923** | **33 945** | **8 652** | **88.7** | **84.0** | **72.7** | **68.8** | **43.1** | **41.7** | **54.6** | **49.2** | **1.6** | **1.7** | **83.6** | **21.3** |
| Баян-Өлгий | 7 880 | 11 742 | 3 691 | 82.2 | 66.7 | 49.1 | 38.3 | 35.5 | 28.4 | 39.2 | 31.2 | 0.5 | 0.5 | 132.1 | 41.5 |
| Говь-Алтай | 121 | 4 473 | 1 500 | 90.4 | 88.8 | 76.5 | 76.9 | 43.4 | 46.5 | 60.7 | 59.3 | 0.5 | 0.5 | 64.8 | 21.7 |
| Завхан | 1 199 | 4 685 | 514 | 91.4 | 89.7 | 85.7 | 84.6 | 53.2 | 52.7 | 62.0 | 56.8 | 1.3 | 1.3 | 53.2 | 5.8 |
| Увс | 6 175 | 6 457 | 662 | 89.4 | 86.2 | 73.9 | 68.4 | 32.6 | 32.2 | 53.9 | 48.2 | 1.4 | 1.7 | 75.2 | 7.7 |
| Ховд | 6 548 | 6 588 | 2 285 | 91.4 | 91.4 | 82.1 | 79.4 | 52.3 | 51.1 | 60.3 | 53.8 | 4.7 | 4.5 | 88.9 | 30.8 |
| **Хангай** | **10 815** | **54 290** | **8 514** | **87.5** | **86.5** | **76.2** | **73.6** | **33.3** | **32.0** | **50.4** | **46.2** | **2.4** | **2.3** | **83.0** | **13.0** |
| Архангай | 116 | 13 484 | 682 | 91.2 | 89.2 | 75.6 | 74.5 | 36.6 | 38.1 | 42.9 | 45.9 | 1.2 | 1.2 | 93.4 | 4.7 |
| Баянхонгор | 1 566 | 6 236 | 2 153 | 88.8 | 86.9 | 80.3 | 75.7 | 36.4 | 34.8 | 66.8 | 57.1 | 0.4 | 0.4 | 55.8 | 19.3 |
| Булган | 323 | 8 161 | 1 420 | 92.2 | 87.3 | 84.0 | 72.2 | 42.2 | 38.1 | 44.6 | 38.6 | 7.7 | 6.9 | 98.3 | 17.1 |
| Орхон | - | 1 093 | 113 | 100.0 | 111.1 | 94.5 | 104.6 | 43.3 | 36.4 | 31.8 | 22.1 | 7.2 | 4.4 | 134.8 | 13.9 |
| Өвөрхангай | 5 079 | 11 571 | 2 489 | 84.7 | 82.7 | 73.1 | 69.4 | 29.3 | 27.1 | 52.1 | 47.8 | 0.4 | 0.4 | 75.1 | 16.2 |
| Хөвсгөл | 3 731 | 13 745 | 1 657 | 82.5 | 85.6 | 71.8 | 74.4 | 26.4 | 25.5 | 48.4 | 42.3 | 3.7 | 4.1 | 90.0 | 10.9 |
| **Төв** | **3 536** | **34 252** | **15 271** | **88.9** | **87.7** | **82.0** | **79.1** | **53.2** | **50.5** | **46.4** | **41.7** | **7.3** | **6.8** | **100.8** | **44.9** |
| Говьсүмбэр | 7 | 507 | 274 | 82.3 | 85.9 | 75.3 | 66.7 | 8.0 | 6.0 | 4.3 | 4.2 | 4.2 | 1.7 | 70.3 | 38.0 |
| Дархан-уул | 14 | 2 451 | 749 | 96.9 | 97.4 | 91.0 | 86.3 | 72.3 | 72.3 | 29.0 | 30.4 | 30.6 | 29.2 | 205.4 | 62.8 |
| Дорноговь | 171 | 3 022 | 2292 | 82.5 | 82.3 | 74.2 | 71.2 | 48.8 | 45.4 | 54.1 | 51.2 | 0.4 | 0.4 | 73.0 | 55.4 |
| Дундговь | 787 | 4 401 | 2790 | 83.1 | 82.3 | 75.7 | 74.2 | 43.5 | 38.8 | 56.1 | 45.1 | 0.3 | 0.3 | 66.8 | 42.3 |
| Өмнөговь | 2 041 | 4 038 | 3477 | 85.9 | 81.7 | 78.8 | 73.1 | 47.6 | 43.4 | 48.4 | 46.7 | 0.4 | 0.4 | 71.5 | 61.6 |
| Сэлэнгэ | 112 | 8 221 | 3589 | 95.5 | 94.7 | 87.6 | 87.9 | 82.7 | 86.9 | 40.4 | 36.8 | 22.4 | 23.7 | 185.7 | 81.1 |
| Төв | 404 | 11 612 | 2100 | 93.1 | 92.2 | 87.6 | 84.6 | 52.7 | 48.9 | 43.6 | 39.0 | 9.3 | 7.4 | 103.0 | 18.6 |
| **Зүүн** | **144** | **13 883** | **8 003** | **87.8** | **86.6** | **81.6** | **77.2** | **43.6** | **42.0** | **42.2** | **38.8** | **6.6** | **5.4** | **73.3** | **42.2** |
| Дорнод | 30 | 4674 | 3403 | 90.3 | 82.8 | 83.1 | 74.3 | 38.2 | 36.7 | 34.4 | 28.6 | 10.8 | 8.5 | 106.3 | 77.4 |
| Сүхбаатар | 34 | 2493 | 2418 | 91.4 | 89.1 | 83.9 | 80.7 | 43.6 | 45.9 | 49.5 | 52.3 | 0.7 | 0.5 | 34.4 | 33.3 |
| Хэнтий | 80 | 6716 | 2182 | 82.7 | 86.3 | 78.5 | 75.5 | 46.9 | 41.4 | 39.5 | 31.6 | 9.9 | 8.5 | 92.1 | 29.9 |
| **Улаанбаатар** | **9** | **4 818** | **1 883** | **104.6** | **84.8** | **91.5** | **67.0** | **50.3** | **65.0** | **18.1** | **19.2** | **3.4** | **3.5** | **278.8** | **109.0** |

ХҮСНЭГТ 4. **МАЛТАЙ ӨРХИЙН ТОО, малын тооны бүлэглэлтээр, бүс, аймаг, нийслэлээр**

| Бүс, аймаг, нийслэл | Бүгд | | | | | 11 хүртэл малтай | | | | | 11-30 малтай | | | | | 31-50 малтай | | | | | 51-100 малтай | | | | | 101-200 малтай | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
| **Бүгд** | **207 818** | **209 933** | **213 363** | **216 734** | **223 761** | **16 827** | **16 712** | **14 980** | **14 226** | **14 176** | **23 449** | **22 528** | **20 343** | **19 933** | **19 611** | **17 792** | **17 088** | **15 770** | **15 478** | **15 323** | **32 902** | **31 432** | **29 392** | **29 266** | **29 075** | **48 474** | **47 005** | **46 847** | **46 250** | **45 870** |
| **Баруун** | **57 560** | **58 455** | **59 513** | **59 886** | **62 019** | **3 934** | **4 295** | **3 890** | **3 749** | **3 947** | **6 649** | **6 345** | **5 435** | **5 090** | **5 191** | **5 478** | **5 278** | **4 797** | **4 583** | **4 525** | **10 266** | **9 673** | **9 188** | **8 793** | **8 668** | **15 205** | **14 695** | **15 041** | **14 616** | **14 656** |
| Баян-Өлгий | 13 520 | 14 104 | 14 636 | 14 608 | 14 961 | 1 712 | 2 037 | 2 019 | 2 006 | 2 045 | 2 056 | 2 156 | 1 767 | 1 706 | 1 743 | 1 585 | 1 487 | 1 433 | 1 370 | 1 326 | 2 805 | 2 494 | 2 563 | 2 375 | 2 309 | 3 640 | 3 681 | 3 988 | 3 939 | 4 013 |
| Говь-Алтай | 9 264 | 9 396 | 9 428 | 9 602 | 9 932 | 193 | 199 | 134 | 144 | 121 | 765 | 668 | 571 | 498 | 424 | 752 | 736 | 630 | 562 | 521 | 1 526 | 1 394 | 1 265 | 1 268 | 1 081 | 2 558 | 2 362 | 2 255 | 2 114 | 2 027 |
| Завхан | 11 759 | 11 886 | 11 983 | 12 176 | 12 931 | 539 | 544 | 441 | 417 | 498 | 1 181 | 1 089 | 968 | 889 | 1 050 | 1 090 | 1 051 | 970 | 944 | 987 | 2 147 | 1 987 | 1 871 | 1 909 | 1 993 | 2 975 | 2 998 | 2 903 | 2 854 | 2 930 |
| Увс | 12 186 | 12 035 | 12 179 | 12 142 | 12 569 | 883 | 854 | 734 | 679 | 775 | 1 490 | 1 326 | 1 173 | 1 123 | 1 191 | 1 138 | 1 026 | 940 | 952 | 1 006 | 1 991 | 1 929 | 1 789 | 1 686 | 1 812 | 3 216 | 3 051 | 3 116 | 2 962 | 3 041 |
| Ховд | 10 831 | 11 034 | 11 287 | 11 358 | 11 626 | 607 | 661 | 562 | 503 | 508 | 1 157 | 1 106 | 956 | 874 | 783 | 913 | 978 | 824 | 755 | 685 | 1 797 | 1 869 | 1 700 | 1 555 | 1 473 | 2 816 | 2 603 | 2 779 | 2 747 | 2 645 |
| **Хангай** | **77 475** | **77 809** | **78 330** | **79 395** | **81 614** | **3 677** | **3 622** | **3 044** | **2 759** | **2 638** | **7 565** | **7 201** | **6 155** | **6 008** | **5 577** | **6 446** | **6 122** | **5 517** | **5 370** | **5 233** | **13 020** | **12 321** | **11 055** | **11 105** | **10 586** | **20 223** | **19 382** | **19 047** | **18 888** | **18 119** |
| Архангай | 17 255 | 17 148 | 17 219 | 17 362 | 17 797 | 784 | 772 | 616 | 523 | 560 | 1 737 | 1 564 | 1 379 | 1 297 | 1 266 | 1 463 | 1 260 | 1 135 | 1 139 | 1 085 | 2 998 | 2 670 | 2 369 | 2 376 | 2 291 | 4 527 | 4 407 | 4 270 | 4 407 | 4 182 |
| Баянхонгор | 13 174 | 13 302 | 13 424 | 13 644 | 14 162 | 292 | 265 | 212 | 184 | 189 | 1 069 | 941 | 750 | 721 | 680 | 1 021 | 997 | 819 | 781 | 829 | 2 271 | 2 189 | 1 929 | 1 842 | 1 829 | 3 713 | 3 431 | 3 306 | 3 264 | 3 106 |
| Булган | 9 524 | 9 738 | 10 089 | 10 337 | 10 614 | 479 | 469 | 437 | 387 | 364 | 704 | 756 | 712 | 713 | 711 | 582 | 614 | 592 | 597 | 617 | 1 321 | 1 320 | 1 213 | 1 312 | 1 264 | 2 169 | 2 071 | 2 084 | 2 150 | 2 070 |
| Орхон | 1 355 | 1 321 | 1 039 | 1 081 | 1 130 | 272 | 274 | 258 | 260 | 246 | 204 | 220 | 192 | 251 | 259 | 113 | 120 | 93 | 100 | 111 | 182 | 181 | 128 | 143 | 146 | 259 | 227 | 168 | 136 | 151 |
| Өвөрхангай | 17 272 | 17 595 | 17 752 | 17 959 | 18 520 | 680 | 616 | 459 | 397 | 359 | 1 986 | 1 821 | 1 436 | 1 349 | 1 144 | 1 739 | 1 598 | 1 438 | 1 349 | 1 282 | 3 198 | 3 016 | 2 713 | 2 631 | 2 506 | 4 692 | 4 534 | 4 635 | 4 536 | 4 311 |
| Хөвсгөл | 18 895 | 18 705 | 18 807 | 19 012 | 19 391 | 1 170 | 1 226 | 1 062 | 1 008 | 920 | 1 865 | 1 899 | 1 686 | 1 677 | 1 517 | 1 528 | 1 528 | 1 440 | 1 404 | 1 309 | 3 050 | 2 945 | 2 703 | 2 801 | 2 550 | 4 863 | 4 712 | 4 584 | 4 395 | 4 299 |
| **Төв** | **44 117** | **44 854** | **45 959** | **47 011** | **48 415** | **5 417** | **5 240** | **4 775** | **4 713** | **4 661** | **5 383** | **5 195** | **5 119** | **5 178** | **5 121** | **3 522** | **3 391** | **3 222** | **3 247** | **3 240** | **5 762** | **5 631** | **5 390** | **5 625** | **5 719** | **8 072** | **7 978** | **7 766** | **7 614** | **7 745** |
| Говьсүмбэр | 798 | 872 | 950 | 994 | 1 055 | 34 | 28 | 23 | 23 | 26 | 93 | 93 | 86 | 79 | 80 | 75 | 79 | 79 | 69 | 62 | 101 | 120 | 116 | 136 | 138 | 139 | 144 | 148 | 157 | 167 |
| Дархан-уул | 2 412 | 2 476 | 2 475 | 2 408 | 2 501 | 863 | 871 | 749 | 726 | 740 | 474 | 472 | 512 | 483 | 463 | 168 | 191 | 165 | 213 | 220 | 231 | 234 | 244 | 284 | 290 | 253 | 283 | 282 | 256 | 281 |
| Дорноговь | 4 597 | 4 716 | 4 824 | 5 020 | 5 141 | 132 | 122 | 96 | 106 | 121 | 324 | 303 | 289 | 293 | 331 | 295 | 295 | 291 | 295 | 300 | 587 | 552 | 520 | 615 | 653 | 946 | 935 | 933 | 899 | 973 |
| Дундговь | 6 942 | 7 071 | 7 280 | 7 516 | 7 947 | 172 | 140 | 90 | 62 | 64 | 630 | 499 | 365 | 319 | 313 | 597 | 568 | 449 | 378 | 414 | 1 067 | 969 | 915 | 878 | 813 | 1 586 | 1 581 | 1 493 | 1 507 | 1 565 |
| Өмнөговь | 6 618 | 6 712 | 6 771 | 6 963 | 7 172 | 146 | 141 | 140 | 140 | 105 | 585 | 498 | 494 | 468 | 445 | 582 | 551 | 526 | 510 | 469 | 1 075 | 995 | 904 | 944 | 983 | 1 562 | 1 479 | 1 361 | 1 299 | 1 271 |
| Сэлэнгэ | 8 968 | 8 987 | 9 270 | 9 406 | 9 565 | 2 464 | 2 380 | 2 321 | 2 264 | 2 178 | 1 566 | 1 616 | 1 669 | 1 819 | 1 820 | 713 | 665 | 697 | 746 | 774 | 945 | 1 078 | 1 046 | 1 085 | 1 104 | 1 169 | 1 183 | 1 242 | 1 228 | 1 237 |
| Төв | 13 781 | 14 019 | 14 389 | 14 704 | 15 034 | 1 606 | 1 558 | 1 356 | 1 392 | 1 427 | 1 711 | 1 714 | 1 704 | 1 717 | 1 669 | 1 092 | 1 042 | 1 015 | 1 036 | 1 001 | 1 756 | 1 683 | 1 645 | 1 683 | 1 738 | 2 417 | 2 373 | 2 307 | 2 268 | 2 251 |
| **Зүүн** | **23 739** | **23 988** | **24 575** | **25 307** | **26 443** | **1 820** | **1 750** | **1 581** | **1 385** | **1 293** | **2 596** | **2 511** | **2 306** | **2 224** | **2 235** | **1 884** | **1 828** | **1 727** | **1 706** | **1 776** | **3 411** | **3 324** | **3 227** | **3 190** | **3 515** | **4 586** | **4 593** | **4 594** | **4 722** | **4 932** |
| Дорнод | 5 819 | 5 911 | 6 124 | 6 342 | 6 641 | 742 | 762 | 728 | 665 | 572 | 850 | 854 | 833 | 812 | 834 | 520 | 514 | 524 | 513 | 541 | 872 | 913 | 884 | 902 | 995 | 1 037 | 1 079 | 1 127 | 1 201 | 1 212 |
| Сүхбаатар | 9 209 | 9 162 | 9 314 | 9 492 | 9 852 | 533 | 473 | 409 | 330 | 348 | 835 | 782 | 685 | 680 | 726 | 673 | 637 | 581 | 595 | 665 | 1 363 | 1 243 | 1 182 | 1 143 | 1 377 | 1 991 | 1 920 | 1 927 | 1 848 | 1 939 |
| Хэнтий | 8 711 | 8 915 | 9 137 | 9 473 | 9 950 | 545 | 515 | 444 | 390 | 373 | 911 | 875 | 788 | 732 | 675 | 691 | 677 | 622 | 598 | 570 | 1 176 | 1 168 | 1 161 | 1 145 | 1 143 | 1 558 | 1 594 | 1 540 | 1 673 | 1 781 |
| **Улаанбаатар** | **4 927** | **4 827** | **4 986** | **5 135** | **5 270** | **1 979** | **1 805** | **1 690** | **1 620** | **1 637** | **1 256** | **1 276** | **1 328** | **1 433** | **1 487** | **462** | **469** | **507** | **572** | **549** | **443** | **483** | **532** | **553** | **587** | **388** | **357** | **399** | **410** | **418** |

Хүснэгт 4-ийн үргэлжлэл

| Бүс, аймаг, нийслэл | 201-500 малтай | | | | | 501-999 малтай | | | | | 1000-1499 малтай | | | | | 1500-2000 малтай | | | | | 2001-ээс дээш малтай | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
| **Бүгд** | **50 468** | **53 143** | **58 131** | **60 075** | **63 120** | **14 276** | **17 123** | **21 092** | **23 070** | **26 632** | **3 046** | **4 076** | **5 620** | **6 950** | **8 144** | **385** | **566** | **816** | **993** | **1 203** | **199** | **260** | **372** | **493** | **607** |
| **Баруун** | **12 836** | **13 853** | **15 523** | **16 261** | **16 941** | **2 623** | **3 421** | **4 342** | **5 068** | **5 936** | **481** | **774** | **1 117** | **1 494** | **1 841** | **57** | **80** | **129** | **169** | **222** | **31** | **41** | **51** | **63** | **92** |
| Баян-Өлгий | 1 554 | 1 993 | 2 524 | 2 760 | 2 980 | 131 | 198 | 268 | 370 | 448 | 20 | 37 | 46 | 44 | 57 | 8 | 12 | 14 | 25 | 18 | 9 | 9 | 14 | 13 | 22 |
| Говь-Алтай | 2 754 | 2 981 | 3 176 | 3 262 | 3 415 | 624 | 876 | 1 131 | 1 334 | 1 697 | 81 | 164 | 231 | 357 | 540 | 7 | 12 | 29 | 49 | 78 | 4 | 4 | 6 | 14 | 28 |
| Завхан | 2 943 | 3 064 | 3 362 | 3 478 | 3 556 | 679 | 852 | 1 046 | 1 159 | 1 320 | 175 | 265 | 368 | 471 | 525 | 20 | 20 | 38 | 38 | 55 | 10 | 16 | 16 | 17 | 17 |
| Увс | 2 813 | 2 981 | 3 281 | 3 398 | 3 363 | 553 | 715 | 913 | 1 038 | 1 057 | 95 | 144 | 215 | 281 | 305 | 5 | 8 | 16 | 20 | 15 | 2 | 1 | 2 | 3 | 4 |
| Ховд | 2 772 | 2 834 | 3 180 | 3 363 | 3 627 | 636 | 780 | 984 | 1 167 | 1 414 | 110 | 164 | 257 | 341 | 414 | 17 | 28 | 32 | 37 | 56 | 6 | 11 | 13 | 16 | 21 |
| **Хангай** | **20 412** | **21 638** | **23 763** | **24 500** | **26 135** | **5 011** | **6 045** | **7 642** | **8 121** | **9 927** | **974** | **1 266** | **1 790** | **2 279** | **2 906** | **99** | **153** | **229** | **249** | **347** | **48** | **59** | **88** | **116** | **146** |
| Архангай | 4 386 | 4 789 | 5 318 | 5 387 | 5 616 | 1 068 | 1 319 | 1 638 | 1 634 | 2 025 | 246 | 300 | 405 | 500 | 643 | 32 | 46 | 58 | 62 | 86 | 14 | 21 | 31 | 37 | 43 |
| Баянхонгор | 3 927 | 4 213 | 4 708 | 4 861 | 5 100 | 717 | 1 039 | 1 362 | 1 549 | 1 816 | 138 | 201 | 295 | 395 | 541 | 18 | 19 | 31 | 31 | 52 | 8 | 7 | 12 | 16 | 20 |
| Булган | 2 756 | 2 807 | 3 057 | 3 138 | 3 296 | 1 205 | 1 311 | 1 497 | 1 503 | 1 697 | 268 | 333 | 411 | 452 | 495 | 27 | 44 | 66 | 65 | 74 | 13 | 13 | 20 | 20 | 26 |
| Орхон | 276 | 243 | 164 | 155 | 170 | 43 | 50 | 34 | 34 | 42 | 5 | 5 | 2 | 2 | 5 | 1 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | - | 0 |
| Өвөрхангай | 4 045 | 4 675 | 5 206 | 5 455 | 6 107 | 755 | 1 034 | 1 408 | 1 622 | 2 027 | 156 | 257 | 382 | 520 | 641 | 12 | 28 | 55 | 68 | 101 | 9 | 16 | 20 | 32 | 42 |
| Хөвсгөл | 5 022 | 4 911 | 5 310 | 5 504 | 5 846 | 1 223 | 1 292 | 1 703 | 1 779 | 2 320 | 161 | 170 | 295 | 410 | 581 | 9 | 15 | 19 | 23 | 34 | 4 | 2 | 5 | 11 | 15 |
| **Төв** | **10 944** | **11 259** | **11 950** | **12 072** | **12 510** | **4 014** | **4 764** | **5 742** | **6 128** | **6 724** | **865** | **1 181** | **1 653** | **1 981** | **2 188** | **92** | **147** | **247** | **310** | **337** | **46** | **68** | **95** | **143** | **170** |
| Говьсүмбэр | 212 | 227 | 278 | 266 | 313 | 107 | 126 | 139 | 169 | 179 | 31 | 39 | 61 | 68 | 68 | 4 | 10 | 11 | 13 | 11 | 2 | 6 | 9 | 14 | 11 |
| Дархан-уул | 302 | 295 | 365 | 305 | 344 | 95 | 108 | 124 | 119 | 131 | 26 | 22 | 32 | 21 | 31 | 0 | 0 | 2 | 1 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Дорноговь | 1 524 | 1 538 | 1 549 | 1 567 | 1 569 | 627 | 744 | 848 | 907 | 880 | 141 | 204 | 242 | 276 | 263 | 12 | 15 | 46 | 45 | 38 | 9 | 8 | 10 | 17 | 13 |
| Дундговь | 2 047 | 2 129 | 2 396 | 2 494 | 2 635 | 682 | 916 | 1 153 | 1 350 | 1 538 | 139 | 217 | 343 | 412 | 462 | 17 | 35 | 49 | 79 | 91 | 5 | 17 | 27 | 37 | 52 |
| Өмнөговь | 2 104 | 2 244 | 2 285 | 2 338 | 2 343 | 497 | 665 | 871 | 970 | 1 179 | 66 | 129 | 176 | 269 | 337 | 1 | 10 | 10 | 20 | 31 | 1 | 1 | 4 | 5 | 9 |
| Сэлэнгэ | 1 442 | 1 391 | 1 478 | 1 464 | 1 564 | 579 | 572 | 676 | 650 | 699 | 75 | 84 | 122 | 135 | 160 | 12 | 12 | 13 | 11 | 22 | 3 | 6 | 6 | 4 | 7 |
| Төв | 3 313 | 3 435 | 3 599 | 3 638 | 3 742 | 1 427 | 1 633 | 1 931 | 1 963 | 2 118 | 387 | 486 | 677 | 800 | 867 | 46 | 65 | 116 | 141 | 143 | 26 | 30 | 39 | 66 | 78 |
